



БОЛОВСРОЛ,
СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН,
СПОРТЫН ЯАМ

СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР, ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗӨВЛӨМЖ

2019 он

Азийн Хөгжлийн Банкны “Эдийн засгийн хүндрэлийн үед боловсролын чанар, хүртээмжийг сайжруулах төсөл”-ийн хүрээнд хэвлүүлэв.



**МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛ,
СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН
САЙДЫН ТУШААЛ**

2019 оны 08 сарын 02 өдөр

Дугаар А/494

Улаанбаатар хот

Хөтөлбөр батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг, Боловсролын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.2 дахь заалт, Сургуулийн өмнөх боловсролын тухай хуулийн 9.5 дахь хэсэг, Төрөөс боловсролын талаар баримтлах бодлогын 4.8 дахь хэсэг, “Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө батлах тухай” 2016 оны 121 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Сургуулийн өмнөх боловсролын сайжруулсан сургалтын хөтөлбөрийг нэгдүгээр, хүүхдийн хөгжлийн үнэлгээний хуудсыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Сургуулийн өмнөх боловсролын сайжруулсан сургалтын хөтөлбөрийг 2019-2020 оны хичээлийн жилээс эхлэн өмчийн хэлбэр харгалзахгүй нийт цэцэрлэгийн сургалтад хэрэгжүүлсүгэй.

3. Тус хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг нэгдсэн удирдлагаар хангаж ажиллахыг Сургуулийн өмнөх боловсролын бодлогын газар /Ж.Мягмар/, хөтөлбөрийг хэрэгжүүлэх мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэхийг Боловсролын хүрээлэн /П.Лхагвасүрэн/, Багшийн мэргэжил дээшлүүлэх институт /Ж.Болормаа/, хөтөлбөрийг чанартай хэрэгжүүлэхэд мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэхийг аймаг, нийслэлийн Боловсролын газрын дарга нарт тус тус даалгасугай.

4. Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын “Сургуулийн өмнөх боловсролын сургалтын цөм хөтөлбөр батлах тухай” 2015 оны А/301 дүгээр тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

САЙД



Е.БААТАРБИЛЭГ

0901571

АГУУЛГА

НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ	5
НЭГ. СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨРИЙН ЗАРЧИМ	6
ХОЁР. СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛГО, ЗОРИЛТ	6
ГУРАВ. СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨРИЙН АГУУЛГА	7
ДӨРӨВ. СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ЗҮЙ.....	7
ТАВ. СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ СУРГАЛТЫН ОРЧИН.....	8
ЗУРГАА. ХҮҮХДИЙН ХӨГЖЛИЙН ҮНЭЛГЭЭ	9
ДОЛОО. СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ	10
НАЙМ. БАГШ, ЭЦЭГ ЭХ, АСРАН ХАМГААЛАГЧИЙН ДЭМЖЛЭГ, ОРОЛЦОО.....	11
НИЙГЭМШИХҮЙН ХӨГЖИЛ.....	13
ХӨДӨЛГӨӨН, ЭРҮҮЛ МЭНД.....	17
ХЭЛ ЯРИА.....	21
БАЙГАЛЬ, НИЙГМИЙН ОРЧИН.....	25
МАТЕМАТИК	29
ХӨГЖИМ, ДҮРСЛЭХ УРЛАГ	33



Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2019 оны 08 дугаар сарын 02 өдрийн А/494 дугаар тушаалын нээдүгээр хавсралт

НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

Монгол Улсын Боловсролын тухай хуульд “Монгол улсын боловсролын зорилго нь иргэнийг оюун ухаан, ёс суртахуун, бие бялдрын зохих чадавхтай, хүмүүнлэг ёсыг дээдлэн сахидаг, бие даан сурах, ажиллах, амьдрах чадвартай болгон төлөвшүүлэхэд оршино”, Сургуулийн Өмнөх Боловсролын тухай хуульд “Сургуулийн өмнөх боловсролын зорилго нь бага насны хүүхдийг өөрийн онцлог, чадвар, бүтээлч үйлээрээ хөгжин, насан туршийн боловсролын суурь чадварыг эзэмшихэд дэмжин асрах, хамгаалах, хөгжүүлэх, сургалт, үйл ажиллагаагаар сургуулийн өмнөх боловсрол эзэмшүүлэхэд оршино” гэж тус тус заасан.

Монгол Улсын Их Хурлаас баталсан “Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого”-ын 3.2-т Сургуулийн өмнөх боловсролыг “хүүхдийг сургах, сургуульд бэлтгэх” гэсэн зорилгоос илүүтэйгээр хүний хөгжлийн үндэс, өөрийн онцлог, чадвар, бүтээлч үйлээрээ хөгжих, насан туршийн боловсролын суурь үе хэмээн хөгжүүлнэ” гэж, Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2013 оны 327 тоот тушаалаар баталсан “Сургуулийн өмнөх боловсролын сургалтын талаар баримтлах бодлого”-ын Нийтлэг үндэслэлд “Сургуулийн өмнөх боловсролын сургалтын талаар баримтлах бодлого нь хурдацтайгаар өөрчлөгдөн байгаа нээлттэй, өрсөлдөөнтэй, мэдээлэлжсэн нийгэмд зохицон амьдрах чадвартай хүүхдийг бага наснаас нь хөгжүүлэхэд өөрийн орны уламжлал, онцлогт түшиглэн олон улсын чиг хандлагатай нийцүүлж, эцэг эх, багш, судлаач, олон нийтийн оролцоог ханган хамтран ажиллах зарчимд тулгуурлана”, “Сургалтын хөтөлбөрийн зорилго, агуулга, арга зүй, хэрэглэгдэхүүн, үнэлгээ нь хүүхдийн хөгжлийн ахиц, амжилтын үр дүнд чиглэсэн, нээлттэй байна. Цэцэрлэг сургалтын хөтөлбөрөө байгууллагынхаа үзэл баримтлалыг үндэслэн боловсруулна” хэмээн тус тус заасны дагуу энэхүү сургалтын сайжруулсан хөтөлбөрийг боловсруулсан болно.

Бага насны хүүхдийн талаарх судалгааны ажил дэлхий нийтэд эрчимжиж, хүүхдийн хөгжлийн онцлог, боломжийн талаар шинэ нотолгоо, мэдлэг, мэдээлэл бий болсоор байна. Тухайлбал, сургуулийн өмнөх насанд хүүхдийн тархи маш эрчимтэй хөгждөг бөгөөд уян хатан чанартай, суралцах орчин, түүнчлэн ойр дотны харилцаа нь тэдний хөгжил, төлөвшилд чухлаар нөлөөлдөг, хүүхэд боловсролын нэг түвшнээс нөгөө түвшинд (цэцэрлэгээс сургуульд) шилжих шилжилтийг зөв хийх нь тэдний суралцах үйлд эерэг нөлөө үзүүлж, насан туршийн амьдралын суурь болдог гэдгийг эрдэмтэн, судлаачид баталж байна.

Мэдлэгт суурилсан нийгэм, мэдээлэл, харилцааны технологийн хурдацтай хөгжлийн энэ эрин үед хүүхдийг бага наснаас нь янз бүрийн мэдлэг эзэмшүүлэх гэхээс илүүтэй тэдний төрөлхийн суралцах хүсэл эрмэлзэл, дур сонирхолд тулгуурлан, тэдэнд орчинтойгоо идэвхтэй харьцаж, өөрөө судлан шинжилж учир холбогдлыг нь олж нээх боломж олгох, бие даан аливаа үйлийг гүйцэтгэх чадвартай болоход нь дэмжлэг туслалцаа үзүүлэхэд түлхүү анхаарах шаардлагатай байна.

Монголчууд үр хүүхдээ сайн хүн болгон төлөвшүүлэх уламжлалт сэтгэлгээ, ёс заншилтай ард түмэн. Эцэг эхчүүд хүүхдэдээ багаас нь эрдэнэт хүний биеийн үнэ цэнэ, нүгэл буян, үйлийн үрийн сургаал, бусдыг энэрэн нигүүлсэх, хайрлан халамжлах, байгаль дэлхийтэйгээ зөв харьцах арга ухаан, эцэг эх, ахмадыг хүндэтгэх, ач тусыг нь санахыг

ухааруулан, сургасаар ирсэн. Энэхүү уламжлалт арга ухаанаа эрхэмлэн хүүхэд бүрийн ХҮН БОЛОХ төлөвшилд илүү анхаарах нь өнөөгийн нийгэм, хөгжлийн хэрэгцээ, шаардлага болоод байна.

“Сургуулийн өмнөх боловсролын сургалтын цөм хөтөлбөр” 2015 оноос манай улсын нийт цэцэрлэгт хэрэгжиж эхэлсэн бөгөөд 2019 оны 3 дугаар сард БСШУСЯ-аас сургалтын цөм хөтөлбөрт хийсэн үндэсний хэлэлцүүлэг болон хөтөлбөрийн хэрэгжилтийн судалгаанд үндэслэн уг хөтөлбөрийг сайжруулан гаргаж байна.

Энэхүү сургалтын хөтөлбөр нь орон нутаг, цэцэрлэгийн онцлог, давуу тал, судалгааны шинэ ололт, багш нарын бүтээлч үйлээр баяжигдах бөгөөд багш нараас гадна сургуульд элсэх хүртэлх насны хүүхэдтэй эцэг эхчүүдийн хувьд хүүхдээ хөгжүүлж төлөвшүүлэхэд нь чиглүүлэг болно.

НЭГ. СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨРИЙН ЗАРЧИМ

1. Сургалтын хөтөлбөрийн зорилго, зорилт нь хүүхдийн нас, сэтгэхүй, хөгжлийн онцлогийг харгалзсан байх;
2. Агуулга нь өргөсөн гүнзгийрэх ба залгамж холбоотой, хүүхдийн хөгжил, төлөвшлийг хангахуйц байх;
3. Хүүхэд бүртэй ажиллах арга зүйд суурилан сургалтыг уян хатан төлөвлөх, зохион байгуулах нөхцөлийг бүрдүүлэхэд дэмжлэг болох;
4. Үнэлгээ нь хүүхэд бүрийн чадамжийг хөгжүүлэх, онцлогийг илрүүлж, дэмжлэг үзүүлэхүйц байх;
5. Эцэг эх, асран хамгаалагч, олон нийтийн оролцоог хангасан, цэцэрлэгийн менежмент, бие даасан байдал, багш нарын бүтээлч үйлийг дэмжсэн байх.

ХОЁР. СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛГО, ЗОРИЛТ

Зорилго

Бага насны хүүхэд бүр бие, оюун ухаан, сэтгэлээр эрүүл өсөн бойжих, өөрийн онцлог, бүтээлч үйлээрээ хөгжих, бие бялдар, танин мэдэхүй, нийгэмшихүйн чадамжийг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.

Зорилт

1. Хүүхэд эрүүл бие бялдартай, биеийн хөдөлгөөнөө зохицуулан аливаа үйл ажиллагаанд идэвх сонирхолтой оролцож, болзошгүй осол гэмтлээс сэргийлэх, эрүүл амьдрах дадалтай болох;
2. Хүүхэд өөрийн болон хүмүүсийн сэтгэл хөдлөл, зан байдлыг танин мэдэх, ойлгох, сэтгэлийн хөдөлгөөн, зан, үйл, харилцаагаа эергээр зохицуулан хүмүүстэй хүндэтгэлтэй харилцах;
3. Хүүхэд өөртөө итгэлтэй, эерэг зан чанартай, тууштай, суралцах сонирхолтой байх;
4. Хүүхэд хүмүүсийг сонсож, тэдэнтэй ярилцаж мэдээлэл солилцох дуртай, санаа бодол, мэдрэмж, мэдлэг төсөөллөө хэл яриагаар илэрхийлэх;
5. Хүүхэд бодит амьдралд тулгуурлаж математикийн энгийн төсөөлөлд суралцах, түүнд сонирхолтой байж, өдөр тутам хэрэглэдэг байх;
6. Хүрээлэн буй байгаль, нийгмийн орчныг сонирхож, тэдгээрийн учир шалтгаан, харилцан хамаарлыг өдөр тутмын амьдралаас танин мэдэх, орчинтойгоо зохистой харьцдаг байх;
7. Хүүхэд дүрслэх урлаг, хөгжмийг сонирхож таашааж, уран сэтгэмжтэй, урлагийн үйлд бүтээлчээр оролцдог байх.

ГУРАВ. СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨРИЙН АГУУЛГА

- Сургалтын хөтөлбөрийн зорилго, зорилтыг хэрэгжүүлэх агуулгыг хүүхдийн хөгжлийн хүрэх үр дүнгээр тодорхойлно.
- Сургалтын хөтөлбөрийн агуулга нь бага насны хүүхдийн бие бялдар, танин мэдэхүй, нийгэмшихүйн хөгжлийг дэмжихэд чиглэсэн “хөдөлгөөн, эрүүл мэнд”, “хэл яриа”, “математикийн энгийн төсөөлөл”, “байгаль нийгмийн орчин”, “хөгжим, дүрслэх урлаг” гэсэн суралцахуйн чиглэлүүдээр хэрэгжинэ. Нийгэмшихүйн хөгжлийг “хөдөлгөөн, эрүүл мэнд”, “хэл яриа”, “математикийн энгийн төсөөлөл”, “байгаль нийгмийн орчин”, “хөгжим, дүрслэх урлаг” гэсэн суралцахуйн чиглэл бүрээр дэмжиж төлөвшүүлнэ.
- Суралцахуйн чиглэл бүрээр эзэмших чадварыг хүүхдийн нас, хөгжлийн онцлогийг харгалзсан гурван түвшнээр тодорхойлно. Хүүхдийн эзэмших чадвар тус бүр хөнгөнөөс хүнд рүү чиглэсэн гурван түвшинтэй байна. Чадваруудын “I” түвшин 2 нас, “II” түвшин 3-4 нас, “III” түвшнийг 5 настай хүүхдэд баримжаалж болно.
- Энэхүү гурван түвшин нь хүүхдийн өмнөх төсөөлөл, мэдлэг, туршлагад тулгуурлан шинэ зүйлийг мэдэх мөн тодорхой нөхцөлд хэрэглэх чадвар, хандлагыг хөгжүүлэхэд чиглэнэ.

ДӨРӨВ. СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ЗҮЙ

Сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга зүйд хөтөлбөрийн зорилго, зорилт, агуулгыг хэрэгжүүлэх багшийн сургах, хөгжүүлэх, хүүхдийн сурч танин мэдэх арга, үйл үйлдлийг багтаан ойлгоно. Гэвч хүүхэд бүрийн хөгжлийн онцлог адилгүй гэдгийг багш онцгой анхаарч, хүүхдүүдийн дийлэнх нь аль түвшинд байгааг тогтоож, тэдэнд чиглэсэн үйл ажиллагааг зохион байгуулна.

Сургалтын хөтөлбөрийн агуулгыг хэрэгжүүлэхэд дараах аргуудыг хэрэглэнэ. Үүнд:

Багшлахуйнаргууд

- Тайлбарлан таниулах
- Асуулт тавих, харилцан ярилцах
- Үзүүлэн таниулах (бодит зүйл, карт, зурагт болон хөдөлгөөнт зүйлс)
- Асуудал шийдвэрлэх
- Идэвхжүүлэх арга
- Практик арга (дасгалжуулах, дагуулж хийлгэх, давтан хийлгэх арга)
- Дүрд тоглуулах арга
- Юмсыг бодитойгоор барьж, атгуулж, хүртүүлэх арга

Хүүхдийн сурч, таних мэдэх аргууд

- Сонирхож ажиглах
- Асуулт тавих, хариулах
- Даган дуурайх
- Давтах
- Тогтоох

Арга зүйд тавигдах шаардлага

1. Бага насны хүүхэд дотны хүнтэйгээ бие, сэтгэлээр ойр байж, хайр халамж, хамгаалагдсан байдлыг мэдэрсэн, тайван амгалан, чөлөөтэй байх үедээ идэвхтэй суралцдаг учир сэтгэлээрээ ойр дотно байхыг эрхэмлэх;
2. Хүүхэд багш, аав, ээж болон бусадтай хамт үйл хийж, идэвхтэй харилцах үед өөрийг нь итгэлтэй хамтрагч гэдгийг хүлээн зөвшөөрч байгааг мэдэрч, аливаа зүйлийн учрыг олох, тулгарсан асуудлыг шийдвэрлэхэд шинэ зүйлийг илүү хурдтай суралцдаг тул багш, хүүхэд, эцэг эхийн хамтын үйл ажиллагааг чухалчлах;

3. Хүүхдийн сэтгэл, оюунд баяр хөөртэй, сайхан мэдрэмж төрүүлсэн үйл явдал хоногшин үлддэг. Хүүхэд аз жаргалтай, баяр баясгалантай, хөгжилтэй, сонирхолтой байвал хийж буй зүйлдээ бүхий л боломж, чадвараа дайчлан илүү бүтээлчээр суралцдаг тул аливаа үйл нь хүүхдийн сонирхол, баяр баясгаланг төрүүлэхүйц байх;
4. Хүүхэд бүхий л мэдрэхүйгээрээ мэдээлэл хүлээн авч, эргэцүүлэн бодож, туршиж судлах явцад төвлөрч, сонголт хийж, бүтээлчээр ажиллаж, асуудал шийдвэрлэх арга замаа олдог тул мэдрэхүй, бүтээлч үйлийг дэмжсэн үйл ажиллагааг төлөвлөж хэрэгжүүлдэг байх;
5. Багш хүүхдийн алдааг хүлээн зөвшөөрч, тэдэнд алдаанаас суралцах боломжийг олгох;
6. Тусгай хэрэгцээт боловсрол шаардлагатай хүүхэдтэй эрэлт хэрэгцээнд нь нийцсэн ганцаарчилсан төлөвлөгөө боловсруулж ажиллах шаардлагатай.

ТАВ. СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ СУРГАЛТЫН ОРЧИН

1. Хүүхдийн орчин нь осол аюулгүй, эрүүл мэнд, хөдөлгөөн, тоглох үйлийг дэмжсэн, эерэг харилцааг үүсгэх, эрэл хайгуул хийхэд өдөөсөн суралцахуйн хөгжлийг дэмжсэн байна.
2. Сургалтын орчин нь бие бялдар, танин мэдэхүй, нийгэмшихүйн хөгжлийг дэмжсэн суралцахуйн чиглэлүүдийн үйлийг хэрэгжүүлэх боломжтой, хүүхдийн бие махбод, сэтгэл хөдлөл, харилцаа, сэтгэн бодох болон сурах арга барилыг дэмжсэн, харилцан хамааралтай, уян хатан байна.
3. Сургалтын материаллаг орчин, үйлийн орчин, сэтгэл зүйн орчин нь дараах шаардлагыг хангасан байна.

Материаллагорчин

- Хүүхэд бүлгээр ажиллахад хүртээмжтэй;
- Сонирхлыг татахуйц;
- Хэрэглэхэд ойр, хялбар;
- Хүүхдийн тоглонгоо суралцах хэрэгцээг хангах.

Үйлийнорчин

- Сонголт хийх боломжтой;
- Бодит үйл явцад оролцох;
- Хөдөлгөөний хэрэгцээг хангах;
- Олон талын туршлага хуримтлуулахуйц байх;
- Үйлийн эзэн, идэвхтэй харилцагч байх;
- Хангалттай цаг хугацаа олгох.

Сэтгэлзүйнорчин

- Эелдэг, дотно харилцааг бүрдүүлсэн;
- Хүүхдэд таатай, хайр халамжийг мэдрүүлэхүйц;
- Хүүхдэд баяр баясгалан төрүүлэхүйц;
- Өөрийнхөө талаар эерэг мэдрэмж авахуйц;
- Өрөө, танхим хангалттай орон зайтай байх.

ЗУРГАА. ХҮҮХДИЙН ХӨГЖЛИЙН ҮНЭЛГЭЭ

Хүүхдийн хөгжлийн үнэлгээ нь хүүхэд бүрд шаардлагатай дэмжлэг тусалцаа үзүүлэх, багш сургалтын агуулга, арга зүйгээ боловсронгуй болгох, эцэг эх, асран хамгаалагчид хүүхдийн хөгжил төлөвшлийн талаар бодит мэдээлэл өгөх зорилготой.

Сургуулийн өмнөх боловсролын сургалт, үйл ажиллагааны явцад хүүхдийн ойлголт төсөөлөл, мэдлэг, чадвар, дадлын үнэлгээ нь хүүхэд үйлийг гүйцэтгэхэд тулгарч буй бэрхшээл, гарч байгаа ахиц өөрчлөлт, хүүхдийн давуу талыг илрүүлэх, цаашид хэрхэн дэмжиж ажиллах арга барилаа сонгоход багшид баримжаа болно.

Үнэлгээний зарчим

- Хүүхдийн цогц хөгжлийг хамарсан байх;
- Хүүхдийн хөгжлийн талаар бодит баримтад тулгуурласан байх;
- Тухайн хүүхдийн гүйцэтгэлийн үр дүн, ахиц өөрчлөлтийг бусадтай нь харьцуулахгүй байх;
- Өдөр тутмын үйл ажиллагааны явцад тасралтгүй, эргэх холбоотой байх;
- Хүүхдийн гүйцэтгэсэн үйлийн үр дүн, гүйцэтгэлийн явцад илэрч буй оролдлого, зүтгэл чармайлт, нягт нямбай байдал зэргийг чухалчлан үзнэ.

Үнэлгээ нь явцын болон үр дүнгийн гэсэн хоёр төрөлтэй байна.

Явцын үнэлгээгээр багш өдөр тутмын хичээл, бусад үйл ажиллагааны явцад хүүхдийн юу сурч мэдэж, чадаж, сонирхож буйг болон хөгжлийн ахиц өөрчлөлтийг, үр дүнгийн үнэлгээгээр суралцахуйн чиглэлийн түвшин бүрээр хүүхдийн эзэмшсэн чадварыг үнэлнэ. Үнэлгээ нь багшид хүүхдийг хөгжүүлж төлөвшүүлэх ажлын явц, үр дүнг хянах боломж олгоно.

Бага насны хүүхдэд гарч буй ахиц өөрчлөлтийг илрүүлэх үндсэн арга нь ажиглалт байна. Багш хүүхдийн тоглох болон бусад үйлийн явцад бие бялдар, танин мэдэхүй, нийгэмшихүйн хөгжлийн тухайн үеийн байдал болон ахиц өөрчлөлтийг ажиглан тэмдэглэж баримтжуулна.

Ажиглалтад тавигдах шаардлага

- Юуг ажиглах зорилгоо тодорхойлох;
- Өдөр тутмын үйл ажиллагааны явцад хүүхдийн хийж буй үйл, илэрч буй зан ааш, сэтгэл хөдлөл зэрэг ажигласан зүйлээ тэмдэглэх;
- Тэмдэглэлд хэнийг, хаана, хэзээ ажигласныг тодорхой бичих;
- Ажиглалтын тэмдэглэл нь тухайн хүүхдийн хөгжилд дэмжлэг үзүүлэх суурь баримт болох.

Хувийн хавтас нь хүүхдийн сурч мэдсэн, чаддаг болсон зүйлийг бодитой харуулж, эцэг эх, асран хамгаалагчтай мэдээлэл солилцох үнэлгээний чухал хэрэгсэл болно. Багш хувийн хавтсыг хичээлийн жилийн туршид эцэг эх, хүүхэдтэй хамтран хөтөлнө. Энэ нь хүүхдийн ахиц өөрчлөлтийг харуулсан бүтээлүүд, фото зураг, ярилцлагын тэмдэглэл, бичлэг зэрэг олон зүйлийг агуулсан баялаг агуулгатай байна. Багш ажиглалтын тэмдэглэл, хувийн хавтас дахь баримт мэдээлэл болон үнэлгээний хуудсыг ашиглан тухайн хүүхдийн талаар цогц мэдээлэлтэй болж, үүнд тулгуурлан суралцахуйн чиглэл, үйл ажиллагааг төлөвлөнө.

Багш, эцэг эх хүүхэд бүрийн үнэлгээний мэдээллийн нууцлалыг хадгалах бөгөөд дараагийн шатны боловсролын байгууллагад шилжин суралцахад суурь баримт, мэдээлэл болгон ашиглана.

Үр дүнгийн үнэлгээ нь хүүхдийн хөгжлийг илрүүлэхэд чиглэнэ. Энэ нь суралцахуйн чиглэл, түвшин бүрээр хүүхдийн эзэмшсэн чадвараар тодорхойлогдоно. Багш хүүхдийн эзэмшсэн чадвар, ахицыг жилд 2 удаа буюу намар 9-11 дүгээр сард, хавар 4-6 дугаар сард үр дүнгийн үнэлгээний хуудас ашиглан үнэлнэ.

Үнэлгээнд хэн, ямар оролцоотой байх вэ?

Цэцэрлэгийн нүдирдлага

- Цэцэрлэгийн эрхлэгч, багш хүүхдийг үнэлж буй байдалд зөвлөн туслах, үнэлгээний арга, хэрэгслийг ашиглахад дэмжлэг үзүүлэх;
- Цэцэрлэгийн арга зүйч, хүүхдийн хөгжлийн ахицын үнэлгээнд дүн шинжилгээ хийж үнэлэлт, дүгнэлт өгөх;
- Цэцэрлэгийн арга зүйч хүүхдийн явцын үнэлгээнд үндэслэн сургалт (хичээл), үйл ажиллагааг төлөвлөх, сургалтын орчинг бүрдүүлэхэд багшид дэмжлэг үзүүлэх.

Багшнар

- Хүүхдийн чадвар, сонирхол, бие хүний онцлог шинжийг мэдэх, ойлгох;
- Хүүхдийн бие бялдар, нийгэмшихүй, танин мэдэхүйн хөгжилд гарч буй ахиц өөрчлөлтийг ажиглах арга техникийг эзэмшсэн байх;
- Хүүхдийн ялгаатай байдлыг илрүүлэх, тодорхойлох, дэмжлэг үзүүлэх;
- Эцэг эхчүүд хүүхдийнхээ талаар мэдээлэл өгч хамтран ажиллахад нь туслах;
- Хүүхдийн хэрэгцээнд нийцүүлэн сургалт (хичээл), үйл ажиллагааг төлөвлөхөд чиглэл болгох.

Эцэгэх

- Хүүхдийнхээ өсөлт, цогц хөгжлийн талаарх мэдээлэл авах, өгөх;
- Хүүхдийн хийж буй үйлийн гүйцэтгэл, үр дүнг ойлгох, ахиц өөрчлөлтийг таньж мэдэх;
- Хүүхдийн хөгжлийг дэмжих.

ДОЛОО. СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

1. Сургалтын хөтөлбөрийг цэцэрлэг бүр өөрийн үзэл баримтлалд үндэслэн боловсруулсан цэцэрлэгийн сургалтын хөтөлбөрөөр хэрэгжүүлнэ.
2. Хүүхдийг хөгжүүлэх үйл ажиллагааны зорилго нь хүүхдийн хөгжлийн эрэлт хэрэгцээ, сургалтын хөтөлбөрийн зорилго, зорилт, агуулгатай уялдуулсан байхаар тодорхойлно.
3. Өдрийн дэглэмийн дагуу явагдах бүхий л үйл ажиллагааг хүүхдийг хөгжүүлэх цаг гэж үзэх тул багш үйл ажиллагаа бүрийг хүүхдэд үр өгөөжтэй зохион байгуулахад анхаарч ажиллана.
4. Багш суралцахуйн чиглэл тус бүрээр сургалт (хичээл)-ын үйл ажиллагааг 7 хоногт 1 удаа зохион байгуулна.
5. Үйл ажиллагааны агуулга, арга зүй нь нээлттэй, уян хатан байна. Хүүхдийг хөгжүүлж төлөвшүүлэх ажлыг төлөвлөхдөө суралцахуйн чиглэл тус бүрт заасан хүүхдийн хүрэх үр дүнд баримжаалж, хөгжлийг дэмжих үйлийг дэлгэрүүлэхэд анхаарна.
6. Багш хүүхдийг хөгжүүлэх үйл ажиллагааг аль нэг сэдвийн дор зорилго, агуулга, арга зүй, хэрэглэгдэхүүнийг сонгож, нэгдмэл байдлаар (интеграцчилан) төлөвлөж явуулна.
7. Хүүхдийг хөгжүүлэх үйл ажиллагааг сургалтын зорилго, агуулга, арга, хэрэгсэл, тухайн хүүхдийн хувийн онцлогоос шалтгаалж ганцаарчилсан, хэсэгчилсэн, нийтээр зохион байгуулна.
8. Хүүхэд бүрийн хөгжлийн үнэлгээ нь тухайн хүүхдийн суралцах үйл явц, шаардлагатай дэмжлэг, үйл ажиллагааг тодорхойлж төлөвлөх суурь болно.
9. Цэцэрлэг тусгай хэрэгцээт боловсрол шаардлагатай хүүхдийн ангитай эсвэл ердийн ангид тусгай хэрэгцээт боловсрол шаардлагатай хүүхэд байдаг бол тэдний эрэлт хэрэгцээнд нийцсэн ганцаарчилсан төлөвлөгөө боловсруулж ажиллана.
10. Сургалтын хөтөлбөр нь багш, хүүхдийн харилцан идэвхтэй, бүтээлч үйлээс гадна эцэг эх, асран хамгаалагч болон нийгмийн бүлгүүдийн оролцоо, тэдний хамтын ажиллагааны үр дүнд хэрэгжинэ.

НАЙМ. БАГШ, ЭЦЭГ ЭХ, АСРАН ХАМГААЛАГЧИЙН ДЭМЖЛЭГ, ОРОЛЦОО

1. Багш нь хүүхдийн төлөө гэсэн сэтгэлтэй, тэдэнд хайртай, хүлээцтэй байхын дээр хүүхэд бүр харилцан адилгүй, давуу, сул талтай, өөрийн гэсэн зан ааштай гэдгийг хүлээн зөвшөөрч, хүндэтгэн харилцана. Багш дараах үүргийг хүлээнэ.

- **Хүүхэдтэй ойр дотно байж, тэдэнд хайр халамж, хамгааллыг мэдрүүлэх**
Багш хүүхэд бүрийн хүсэл, санаа бодлыг анхааран сонсож, хийж буй үйлд нь ач холбогдол өгнө. Тавьсан асуултад хариулт эрж олох, хийж буй үйлээ амжилттай гүйцэтгэхэд нь тусална, зоригжуулна, өөрийнхөө саналыг хэлнэ.
- **Анги танхимаа тохижуулах**
Хүүхэд идэвхтэй үйл гүйцэтгэх, чөлөөтэй хөдлөх, бусадтай харилцах, анхаарлаа төвлөрүүлэн ажиллах, амрах боломжийг бүрдүүлнэ. Тэдэнд тоглоом наадгай, сургалтын хэрэглэгдэхүүн, техник хэрэгслийг чөлөөтэй авч ашиглах боломж олгоно.
- **Тоглоом болон сургалтын бусад үйл ажиллагааг төлөвлөж зохион байгуулах**
Хүүхдийн тоглох явцад гаргасан сэдлийг дэмжинэ, тоглоомоо олон хувилбараар, сонирхолтой зохион байгуулахад нь сэдэл өгч дэмжинэ. Шаардлагатай тохиолдолд тоглоомын дүрмээ тохирч, хамтран зохицож тоглоход нь дэмжлэг үзүүлнэ. Цэцэрлэгийн өдөр тутмын үйл ажиллагааг төлөвлөхдөө хүүхдийн хэрэгцээ, сонирхлыг харгалзан, хүүхдийн оролцоог хангана. Цэцэрлэгийн гаднах орчинд хүүхэд суралцах, туршлага хуримтлуулах үйл ажиллагааг зохион байгуулна.
- **Хүүхдийг ажиглах, баримтжуулах**
Хүүхэд бүрийн хөгжлийг дэмжихийн тулд багш тухайн хүүхэд хэрхэн суралцаж, хөгжиж буйг ажиглаж үнэлнэ. Хүүхдийн тавьж буй асуулт, сонирхол, тулгарч буй асуудал, сэдсэн санааг мэдэрч хүлээж авна. Хүүхэд өдөр тутмын үйл ажиллагааны явцад юу хийж, яаж тоглож, биеэ хэрхэн авч явж байгаа, хөгжилд нь ямар ахиц ажиглагдсаныг тэмдэглэнэ. Хүүхдийн гүйцэтгэсэн үйлийн үр дүн (зураг, бүтээл, яриа гэх мэт)-ээр нь баримтжуулна. Түүнчлэн тодорхой зорилго, чиглэлтэй ажиглалт явуулна.
- **Эцэг эх, асран хамгаалагчтай хамтран ажиллах**
Эцэг эх, асран хамгаалагчдад хүндэтгэлтэй, нээлттэй, ойр дотно эергээр харилцаж, ойлгон, хүлээн зөвшөөрч, эрэлт хэрэгцээ, хүсэлд нь нийцсэн үйл ажиллагаа явуулж, хүүхдийнх нь хөгжлийн талаар тогтмол ярилцан, санаа бодлыг нь хуваалцана. Эцэг эх, асран хамгаалагчдын оролцооны боломжтой, үр дүнтэй хувилбаруудыг санаачлан ажиллана.

2. Гэр бүл нь хүүхдэд өргөн хүрээтэй, удаан хугацаагаар, хамгийн хүчтэй нөлөөлдөг анхдагч боловсролын орчин бөгөөд бага насны хүүхдийн хөгжилд гэр бүл шийдвэрлэх үүрэгтэй.

Эцэг эх, асран хамгаалагчийн үүрэг оролцоо

Цэцэрлэгийн удирдлага, багш нар, эцэг эх, асран хамгаалагчдад хүүхдийнхээ хөгжил, төлөвшлийг дэмжин ажиллахад дараах чиглэлээр зөвлөн тусалж, хамтран ажиллана.

Хүүхдэдээ олгох боломж

- Янз бүрийн орчин нөхцөлд туршлага хуримтлуулах (Жишээ нь: Хөдөө явах, музей үзэх);
- Үндэсний ёс заншил, гэр бүлийн үнэт зүйлс, өв уламжлалыг мэдэрч ойлгох, дагаж биелүүлэх;
- Харилцааны соёл, хэм хэмжээ, ёс зүйг мэдэрч дуурайх (Жишээ нь: Мэндлэх, талархах, уучлалт хүсэх, үнэнч, шударга байх);

- Эрүүл ахуйн хэвшил дадал эзэмших (Жишээ нь: Гар, шүдээ угаах, тогтсон цагт унтах);
- Чаддаг зүйлээ бие даан хийж дуусгах;
- Сонголт хийх, шийдвэр гаргах;
- Эрүүл, тэжээллэг хоол хүнс хэрэглэх.

Хүүхдэд эзэнлөөлөхүйл

- Хүүхдээ анхааралтай сонсож, ярилцах;
- Хүүхдийнхээ асуултад ач холбогдол өгч, хариулт өгөх, хамтран хариулт олох;
- Хүүхдэдээ асуулт тавих, ярилцах;
- Хүүхдэдээ үлгэр, өгүүллэг уншиж өгөх, ярилцах;
- Унтуулахдаа “Бүүвэйн дуу” аялах;
- Хүүхдэд өгсөн амлалтаа биелүүлэх;
- Хүүхдийнхээ зурсан зураг, бүтээлүүдийг үзэж сонирхож саналаа хэлж, урам өгөх;
- Хүүхэд, багштай хамтран “Хувийн хавтас”-ыг нь баяжуулах;
- Хүүхэд бодол санаа, мэдрэмжээ зурах, урлаж бүтээх, тоглох үйлээр илэрхийлэхийг урамшуулж дэмжих;
- Хүүхэд дуулах, шүлэг унших, бүжиглэх, жүжиглэхэд нь талархах, зоригжуулах;
- Үзэж харсан, оролцсон үйл явдлынх нь тухай хүүхэдтэйгээ ярилцах.



НИЙГЭМШИХҮЙН ХӨГЖИЛ

Яагаад хэрэгтэй вэ?

“Хүн болох” үндэс суурь бага насанд тавигддаг. Хүүхэд бүр хүмүүний зан чанар, харилцааны үнэт зүйлсийг багаасаа эзэмшиж, төлөвших нь тэдний насан туршийн ажил, амьдралд шийдвэрлэх үүрэгтэй. Хүний хөгжил, төлөвшлийн судалгаагаар нийгэмшихүйн чадамж (EQ) нь оюуны чадамж (IQ)-ийн суурь шийдэл буюу хүний амжилтын үндэс болохыг нотолж байна. Энэ нь манай ард түмэн хүмүүний “зүрх сэтгэлийн хөгжил”-ийг чухалчлан “Санаа зөв бол заяа зөв”, “Дотоод сэтгэл зөв бол гадаад үйл зөв” хэмээх сургаалыг эрхэмлэн үр хүүхдээ хүмүүжүүлж ирсэн уламжлалтай утга нэг юм. Иймд хүүхэд өөртөө итгэх, өөрийнхөө онцлог, давуу талыг мэдрэх, хүмүүст анхаарал тавих, холбоо харилцаа тогтоох, мэдээлэл солилцох, оролдлого, зүтгэлтэй байх, хийж буй үйлээ ойлгох, тууштай хандах боломж, орчин нөхцөлийг бүрдүүлэх хэрэгцээ бий болдог.

Ямар үр дүнд хүрэх вэ?

- Хүүхэд, өөрийн болон хүмүүсийн зан байдал, сэтгэл хөдлөлийг мэдэрч, өөрийнхөө талаар өөдрөг сэтгэгдэлтэй, өөртөө итгэлтэй байна.
- Өөрийн сонирхол, давуу тал, бүтээлч, тууштай, санаачилгатай, идэвх чармайлтаа чөлөөтэй илэрхийлнэ.
- Хүмүүсийн ялгаатай байдлыг ойлгож хүндэлнэ, үеийн хүүхэд, найз нөхөд, хүмүүстэй тоглоом, эд зүйлсээ хуваалцаж хамтран тоглож, тэднээс тусламж хүсч талархана.
- Уламжлалт ёс заншлыг дагаж тогтоосон дүрэм журмыг мэдэж, харилцаанд тулгарсан асуудлыг өөрийн хэмжээнд шийдвэрлэнэ.

Ямар чадвар эзэмших вэ?

1. Өөрийгөө мэдрэх, илэрхийлэх
2. Өөртөө үйлчлэх, оролцоотой байх
3. Сэтгэлийн хөдөлгөөнөө зохистой илэрхийлэх
4. Асуудлыг өөрийн хэмжээнд шийдвэрлэх
5. Бусдыг мэдэрч ойлгох
6. Насанд хүрэгчидтэй харилцах
7. Үеийн хүүхдүүдтэй харилцах
8. Бусад хүүхэд (өөрөөсөө насаар ах, дүү)-тэй харилцах
9. Орчны өөрчлөлтөд дасах
10. Хүмүүсийн хоорондох ялгаатай байдлыг ойлгох, хүндэтгэлтэй хандах
11. Оролдлоготой, санаачилгатай, тууштай байх
12. Дүрэм журмыг ойлгох, мөрдөх

Чадвар	Түвшин		
	I	II	III
1.Өөрийгөө мэдрэх, илэрхийлэх	Бие, сэтгэлийнхээ тааламжтай ба тааламжгүй байдлыг мэдрэх, илэрхийлэх	Дуртай, дургүй, сонирхож байгаагаа илэрхийлэх	Санаа бодлоо илэрхийлэх, хамгаалах
2.Өөртөө үйлчлэх, оролцоотой байх	Хувцсаа өмсөх, тайлах, хоолоо идэх зэрэг үйлийг хийх, чадахгүй зүйлдээ бусдаас туслалцаа хүсэх	Өдөр тутмын үйл ажиллагаа (жижүүр хийх, тоглох гэх мэт)-нд бүтээлчээр, бие даан оролцох	Тоглох, сурах үйлд санал гаргах, эрэл хайгуул хийх, эхэлснээ дуусгах

3. Сэтгэлийн хөдөлгөөнөө зохистой илэрхийлэх	Сэтгэлийн хөдөлгөөнөө үйл хөдлөл, үгээр илэрхийлэх	Сэтгэлийн хөдөлгөөнийхөө учир шалтгааныг тайлбарлах	Уур бухимдлаа (бусдыг гомдоохгүй, түрэмгийлэхгүй) үгээр илэрхийлэх, өөрийгөө ойлгуулах
4. Асуудлыг өөрийн хэмжээнд шийдвэрлэх	Тулгарсан асуудлаа мэдэгдэх, бусдын дэмжлэгийг хүсэх	Асуудал, зөрчлийг өөрийн хэр хэмжээнд шийдвэрлэх	Тоглох, үйл гүйцэтгэх явцад тулгарах асуудлыг бие даан шийдвэрлэх, асуудлыг шийдвэрлэх боломжит хувилбаруудыг санал болгох
5. Бусдыг мэдэрч ойлгох	Хүмүүсийн сэтгэлийн хөдөлгөөнийг нүүрний хувирал, дуу хоолойн өнгө, хөдөлгөөнөөр ялгах	“Би” бусдаас ялгаатай гэдгээ мэдэрч таних, өөрийнх нь үйлдэл бусдад нөлөөлж буйг мэдэж харилцах	Хүмүүсийн сэтгэлийн хөдөлгөөн өөр өөр байдгийг ялган хэлэх, зохицон харилцах
6. Насанд хүрэгчидтэй харилцах	Хүүхэд талархал, дургүйцэл, сэтгэлд нийцэж байгаагаа үг, үйл хөдлөлөөрөө илэрхийлэх	Насанд хүрэгчидтэй мэндчилгээ, талархлын үг хэлж харилцах, шаардлагатай үед тусламж хүсэх, хүссэн тохиолдолд тэдэнд туслах	Насанд хүрэгчдээс сонирхсон зүйлээ асуух, хүсэлт гуйлтыг нь биелүүлэх, хүндэтгэн харилцах
7. Үеийн хүүхдүүдтэй харилцах	Бусдын дунд багш (насанд хүрэгчид)-ийн тусламжтайгаар тоглоом, эд зүйлсийг хэрэглэх	Бусадтай хамтран тоглох, ажил үйл гүйцэтгэх	Санаа бодлоо бусдад ойлгуулан, найзтайгаа найрсаг, нээлттэй харилцах
8. Бусад хүүхэд (өөрөөсөө насаарах, дүү)-тэй харилцах	Бусад хүүхдийн тоглох, хийж буй үйлийг ажиглах, хөдөлгөөн, үг хэллэгийг дуурайх	Тоглоом наадгай, эд зүйлээ хуваалцах, ээлжээ хүлээх, хамтрах, өөрөөсөө дүү, ах хүүхдийг хүндэтгэж харилцах	Бусад хүүхэдтэй багаар үйл гүйцэтгэх, өөрөөсөө бага насныханд туслах, халамжлах
9. Орчны өөрчлөлтөд дасах	Гэр бүлийн орчноос цэцэрлэг ялгаатай гэдгийг мэдэрч, дасан зохицох	Цэцэрлэгийн амьдрал, үйл ажиллагаанд оролцох	Өөр өөр орчин (бусад анги, танхимд, шинэ хүүхэдтэй)-д үйл ажиллагаанд идэвхтэй оролцох
10. Хүмүүсийн хоорондох ялгаатай байдлыг ойлгох, хүндэтгэлтэй хандах	Хүн бүр өөр гэдгийг мэдэрч, ялгаж заах, нэрлэх	Хүмүүс (хүүхдүүд) хүйс, царай зүс, зан ааш, чадвар, биеийн онцлогоороо ялгаатай гэдгийг мэдэх, хүлээн зөвшөөрч харилцах	Өөр хэл, соёлтой хүмүүсийг сонирхох (асуулт асуух), тэдэнтэй хүндэтгэлтэй харилцах
11. Оролдлоготой, санаачилгатай, тууштай байх	1-2 шатлалтай зааврыг анхааралтай сонсох, биелүүлэх	Хийж буй ажил үйлдээ оролцох хугацаа нь уртсах, сонголт хийх, 2-3 шатлалтай зааврыг ойлгож биелүүлэх	Өгсөн заавар, дүрмийг анхааралтай сонсож, биелүүлэх, хийж буй зүйлээ дуусгах, санаачилгаараа үйл гүйцэтгэх
12. Дүрэм журмыг ойлгох, мөрдөх	Болно, болохгүйг ойлгох, өгсөн энгийн зааврыг дагах	Тоглоомын болон ангийн дүрмийг ойлгож, бусдын сануулгатайгаар мөрдөх	Гэр бүл, цэцэрлэг, анги, олон нийтийн газарт тогтсон дүрэм, журмыг баримтлах

Нийгэмшихүйн чадамжийг хүүхэд суралцахуйн чиглэлүүд болон өдөр тутмын бүхий л үйл ажиллагааны явцад эзэмшинэ.

Ямар үйлээр дэмжих вэ?

- Хүүхдийн сэтгэл санааны байдлыг ажиглаж мэдрэх, ойлгох, мөн баяр хөөртэй яриа, уйтгарласан тухай сонсож, сэтгэл санааг тайвшруулаж, хүндэтгэж харилцана.
- Хүүхдэд өөрийнхөөрөө үйлээ төлөвлөх, төлөвлөснөө хэрэгжүүлэх, сурсан зүйл, туршлагаа давтах, сэргээн санах боломж олгоно. (Жишээ нь: Өнөөдөр юу хийхээр төлөвлөсөн бэ?)
- Хүүхдэд өөрийгөө ойлгуулах, хийсэн үйлдлээ тайлбарлах боломж олгоно.
- Хүүхдийг ажиглаж давуу талыг илрүүлэх, өөрийгөө таньж мэдэхтэй холбогдох үйл ажиллагаанууд зохион байгуулна.
- Багш хүүхдүүдэд өөрийнхөө чадвар, хүч, хурдыг мэдрэх, өөртөө итгэх итгэл, мэдрэмжийг төрүүлэх олон төрлийн үйл ажиллагааг (өрсөлдүүлэхгүй байхад анхаарах) зохион байгуулна.
- Багш өөрийн сэтгэлийн хөдөлгөөн, байдлаа үгээр илэрхийлж, дуу хоолойн өнгө, үйл хөдлөл, хандлагаараа үлгэрлэн харуулна.
- Багш ангид аа үйл ажиллагаа зохион байгуулахдаа олон хэлбэрээр хүүхдэд сонирхолтой, өөрсдөө шийдвэр гаргах боломжийг олгож, гаргасан шийдвэрээ хэлэлцэх, хамтрах тухай ярилцана.
- Хүүхдийг богино хугацаанд цэцэрлэгт дасгах аргуудыг хэрэглэнэ. (Жишээ нь: Хүүхэд цэцэрлэгт ангитайгаа танилцах, ангид аав ээжтэйгээ хамт байх, хайртай тоглоом, эд зүйлээ авч ирэх)

Ямар хэрэглэгдэхүүн ашиглах вэ?

- Шинэ зүйлтэй танилцах, шинэ ажил үйл санаачлах, зохион бүтээх үйл хийх орчин
- Өдөр тутмын амьдралд тохиолдож буй эерэг, сөрөг харилцааны илрэл
- Сургах тоглоомын хэрэглэгдэхүүн
- Дүрд тоглох тоглоом, ширээний театр, жүжигчилсэн тоглолтын хувцас, хэрэглэл
- Сэтгэлийн хөдөлгөөний хувирал, харилцааны сайн, муу жишээг харуулсан зурагт үзүүлэн, ижилсүүлэх, ялгаа олох картууд
- Харилцааны агуулга бүхий цахим хэрэглэгдэхүүн (аудио, видео хуурцаг)
- Харилцааны агуулга бүхий үлгэр, өгүүллэг, дуу, шүлэг, сургамжит өгүүллэг
- Энгийн хөдөлмөр гүйцэтгэх багаж хэрэгсэл
- Байгалийн бичил орчин (тасалгааны цэцэг, ургамал)

The image features a central text block flanked by decorative vertical elements. On the left, a dark vertical line is partially obscured by a light gray wavy band that loops around it. On the right, a similar dark vertical line is partially obscured by a light gray wavy band. The text is centered between these elements.

**ХӨДӨЛГӨӨН,
ЭРҮҮЛ МЭНД**

Яагаад хэрэгтэй вэ?

Хүүхдийн бие эрүүл, чийрэг байх нь тэднийг идэвхтэй, эрч хүчтэй, тэсвэр хатуужилтай болгохоос гадна суралцах, хөгжих нөхцөлийг бүрдүүлдэг учраас тэдний хөдөлгөөний хөгжлийг дэмжихэд чиглэсэн үйл ажиллагааг зохион байгуулна. Хөдөлгөөн нь хүүхдийн тархины үйл ажиллагааг идэвхижүүлдэг.

Хүүхдийн бага насандаа эзэмшсэн эрүүл амьдрах дадал хэвшил нь тэдний насан туршид нь хадгалагдан эрүүл мэндэд сайнаар нөлөөлж, ач тусаа өгдөг.

Хүүхэд өөртөө итгэлтэй, өөдрөг сэтгэлтэй, баяр баясгалантай, дарамтгүй, тайван байх сэтгэл санааны эрүүл мэнд нь хүүхдийн хөгжил, төлөвшлийн хамгийн чухал суурь болно.

Ямар үр дүнд хүрэх вэ?

- Бие, гар, хурууны хөдөлгөөн хийснээр хөдөлгөөний эв дүй, хурд, хүч, уян хатан, тэсвэржилт, тэнцвэр нь сайжирч, хөдөлгөөнөө хянан, зохицуулж, төрөл бүрийн хөдөлгөөнийг чадварлаг гүйцэтгэнэ.
- Хөдөлгөөнт тоглоом, үйл ажиллагаанд идэвхтэй, сонирхож оролцоно.
- Эрүүл, аюулгүй амьдралд хэвшүүлэх үйл ажиллагаанд идэвхтэй, тогтмол оролцож дадал хэвшил эзэмшсэнээ харуулна.
- Гэмтэл бэртлээс болгоомжилж, өвчлөлтөөс сэргийлдэг болно.

Ямар чадвар эзэмших вэ?

1. Алхах, гүйх
2. Үсрэх, харайх
3. Мөлхөх, авирах
4. Шидэх, дамжуулах, барих
5. Биеийн хөдөлгөөнөө хянах, зохицуулах
6. Хөдөлгөөн гүйцэтгэхдээ биеийн тэнцвэрийг хадгалах
7. Гар хурууны хөдөлгөөнөө зохицуулах
8. Хувийн ариун цэврийг сахих
9. Гэмтэхээс болгоомжлох, өвчлөхөөс сэргийлэх

Чадвар	Түвшин		
	I	II	III
1. Алхах, гүйх	Явж, гүйж байгаад унахгүйгээр зогсох	Орон зайг баримжаалан алхах, гүйх хөдөлгөөнийг хослуулах	Алхалт, гүйлтийг янз бүр (өлмий дээр алхах, ухарч алхах, хөлийг хойш хаяж гүйх, хөлийг солбиж гүйх гэх мэт)-ээр гүйцэтгэх, чиглэл, хурдаа өөрчлөн гүйх
2. Үсрэх, харайх	Хоёр хөл дээрээ байрандаа болон урагш үсрэх	Хоёр хөл дээрээ тодорхой (2 метр орчим зай туулж) зайд үсрэх, өөрөөсөө өндөр зүйлд үсэрч хүрэх	2 хөлөө нийлүүлэн олсны хоёр талд гарч үсрэх, саадыг давж үсрэх, өндөр (30 см)-т харайх

3. Мөлхөх, авирах	Нэг чиглэлд мөлхөх, шатаар өгсөх, уруудах	Саадыг давж мөлхөх, өндөрлөг зүйл (гулсуур, налуу шат гэх мэт) дээр авирч гарах, давж буух	Янз бүрээр мөлхөх, хананд тогтоосон шатанд авирч гарах, буух
4. Шидэх, дамжуулах, барих	Бөмбөг (эд зүйлс)-ийг урагш өнхрүүлэх, шидэх, шидсэн том бөмбөгийг барьж авах	Бөмбөгийг дамжуулах, дээш шидэх, барьж авах	Бөмбөгийг бай руу чиглүүлэн шидэж онох
5. Биеийн хөдөлгөөнөө хянах, зохицуулах	Насанд хүрэгчдийн хөдөлгөөнийг даган хийх	Дасгал, хөдөлгөөнийг дарааллын дагуу хийх	Хөдөлгөөнийг орон зайд зохицуулан бусадтай хамтран гүйцэтгэх
6. Хөдөлгөөнийг гүйцэтгэхдээ биеийн тэнцвэрийг хадгалах	Өргөн замаар биеийн тэнцвэрийг хадгалан алхах	Нарийн замаар биеийн тэнцвэрийг хадгалан алхах, үсрэх	Алхах, үсрэх, харайх, шидэх зэрэг хөдөлгөөн гүйцэтгэхдээ биеийн тэнцвэрээ хадгалах
7. Гар хурууны хөдөлгөөнөө зохицуулах	Жижиг тоглоом, эд зүйл (халбага, харандаа)-ийг алдахгүй барих	Гар хуруугаараа энгийн үйл (хаалга цоожлох, шүр хэлхэх, таглааг эргэдэж таглах, цэцэг услах, товч товчлох, бүсээ бүслэх гэх мэт) гүйцэтгэх	Гар хуруугаараа нарийн, хүндэвтэр үйл (хайчлах, эвхэх, гутлаа үдэх, шагай няслах, үсээ сүлжих, уяж зангидах гэх мэт) гүйцэтгэх
8. Хувийн ариун цэврийг сахих	Насанд хүрэгчдийн дэмжлэгтэйгээр амаа зайлах, хамраа цэвэрлэх, нүүр гараа угаах	Бусдын сануулгатайгаар гараа дарааллын дагуу угаах, хоолойгоо зайлах	Гараа бие даан дарааллын дагуу угаах, шүдээ насанд хүрэгчдийн дэмжлэгтэйгээр угаах. Бие зассаны дараа ариун цэврийн цаас хэрэглэх
9. Гэмтэхээс болгоомжлох, өвчлөхөөс сэргийлэх	Насан хүрэгчдийн анхааруулсан үйлдэл (бохирдсон хүнсийг идэхгүй байх гэх мэт)-ийг хийхгүй байх	Өөрийн эрүүл мэндэд хортой зүйлсээс зайлсхийх, эрүүл мэндээ хамгаалах үйлдэл (түүхий ус уухгүй байх, ханиадны эсрэг массаж хийх гэх мэт)-үүд хийх	Гэмтэж болзошгүй үйлдэл (малын хөлөөс хол байх, машинаас болгоомжлох гэх мэт)-ээс зайлсхийх, биед сайн, муу хүнсийг ялгах

Ямар үйлээр дэмжих вэ?

- Хүүхдийн орчин осол аюулгүй, амар тайван, хөдөлгөөн гүйцэтгэх орон зай хангалттай байхад анхаарч бүрдүүлнэ.
- Хүүхдийн сэтгэл санааны байдал, дуртай болон дургүй зүйлийг анзаарч, ганцаарчилсан дэмжлэг үзүүлнэ.
- Хүүхэд тоглоом, хэрэглэлийг бие даан сонгох, үндсэн хөдөлгөөнүүдийг гүйцэтгэхэд дэмжлэг үзүүлнэ, зоригжуулна.
- Хүүхдэд дасгал, хөдөлгөөн гүйцэтгэх техникийг үлгэрлэн үзүүлж, хүүхэдтэй хамтран хийж, давтан хийх явцдаа гүйцэтгэлээ сайжруулах боломж олгоно.
- Тоглоомын дүрмийг баримтлахад дэмжлэг үзүүлж, дүгнэж ярилцана.
- Хооллолтыг ая тохитой, тайван зохион байгуулна. Хүүхдэд эрүүл хооллолтын талаар ойлголт өгнө.

- Гарын хөдөлгөөнийг дэмжсэн тоглоом зохион байгуулна. (Жишээ нь: Элс, усаар тоглох, гар хуруугаар тоглох)
- Цэцэрлэг дээр хүүхдэд эзэмшүүлж буй эрүүл ахуйн дадлыг гэрт нь бататган мөрдүүлж байх талаар эцэг эхэд зөвлөнө, хамтран ажиллана.

Ямар хэрэглэгдэхүүн ашиглах вэ?

- Шат, гулсуур, сагсны шийд, вандан, саадтай зам, нуман шат, налуу хавтан зэрэг ангийн болон гадаа талбайн хэрэглэл
- Олс, цагираг, тууз, төрөл бүрийн бөмбөг, дарцаг, саваа мод гэх мэт хөдөлгөөнт тоглоомын хэрэглэл
- Биеийн болон гар хурууны хөдөлгөөн дэмжсэн уламжлалт тоглоомууд
- Том өрж байгуулах тоглоом, унаж явдаг тоглоомон машин
- Хэлхэх шүр, шагай, сүвлэх, сүлжих хэрэглэл
- Хувийн ариун цэврийн хэрэглэл



ХЭЛ ЯРИА

Яагаад хэрэгтэй вэ?

Бага насанд хүүхэд авиа, үг, өгүүлбэрийг зөв ойлгох, хэлэх, сонсох, шинэ үг сурах, үгийг хувилгаж өгүүлбэрт холбож хэрэглэх, өөрийгөө ойлгуулж харилцах хэрэгцээ бий болно.

Хүүхэд бусадтай харилцан ярих, сонсохын зэрэгцээ уншиж, ярьж өгсөн эх (үлгэр, өгүүллэг зэрэг)-ийн утга агуулгыг ойлгож, уялдаа холбоотойгоор эргүүлэн ярьдаг болж, номыг сонирхон, хүмүүсийг дуурайж зурж бичих дуртай болно.

Ямар үр дүнд хүрэх вэ?

- Хүмүүсийн яриаг сонсож ойлгон, идэвхтэй харилцан ярилцана.
- Үг, өгүүлбэрийн утгыг ойлгож, зөв хэрэглэнэ.
- Санаа бодол, хүсэл, сонирхол болон сонссон, харсан, оролцсон үйл явдлаа илэрхийлэн ярьдаг болно.
- Эхийг ойлгож, утгыг ярина, номыг сонирхоно, номтой ажиллаж сурна.
- Тэмдэг, тэмдэглэгээг ойлгоно, ашиглана, энгийн зурлага бичдэг болно.

Ямар чадвар эзэмших вэ?

1. Орчны болон хэлний авиаг ялгаж сонсох
2. Үгийн утгыг ойлгох, хэрэглэх
3. Өгүүлбэрийг ойлгох, өгүүлбэрээр ярих
4. Санаа бодлоо илэрхийлэн ярих
5. Уншиж, ярьж өгсөн эхийг ойлгосноо ярих
6. Зураг, тэмдэг тэмдэглэгээний утгыг хэлэх
7. Төрөл бүрийн зураас (шулуун, долгион, тахир, нуман...) зурах

Чадвар	Түвшин		
	I	II	III
1. Орчны болон хэлний авиаг ялгаж сонсох	Орчны дуу чимээг сонсох, дуурайх	Орчны дуу авиаг ялгаж сонсох, дуурайх	Хэлний авиа (үгийн эхэн, төгсгөлд орсон)-г ялгаж сонсох, зөв дуудах
2. Үгийн утгыг ойлгох, хэрэглэх	Үгийг сонсоод ойлгох, дуурайж дагаж хэлэх	Өдөр тутам хэрэглэдэг үгийн утгыг ойлгох, яриандаа хэрэглэх	Ойролцоо дуудлагатай, эсрэг утгатай үгийг ойлгох, яриандаа хэрэглэх
3. Өгүүлбэрийг ойлгох, өгүүлбэрээр ярих	Хураангуй өгүүлбэр хэлэх	Энгийн ба дэлгэрэнгүй өгүүлбэр ойлгох, хэлэх	Зөв бүтэцтэй өгүүлбэрээр ярих
4. Санаа бодлоо илэрхийлэн ярих	Өөрт тулгарсан, сонирхсон зүйлээ хураангуй өгүүлбэрээр хэлэх	Үзэж харсан, оролцсон үйл явдлынхаа тухай бусдад ярих	Санаа бодол, үзсэн, оролцсон үйл явдлаа ойлгомжтой ярих

5. Уншиж, ярьж өгсөн эхийг ярих	Уншиж, ярьж өгсөн богино үлгэр, өгүүллэгийн агуулгыг ойлгох, асуултад 1-2 үгээр хариулах	Уншиж, ярьж өгсөн үлгэр, өгүүллэгийн агуулгыг ойлгох, өөрийнхөөрөө давтан ярих	Үлгэр, зохиолын үйл явдлыг ойлгомжтой, дэлгэрэнгүй ярих, зохиомжлон ярих
6. Зураг, тэмдэг тэмдэглэгээний утгыг хэлэх	Зургаас өөрийн мэддэг зүйлийг заах, нэрлэх	Үйл явдлыг харуулсан зургийн агуулгыг ойлгох, тайлбарлан ярих	Орчиндоо байгаа тэмдэг тэмдэглэгээг мэдэх, утгыг тайлбарлах
7. Янз бүрийн зураас (шулуун, долгион тахир, нуман...) зурах	Харандааг зөв барих, эрээчиж сараачих	Харандаагаар хүрээнээс гаргахгүй будах, цэг холбон зурах	Энгийн (шулуун, долгион...) зурлага бичих

Ямар үйлээр дэмжих вэ?

- Хүүхдэд орчны дуу чимээ, авиаг ялгаж сонсох боломж олгоно, сонирхол, сэдэл төрүүлнэ.
- Хүүхэд шинэ үг таних, өгүүлбэрээр ярих, эх бүтээхэд дэмжлэг үзүүлж, төрөлх хэлээрээ тод сайхан ярьж үлгэрлэнэ.
- Харилцан ярианы үед, оньсого таавар, үлгэр өгүүллэгээс үгийн утгыг тайлбарлаж, дагаж хэлүүлж дуудлага, хэллэгийг засна.
- Хүүхдийн асуултад хариулж, хариултыг хамтран эрж олно.
- Хүүхдийн оролцсон үйл явдал, зураг бүтээлийн тухай яриаг сонсож, харилцан ярилцаж, чөлөөтэй ярихад нь зоригжуулна.
- Өдөр бүр ном унших, үлгэр, өгүүллэг ярих цаг гаргана. (Жишээ нь: Өдрийн унтлагын өмнө, гадаа тоглох үед. Аав ээж нарын хувьд: орой унтахын өмнө, тээврийн хэрэгслээр зорчих үед)
- Үлгэр, өгүүллэг уншиж байхдаа инээмсэглэх, хөмсгөө зангидах зэрэг нүүрний хувирал, дууныхаа өнгө аясын өөрчлөлтөөр агуулгыг тодруулж, ярихад нь үлгэр дуурайл үзүүлнэ.
- Хүүхдийн сонирхон асууж байгааг өдөөн дэмжиж, “хамтдаа” уншина. (Жишээ нь: Энэ чинь чухал асуулт байна. Чи юу гэж бодож байна? Юу тохиолдох бол?)

Ямар хэрэглэгдэхүүн ашиглах вэ?

- Төрөл бүрийн зургууд (Үлгэр, өгүүллэг, эвлүүлдэг, сэдэвт, зурагт хуудас, ил захидал, ижилсүүлэх карт гэх мэт)
- Тоглоомууд (эвлүүлдэг, лото, домино)
- Ардын уламжлалт тоглоом наадгай, зүйр цэцэн үгс, ертөнцийн гурав, түргэн хэллэг
- Танин мэдэхүйн, түүх, үлгэр зохиолын, хүүхдийн бүтээсэн ном, сэтгүүл
- Хүүхэлдэйн жүжгийн дэлгэц, хүүхэлдэйнүүд
- Самбар, шохой, үзэг, цаас
- Хөгжим, чихэвч, хуурцаг, CD
- Номын тавиур
- Зөөлөн сандал, буйдан, том, жижиг зөөлөн дэр
- Ном бүтээх, засварлахад ашиглах скоч, цаас, харандаа, будаг, хайч, цавуу



**БАЙГАЛЬ,
НИЙГМИЙН ОРЧИН**

Яагаад хэрэгтэй вэ?

Хүүхэд хүрээлэн буй орчны эд зүйлс, ургамал, амьтныг сонирхон судалж, хүмүүс, үйл явдлын талаар мэдээлэлтэй болсноор хорвоо ертөнцийн учир шалтгааныг танин мэдэж сонирхдог. Аливааг сонирхох нь тэдний суралцах үйлийн хөшүүрэг болох ба шинжлэн судлах арга барилд суралцахын тулгуур болно.

Монгол орны үзэсгэлэнт унаган байгаль орчин, амьтан, ургамал, цаг агаарын өөрчлөлт бүхий дөрвөн улирал, хүмүүсийн аж амьдрал, ажил хөдөлмөрийн онцлогийг танин мэдэх нь бага насны хүүхдийн суралцахуйн нэгэн чухал чиглэл юм.

Нийгмийн орчныхоо талаар мэдээлэл, төсөөлөлтэй болсноор хүүхэд нийгмийн нэг гишүүн гэдгээ мэдэх, олон нийтийн дунд өөрийгөө бие даан авч явах, зохистой харилцах хэм хэмжээнд суралцах боломж нэмэгдэнэ.

Ямар үр дүнд хүрэх вэ?

- Ойр орчныхоо юмс, эд зүйлсийг сонирхон судалж шинэ зүйлийг олж нээнэ.
- Юмс, үзэгдлийн учир шалтгааныг олохыг эрмэлздэг болно.
- Байгалийн сайхныг мэдэрч, ургамал, мал, амьтныг хайрлан хамгаална.
- Амьдарч буй нутаг орныхоо онцлог, ойр орчныхоо хүмүүсийн ажил үйлийг таньж мэднэ.
- Орчноо бохирдуулахгүй зохистой харьцана.

Ямар чадвар эзэмших вэ?

1. Орчны юмсыг сонирхох, таних, нэрлэх
2. Ургамал, амьтныг ажиглах, таньж мэдэх, арчлах
3. Улирал, цаг агаарын өөрчлөлтийг сонирхох, ялган таних
4. Ойр орчныхоо хүмүүсийн онцлогийг таньж мэдэх

Чадвар	Түвшин		
	I	II	III
1. Орчны юмсыг сонирхох, таних, нэрлэх	Орчны юмсыг сонирхох, нэрлэх	Орчны юмсын онцлог, шинж чанар (хатуу, зөөлөн гэх мэт)-ыг нэрлэх	Орчны юмсын ялгааг таних, илрүүлэх
2. Ургамал, амьтныг ажиглах, таньж мэдэх, арчлах	Орчныхоо ургамал, амьтныг сонирхох, нэрлэх	Орчны ургамал, гэрийн тэжээмэл амьтдыг онцлог шинжээр нь таньж ялгах, тайлбарлах	Ургамал, амьтныг хайрлах, арчлах
3. Улирал, цаг агаарын өөрчлөлтийг сонирхох, ялган таних	Байгалийн үзэгдэл (цас, бороо, салхи)-ийг нэрлэх	Ямар улирал болж байгаа, тухайн үед цаг агаар, амьтан, ургамалд гардаг өөрчлөлтийг сонирхох, тайлбарлах	Улирал, цаг агаарын байдалд тохируулан хувцаслах, хийх үйлээ (нартай үед сүүдрэвчин дор тоглох, бороотой үед шүхэр барьж явах) тохируулах
4. Ойр орчныхоо хүмүүсийн онцлогийг таньж мэдэх	Өөрийгөө болон гэр бүлээ танилцуулах, ойр орчныхоо хүмүүсийн хийж буй үйлийг сонирхох, нэрлэх	Өөрийн амьдардаг газар (аймаг, хот, дүүрэг, сум), хүмүүсийн ажил хөдөлмөрийн тухай ярих	Өөрийгөө ямар үндэстэн гэдгийг хэлэх, бусад үндэстнээс юугаараа ялгаатайг тайлбарлах

Ямар үйлээр дэмжих вэ?

- Орчны юмс (газар шороо, ус, ургамал гэх мэт)-ыг таньж мэдэх сонирхлыг өдөөж, хүүхдэд тэдгээрийг судлах боломж олгоно.
- Үйл ажиллагаанд шаардагдах багаж хэрэгслүүд болон ахуйн хэрэглээний эд зүйлсийг сонгож, бэлтгэнэ.
- Хүүхдэд юмсын учир шалтгаан, холбоо хамаарлын талаар таамаглал дэвшүүлэх, туршиж үзэх, дүгнэж ярилцах боломж олгож хүүхдийн “Яагаад?” гэсэн асуултыг хөхиүлэн дэмжинэ, хариултыг хүүхэдтэй хамтран эрж олно.
- Хүүхдүүд анги, туршлагын талбайд цэцэг, ургамал тарьж арчлан, өсөлт өөрчлөлтийг нь ажиглаж судлах, хүүхдэд олж мэдсэн, туршиж судалсан зүйлээ тэмдэглэх, ярилцах боломж олгоно. (Жишээ нь: Цаг агаарын өөрчлөлтийг тэмдэглэх хуанли бэлтгэж өгөх)
- Хүүхдэд өөрийгөө, гэр бүл, монгол үндэсний баяр, ёслолын тухай шинээр мэдсэн зүйлээ ярьж танилцуулах боломж олгоно.
- Амьдарч буй орон нутаг, хүмүүсийн ажил үйл, мал, тэжээмэл амьтдын ашиг тус, улирал, цаг агаарын онцлог, ургамал, амьтны амьдралд гарч буй өөрчлөлттэй танилцах аялал хийнэ.
- Хүмүүс байгальд болон орчиндоо эерэг, сөрөг хандаж буй байдал, түүний үр дагаврыг үлгэр, зохиол, бичлэг, зураг ашиглан танилцуулж ярилцана.

Ямар хэрэглэгдэхүүн ашиглах вэ?

- Элс, ус, мод, чулуу, цаас, цаасан хайрцаг, даавуу гэх мэт янз бүрийн юмс, материал
- Орчинд нь байгаа мал, амьтан, шавж, ургамал
- Ахуйн хэрэглээний эд зүйлс (Сам, оо, саван, шингэн саван, утас зүү, шүүр, тосгуур, товч, шүр гэх мэт)
- Янз бүрийн материалаар хийсэн эд зүйлс, тоглоом наадгай (резин, мод, хуванцар, шаазан, төмрөөр хийсэн)
- Багаж хэрэгслүүд (Ус шүршигч, жин, хэмжүүр, цаг, томруулдаг шил)
- Цэцэрлэг, орон нутгийн түвшинд санаачлан бүтээсэн хэрэглэгдэхүүн
- Эд зүйлс, амьтан, ургамлын зураг
- Тоглоомууд (Эвлүүлдэг, сургах, сэдэвт, хөдөлгөөнт тоглоомууд)
- Дуу, чимээ бүхий бичлэг



МАТЕМАТИКИЙН ЭНГИЙН ТӨСӨӨЛӨЛ

Яагаад хэрэгтэй вэ?

Математик нь аливаа утга санаа, сэтгэлгээг тодорхой илэрхийлж байдгаараа шинжлэх ухааны хэл, байгаль, нийгмийн юмс, үзэгдлийн мөн чанарт нэвтэрч орох танин мэдэхүйн арга юм. Аливаа юмс, эд зүйлс нь өнгө, хэлбэр дүрс, хэмжээ, жинтэй, үйл явдал нь цаг хугацаа, орон зайд байдаг. Хүүхэд энэ бүгдийг таньж мэдэж, судалснаар хүний амьдрал, нийгэм, эд зүйлсийн мөн чанарын талаар өөрийн ойлголт, төсөөлөлтэй болно.

Хүүхэд танин мэдэх эрмэлзэл, сонирхолтой болох, тооны ухагдахууныг амьдралдаа хэрэглэх, бүтээлчээр сэтгэх, аливааг цэгцтэй, олон талаас нь бодож сурахад математик чухал үүрэг гүйцэтгэдэг.

Ямар үр дүнд хүрэх вэ?

- Математикийн энгийн төсөөллийн тухай ойлголт (тоо, хэлбэр дүрс, хэмжээ, орон зай, цаг хугацаа)–ыг өдөр тутмын амьдралд хэрэглэх, асуудлыг шийдвэрлэдэг болно.
- Эд зүйлсийг шинж чанар (тоо, хэлбэр дүрс, хэмжээ, өнгө)-аар ялгана, ангилна, ижилсүүлнэ, хэмнэл үүсгэж дараалуулна, хэмжинэ.

Ямар чадвар эзэмших вэ?

1. Тоолох, тоо бодох
2. Хэмжих, хэмжээг ялгах
3. Хэлбэр дүрс, өнгийг тодорхойлох
4. Орон зайг баримжаалах
5. Цаг хугацаа заасан үг хэрэглэх

Чадвар	Түвшин		
	I	II	III
1. Тоолох, тоо бодох	Нэг ба олныг ялгах	Тоолох, тоогоор нь харьцуулах, нэмэгдүүлэх, хорогдуулах, дэс тоо хэрэглэх	Тооны цифр, тэмдэг тэмдэглэгээ хэрэглэх, хялбар бодлого (нэгээр нэмэгдүүлэх, хорогдуулах) зохиох, бодох
2. Хэмжих, хэмжээг ялгах	Эд юмсыг хэмжээгээр нь (том, жижиг) ялгаж заах, нэрлэх	Энгийн хэрэгсэл (харандаа, бичгийн хавчаар гэх мэт) ашиглан эд зүйлсийг хэмжих	Төө, сөөм зэрэг уламжлалт хэмжүүр ашиглан эд зүйлсийг хэмжих, шингэн бутармаг зүйлсийг тохирох хэрэгсэл (халбага, аяга, шанагаар гэх мэт)-ээр хэмжих
3. Хэлбэр дүрс, өнгийг тодорхойлох	Эд зүйлсийг ижлээр нь ялгах, нэгийг нөгөөд оноох	Эд зүйлсийг аль нэг шинж чанараар нь (хэмжээ, хэлбэр, дүрс, өнгө, хийсэн материал зэргийн аль нэгээр нь) ангилах, ижилсүүлэх	Юмсыг хоёр буюу түүнээс дээш шинж чанараар нь (том, гурвалжин дүрс эсвэл улаан дугуй дүрс гэх мэт) ангилах, дараалуулах, давтамж үүсгэх

4. Орон зайг баримжаалах	“Дээр”, “доор”, “гадаа”, “гэрт” гэсэн байрлал заасан үгийг ойлгох, хэрэглэх	Өөрийн байрлал (өмнө, хойно, баруун, зүүн) -аас бусад юмсын байрлалыг тодорхойлох	Нэг юмсын байрлалаар нөгөө юмсын байрлалыг тодорхойлно, харааны баримжаагаар юмсын хол, ойрыг төсөөлөн тооцоолох
5. Цаг хугацаа заасан үг хэрэглэх	Одоо, дараа гэсэн хугацаа илэрхийлсэн үгсийн утгыг мэдэх, хэрэглэх	Хоногийн хэсгүүд (өглөө, өдөр, орой, шөнө)-тэй холбоотой үг хэллэгийг хэлэх	Өнөөдөр, маргааш, өчигдөр гэсэн цаг хугацаа заасан үгсийг ялгах, хэрэглэх, үйл явдлын үргэлжлэх хугацааг баримжаалах

Ямар үйлээр дэмжих вэ?

- Тоолох, харьцуулах, хэмжих, дараалуулах, ангилах зэрэг үйлд шаардагдах төрөл бүрийн хэрэглэгдэхүүнийг ашиглаж, төрөл бүрийн аргаар тоолох (Жишээ нь: Сонсголоор, тэмтэрч тоолох, оноож тоолох), хэмжих, хэмжсэн зүйлээ тэмдэглэх, тооцоолно.
- Тоог өдөр тутмын амьдралд хэрэглэх боломжийг хүүхдэд олгоно. (Жишээ нь: Ширээн дээрх өглөөний цайны жигнэмэгийг тоолох, хүн бүрт халбага тараах, нэг ширээнд сууж байгаа хүүхдүүдийг тоолох)
- Тоотой холбоотой дуу, шүлэг, үлгэр, өгүүлэг ашиглан сонирхолтой үйл ажиллагаанууд зохион байгуулна.
- Өдөр тутмын үйл ажиллагааны явцад эд юмс, тэдгээрийн хэлбэр хэмжээ, шинж чанарын талаар асуух, давтамж үүсгэж тоглоно. Жишээ нь: Өнгө, хэлбэр дүрс, хэмжээ, хөдөлгөөнөөр гэх мэт.
- Ойр орчмын зүйлсийнхээ байрлал, орон зайг төсөөлөн баримжаалахад тусална. (Жишээ нь: Манай гэр цэцэрлэгийн дэргэд байдаг.)
- Чиглэл заасан тэмдэглэгээг ашигладаг байна. (Жишээ нь: Шатаар өгсөхөд сумыг дагаж явах)
- Цаг хугацаатай холбогдох ярилцлага, тоглоом, дүрслэн урлах үйл ажиллагаа зохион байгуулна. (Жишээ нь: Хэзээ болдог вэ? тааварт тоглоом, улирлын онцлогийг зурж дүрслэх, намрын баяр, цасны баяр тэмдэглэх)
- Өглөө бүр дасгал хийх, өдөр тутам цаг агаарын байдлыг хуанлид тэмдэглэх зэрэг давтагдсан үйл ажиллагаа зохион байгуулж, хүүхдийн цаг хугацааны ойлголтод дэмжлэг үзүүлнэ.

Ямар хэрэглэгдэхүүн ашиглах вэ?

- Өдөр тутмын хэрэглээний эд зүйлс
- Гарын доорх болон байгалийн материал (Жишээ нь: Чулуу, боргоцой, мөчир, товч, шүр, лааз, ундааны хуванцар сав, шүдэнзний хоосон хайрцаг)
- Хэрэглэгдэхүүн (Ангилах сав, хайрцаг, картан самбар, элсэн цаг, өнгийн утас, цаас, харандаа)
- Тарааж өгөх материал (Тооны цифр, төрөл бүрийн дүрс, хүнсний зүйлс, амьтан, ургамлын зураг)
- Тоглоомууд (Өрж байгуулах, шүр, шагай, картонон, цаасан тоглоомууд)



**ХӨГЖИМ,
ДҮРСЛЭХ УРЛАГ**

Яагаад хэрэгтэй вэ?

Бага насны хүүхэд хэл ярианаас гадна нүүр царайны хувирал, хөдөлгөөн, тоглох, зурж урлах, дуулах, бүжиглэх зэрэг үйлээр өөрийгөө илэрхийлдэг.

Хөгжмийн аялгууны янз бүрийн хэмнэлийг мэдэрч хөдөлгөөн хийх бүрд хүүхдийн сэтгэл сэргэж, булчин хөгжиж, хөгжмийн зэмсгээр тоглоход хараа болон гар, хурууны хөдөлгөөний зохицуулалт сайжирна. Хөгжмийн аялгууг сонсож утга санааг илэрхийлэх, дууны үг, аяыг сурах явцад тэдний ой тогтоолт сайжирч, сэтгэн бодох чадвар хөгждөг ба өөрийн үндэсний хэл соёлын гайхамшгийг мэдэрч эхэлнэ.

Нийтээрээ дуулах, хөгжим тоглох, жүжиглэх үед хамтран ажиллах, хөгжмийн зэмсгээ хуваалцах, тодорхой дүрэм журам дагах, бусдыг сонсох зэргээр нийгмийн харилцаанд суралцана.

Зурах, урлан бүтээх үйл нь хүүхдийн тал бүрийн хөгжлийг дэмжиж, бүтээлч сэтгэлгээг хөгжүүлнэ. Дүрслэн урлах үйл нь гар, хурууны хөдөлгөөнөө зохицуулах, эхэлсэн ажлаа дуусгах, тэсвэр тэвчээртэй болох, аливааг олон талаас нь бодож төлөвлөх, гоё сайхныг мэдрэх, хийж бүтээхийг эрмэлзэх зэрэг олон зэрэг нөлөөллийг хүүхдэд үзүүлдэг. Урлагийн бүтээлтэй танилцахад хүүхдэд зохиомж, утга агуулга, өнгө зохицол нь бүрдсэн сайхан зүйлсийг мэдэрч ойлгох боломж олдоно.

Ямар үр дүнд хүрэх вэ?

- Дуу, хөгжим, урлагийн бүтээлийг мэдэрч баясна.
- Дуулж, бүжиглэх, жүжигчлэн тоглох, хөгжимдөх, зурах, наах, баримал барих, зохион бүтээх сонирхолтой байна.
- Хөгжмийн аялгуу, хэмнэлийг мэдэрч дуулж, хөгжимдөж, бүжиглэнэ.
- Хүрээлэн байгаа орчны юмс, үзэгдлийн талаарх ойлголт төсөөлөл, санаа бодлоо зураг, бүтээлээрээ бүтээлчээр илэрхийлнэ.

Ямар чадвар эзэмших вэ?

1. Хөгжмийн аялгууг ялгаж сонсох, мэдрэмжээ илэрхийлэх
2. Дуулах
3. Хөгжимдөх
4. Хөгжмийн аялгуу, хэмнэлд тохируулан бүжиглэх, жүжиглэх
5. Хүрээлэн буй орчноос ажигласан зүйл, төсөөллөө зурж дүрслэх
6. Шавраар эд зүйлс, хүн, амьтныг дүрсэлж бүтээх
7. Хүрээлэн буй орчноос ажигласан зүйл, төсөөллөө наах
8. Барьж байгуулах, зохион бүтээх

Чадвар	Түвшин		
	I	II	III
1.Хөгжмийн аялгууг сонсох, мэдрэмжээ илэрхийлэх	Хөгжмийн аялгууг сонсоод баярлах, толгой, биеэ хөдөлгөх зэргээр илэрхийлэх	Өөрийн мэддэг дуу болон хөгжмийн аялгууг сонсоод таних, тохирох хөдөлгөөн хийх	Хөгжмийн хэмнэл, хурдан удаан, чанга сулыг ялган сонсох, дуу авиа, хөдөлгөөн, үгээр илэрхийлэх (алга таших, толгой дохих)

2. Дуулах	Дууны үгийг аялгуулан хэлэх, дагаж аялах	Дууг дагаж, багш хүүхдүүдтэй хамтран дуулах, бусдыг сонсож дууг зэрэг эхэлж, төгсгөх	Дууг өнгө, хэмнэлийг алдалгүй хөгжмийн хамсраатай болон хамсраагүй дуулах
3. Хөгжимдөх	Дуу, хөгжмийн хэмнэлийг илэрхийлэх (биеэр ганхах, алга таших, толгойгоо дохих)	Дуу, хөгжмийн хэмнэлийг энгийн хөгжмийн зэмсгээр дагаж тоглох (бөмбөр, шигшүүр, дуут мод зэрэг)	Дуу авиа, зан байдал, хөгжмийн хэмнэлийг энгийн хөгжмийн зэмсгээр илэрхийлэн тоглох
4. Хөгжмийн аялгуу, хэмнэлд тохируулан бүжиглэх, жүжиглэх	Дуу, хөгжмийн аянд тохируулан гараасаа барьж тойргоор алхах, алга таших, дорoo эргэх хөдөлгөөн хийх	Дуу, хөгжмийг ойлгож байгаагаа хөдөлгөөнөөр илэрхийлж бүжиглэх, дүрээр илэрхийлэх, хэмнэлд тохируулан багшийн зааврын дагуу хөдөлгөөнөө гүйцэтгэх, эхлэх, дуусгах	Дуу, хөгжмийн агуулга, дүрийн онцлогийг хөдөлгөөн, нүүрний хувирлаар илэрхийлэн харуулах, аялгууны хэмнэлд тохируулан хөдөлгөөн гүйцэтгэх
5. Хүрээлэн буй орчноос ажигласан зүйл, төсөөллөө зурж дүрслэх	Зурах үйлийг сонирхох, орчны юмсыг өөрийнхөөрөө зурж дүрслэх	Зурах багаж хэрэгслээ сонгох, төрөл бүрийн материал (харандаа, будаг, бийр эсгий бал гэх мэт) ашиглан олон аргаар зурж дүрслэх	Хүрээлэн буй орчны юмс, үзэгдэл, үйл явдал, санаа бодлоо зургаар илэрхийлэх, бусадтай хамтран бүтээл хийх, зурж буй зүйлдээ бүтээлчээр хандах
6. Шавраар эд зүйлс, хүн, амьтныг дүрсэлж бүтээх	Баримлын болон байгалийн шавар, зуурмаг, элсээр нэг цул бүтэцтэй зүйлс хийх, хэв ашиглан хэлбэр гаргах	Баримлын шавар, зуурмаг, цас, элсээр хялбар бүтэцтэй (2 ба 3-аас доошгүй хэсгээс бүтсэн) зүйлс дүрслэх	Баримлын шавар, зуурмаг, цас, элсээр эд зүйлс, хүн, амьтан дүрслэх
7. Хүрээлэн буй орчноос ажигласан зүйл, төсөөллөө наах	Наамал хийх үйлийг ажиглах, бэлэн дүрсээр наамал хийх	Үндсэн дүрс хайчлан эд зүйлс, амьтан, ургамал дүрсэлж наах	Төрөл бүрийн материал (цаас, картон, бөс даавуу, үр жимс)-аар бүтээлчээр дүрслэн наамал хийх
8. Барьж байгуулах, зохион бүтээх	Барьж байгуулах тоглоомоор эд зүйлс өрж бүтээх тоглох	Барьж байгуулах, эвлүүлж угсрах тоглоом, гарын доорх, байгалийн материалаар бүтээл хийх	Барьж байгуулах, эвлүүлж угсрах, бүтээсэн зүйлсийн агуулга, дүрслэлийг баяжуулах

Ямар үйлээр дэмжих вэ?

- Хүүхэд урлан бүтээхэд хэрэглэх материал (цаас, цавуу, баримлын шавар, байгалийн материал гэх мэт) багаж хэрэгсэл (бийр, хайч гэх мэт), энгийн хөгжмийн зэмсгийг бэлтгэж материал, багаж хэрэгсэлтэй аюулгүй, зөв харьцах арга техникийг таниулна.
- Хэрэглэгдэх материалуудыг төрөлжүүлэн хайрцаглаж, хаяглан (зургаар), хүүхэд сонгож, чөлөөтэй авч ашиглаж болохоор байрлуулна.
- Хүүхдэд хөгжмийн хүч (чанга, сул), хурд (удаан, түргэн), хэмнэлийг мэдрэх, тэдгээрийг янз бүрийн арга, хэрэгслээр илэрхийлэх боломж олгоно.
- Хүүхэд зурааснууд, өнгө, хэлбэр дүрсийг зураг бүтээлдээ ашиглахад тусална.
- Өөрийн санаа бодол, ойлголт төсөөлөл, аялал, зугаалга, тоглоом, уран зохиолтой танилцах явцад танилцсан амьтан, ургамал, сонирхсон эд зүйлс, үйл явдлыг зурж, дүрслэх сэдэл төрүүлнэ, чиглүүлнэ.
- Өдөр бүр хүүхдэд дуу, хөгжим сонсох, төрсөн сэтгэгдлээ хуваалцах, дууг ганцаараа болон бусадтай дуулах, хөгжмийн ая, хэмнэлд тохируулан хөдөлгөөн хийх боломж олгоно.
- Хүүхдийн хоолойн цараанд тохирсон дууг сонгоно, утгыг ярилцана, чанга хашхирахгүй, үгийг зөв тод хэлж дуулахад тусална.
- Дуулах, бүжиглэх, жүжиглэх, дүрслэн урлах чадвар хүүхэд бүрт харилцан адилгүйг хүлээн зөвшөөрнө, шаардагдах дэмжлэг тусалцаа үзүүлнэ.
- Хүүхдийн бүтээлд ажиглалт судалгаа хийнэ, ахицыг баримтжуулна.

Ямар хэрэглэгдэхүүн ашиглах вэ?

- Дууны болон сонсох хөгжмийн цомог
- Дуу авиа гаргах энгийн хэрэгслүүд
- Дуу, бүжиг, хөгжимт хөдөлгөөнд хэрэглэгдэх тууз, дарцаг, баг маск, хүүхэлдэй, тоглоом зэрэг дагалдах хэрэгсэл
- Хуруун, бээлийн, таягт хүүхэлдэй
- Төрөл бүрийн цаас (цаас, зургийн цаас, өнгийн цаас, ханын цаас, картонон цаас, хуучин сонин, сэтгүүл гэх мэт)
- Зургийн хэрэгслүүд (өнгийн харандаанууд, бийр, хайч, усан будаг, гуаш, тосон харандаа, өнгийн шохой гэх мэт)
- Дүрслэн урлахад шаардагдах бусад хэрэглэгдэхүүнүүд (баримлын шавар, зуурмаг, хэв, дардас, цоолбор, гарын доорх болон байгалийн материал гэх мэт)
- Өрж байгуулах, эвлүүлж угсрах тоглоом

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын
сайддын 2019 оны 08 дугаар сарын 02 өдрийн
А/494 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт

ХҮҮХДИЙН ХӨГЖЛИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС

Цэцэрлэгийн нэр, дугаар.....Бүлэг.....
Хүүхдийн овог, нэр.....Хүйс.....Хүүхдийн нас.....сар.....
Үнэлгээ хийсэн огноо.....

I ТҮВШИН

Тухайн чадварыг эзэмшсэн байдлыг “√” гэж тохирох шалгуурт тэмдэглэнэ.

№	Чадвар	Чадаж байна	Хараахан чадахгүй байна	Чадахгүй байна
Нийгэмшихүй				
1	Бие, сэтгэлийнхээ тааламжтай ба тааламжгүй байдлыг мэдрэх, илэрхийлэх			
2	Хувцсаа өмсөх, тайлах, хоолоо идэх зэрэг үйлийг хийх, чадахгүй зүйлдээ бусдаас туслалцаа хүсэх			
3	Сэтгэлийн хөдөлгөөнөө үйл хөдлөл, үгээр илэрхийлэх			
4	Тулгарсан асуудлаа мэдэгдэх, бусдын дэмжлэгийг хүсэх			
5	Хүмүүсийн сэтгэлийн хөдөлгөөнийг нүүрний хувирал, дуу хоолойн өнгө, хөдөлгөөнөөр ялгах			
6	Хүүхэд талархал, дургүйцэл, сэтгэлд нийцэж байгаагаа үг, үйл хөдлөлөөрөө илэрхийлэх			
7	Бусдын дунд багш (насанд хүрэгчид)-ийн тусламжтайгаар тоглоом, эд зүйлсийг хэрэглэх			
8	Бусад хүүхдийн тоглох, хийж буй үйлийг ажиглах, хөдөлгөөн, үг хэллэгийг дуурайх			
9	Гэр бүлийн орчноос цэцэрлэг ялгаатай гэдгийг мэдэрч, дасан зохицох			
10	Хүн бүр өөр гэдгийг мэдэрч, ялгаж заах, нэрлэх			
11	1-2 шатлалтай зааврыг анхааралтай сонсох, биелүүлэх			
12	Болно, болохгүйг ойлгох, өгсөн энгийн зааврыг дагах			
Хөдөлгөөн, эрүүл мэнд				
13	Явж, гүйж байгаад унахгүйгээр зогсох			
14	Хоёр хөл дээрээ байрандаа болон урагш үсрэх			
15	Нэг чиглэлд мөлхөх, бусдын туслалцаатай шатаар өгсөх, уруудах			
16	Бөмбөг (эд зүйлс)-ийг урагш өнхрүүлэх, шидэх, шидсэн том бөмбөгийг барьж авах			
17	Насанд хүрэгчдийн хөдөлгөөнийг даган хийх			
18	Өргөн замаар биеийн тэнцвэрийг хадгалан алхах			
19	Жижиг тоглоом, эд зүйл (халбага, харандаа)-ийг алдахгүй барих			
20	Насанд хүрэгчдийн дэмжлэгтэйгээр амаа зайлах, хамраа цэвэрлэх, нүүр гараа угаах			
21	Насан хүрэгчдийн анхааруулсан үйлдэл (бохирдсон хүнсийг идэхгүй байх гэх мэт)-ийг хийхгүй байх			

Хэл яриа				
22	Орчноосоо сонссон дуу авиаг дуурайх			
23	Үгийг сонсоод ойлгох, дуурайж дагаж хэлэх			
24	Хураангуй өгүүлбэр хэлэх			
25	Өөрт тулгарсан, сонирхсон зүйлээ хураангуй өгүүлбэрээр илэрхийлэн хэлэх			
26	Уншиж, ярьж өгсөн богино үлгэр, өгүүллэгийн агуулгыг ойлгох, асуултад 1-2 үгээр хариулах			
27	Зургаас өөрийн мэддэг зүйлийг заах, нэрлэх			
28	Харандааг зөв барих, эрээчиж сараачих			
Байгаль, нийгмийн орчин				
29	Орчны юмсыг сонирхох, нэрлэх			
30	Орчныхоо ургамал, амьтныг сонирхох, нэрлэх			
31	Байгалийн үзэгдэл (цас, бороо, салхи)-ийг нэрлэх			
32	Өөрийгөө болон гэр бүлээ танилцуулах, ойр орчныхоо хүмүүсийн хийж буй үйлийг сонирхох, нэрлэх			
Математикийн энгийн төсөөлөл				
33	Нэг ба олныг ялгах			
34	Эд юмсыг хэмжээгээр нь (том, жижиг) ялгаж заах, нэрлэх			
35	Эд зүйлсийг ижлээр нь ялгах, нэгийг нөгөөд оноох			
36	“Дээр”, “доор”, “гадаа”, “гэрт” гэсэн байрлал заасан үгийг ойлгох, хэрэглэх			
37	“Одоо”, “дараа” гэсэн хугацаа илэрхийлсэн үгсийн утгыг мэдэх, хэрэглэх			
Хөгжим, дүрслэх урлаг				
38	Хөгжмийн аялгууг сонсоод баярлах, толгой, биеэ хөдөлгөх зэргээр илэрхийлэх			
39	Дууны үгийг аялгуулан хэлэх, дагаж аялах			
40	Дуу, хөгжмийн хэмнэлийг илэрхийлэх (биеэр ганхах, алга таших, толгойгоо дохих)			
41	Дуу, хөгжмийн аянд тохируулан гараасаа барьж тойргоор алхах, алга таших, дороо эргэх хөдөлгөөн хийх			
42	Зурах үйлийг сонирхох, орчны юмсыг өөрийнхөөрөө зурж дүрслэх			
43	Баримлын болон байгалийн шавар, зуурмаг, элсээр нэг цул бүтэцтэй зүйлс хийх, хэв ашиглан хэлбэр гаргах			
44	Наамал хийх үйлийг ажиглах, бэлэн дүрсээр наамал хийх			
45	Барьж байгуулах тоглоомоор эд зүйлс өрж бүтээх, тоглох			

ХҮҮХДИЙН ХӨГЖЛИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС

Цэцэрлэгийн нэр, дугаар.....Бүлэг.....

Хүүхдийн овог, нэр.....Хүйс.....Хүүхдийн нас.....сар.....

Үнэлгээ хийсэн огноо.....

II ТҮВШИН

Тухайн чадварыг эзэмшсэн байдлыг “√” гэж тохирох шалгуурт тэмдэглэнэ.

№	Чадвар	Чадаж байна	Хараахан чадахгүй байна	Чадахгүй байна
Нийгэмшихүй				
1	Дуртай, дургүй, сонирхож байгаагаа илэрхийлэх			
2	Өдөр тутмын үйл ажиллагаа (жижүүр хийх, тоглох гэх мэт)-нд бүтээлчээр, бие даан оролцох			
3	Сэтгэлийн хөдөлгөөнийхөө учир шалтгааныг тайлбарлах			
4	Асуудал, зөрчлийг өөрийн хэр хэмжээнд шийдвэрлэх			
5	“Би” бусдаас ялгаатай гэдгээ мэдэрч таних, ойлгох, өөрийнх нь үйлдэл бусдад нөлөөлж буйг мэдэж харилцах			
6	Насанд хүрэгчидтэй мэндчилгээ, талархлын үгс хэлж харилцах, шаардлагатай үед тусламж хүсэх, хүссэн тохиолдолд тэдэнд туслах			
7	Бусадтай хамтран тоглох, ажил үйл гүйцэтгэх			
8	Тоглоом наадгай, эд зүйлээ хуваалцах, ээлжээ хүлээх, хамтрах, өөрөөсөө ах, эгч хүүхэдтэй хүндэтгэлтэй харилцах			
9	Цэцэрлэгийн амьдрал, үйл ажиллагаанд оролцох			
10	Хүмүүс (хүүхдүүд) хүйс, царай зүс, зан ааш, чадвар, биеийн онцлогоороо ялгаатай гэдгийг мэдэх, хүлээн зөвшөөрч харилцах			
11	Хийж буй ажил үйлдээ оролцох хугацаа нь уртсах, сонголт хийх, 2-3 шатлалтай зааврыг ойлгож биелүүлэх			
12	Тоглоомын болон ангийн дүрмийг ойлгож, бусдын сануулгатайгаар мөрдөх			
Хөдөлгөөн, эрүүл мэнд				
13	Орон зайг баримжаалан алхах, гүйх хөдөлгөөнийг хослуулах			
14	Хоёр хөл дээрээ тодорхой (2 метр орчим зай туулж) зайд үсрэх, өөрөөсөө өндөр зүйлд үсэрч хүрэх			
15	Саадыг давж мөлхөх, өндөрлөг зүйл (гулсуур, налуу шат гэх мэт) дээр авирч гарах, давж буух			
16	Бөмбөгийг дамжуулах, дээш шидэх, барьж авах			
17	Дасгал хөдөлгөөнийг дарааллын дагуу хийх			
18	Нарийн замаар биеийн тэнцвэрийг хадгалан алхах, үсрэх			
19	Гар хуруугаараа энгийн үйл (хаалга цоожлох, шүр хэлхэх, таглааг эргэдэж таглах, цэцэг услах, товч товчлох, бүсээ бүслэх гэх мэт) гүйцэтгэх			
20	Бусдыг сануулгатайгаар гараа дарааллын дагуу угаах, хоолойгоо зайлах			
21	Өөрийн эрүүл мэндэд хортой зүйлсээс зайлсхийх, эрүүл мэндээ хамгаалах үйлдэл (түүхий ус уухгүй байх, ханиадны эсрэг массаж хийх гэх мэт)-үүд хийх			

Хэл яриа				
22	Орчны дуу авиаг ялгаж сонсох, дуурайх			
23	Өдөр тутам хэрэглэгддэг үгсийн утгыг ойлгох, яриандаа хэрэглэх			
24	Энгийн ба дэлгэрэнгүй өгүүлбэр ойлгох, хэлэх			
25	Үзэж харсан, оролцсон үйл явдлынхаа тухай бусдад ярих			
26	Уншиж, ярьж өгсөн үлгэр, өгүүллэгийн агуулгыг ойлгох, өөрийнхөөрөө давтан ярих			
27	Үйл явдлыг харуулсан зургийн агуулгыг ойлгох, тайлбарлан ярих			
28	Харандаагаар хүрээнээс гаргахгүй будах, цэг холбон зурах			
Байгаль, нийгмийн орчин				
29	Орчны юмсын онцлог, шинж чанар (хатуу, зөөлөн гэх мэт)-ыг нэрлэх			
30	Орчны ургамал, гэрийн тэжээмэл амьтдыг онцлог шинжээр нь таньж ялгах, тайлбарлах			
31	Ямар улирал болж байгаа, тухайн үед цаг агаар, амьтан, ургамалд гардаг өөрчлөлтийг сонирхох, тайлбарлах			
32	Өөрийн амьдардаг газар (аймаг, хот, дүүрэг, сум), хүмүүсийн ажил хөдөлмөрийн тухай ярих			
Математикийн энгийн төсөөлөл				
33	Тоолох, тоогоор нь харьцуулах, нэмэгдүүлэх, хорогдуулах, дэс тоо хэрэглэх			
34	Энгийн хэрэгсэл (харандаа, бичгийн хавчаар гэх мэт) ашиглан эд зүйлсийг хэмжих			
35	Эд зүйлсийг аль нэг шинж чанараар нь (хэмжээ, хэлбэр, дүрс, өнгө, хийсэн материал зэргийн аль нэгээр нь) ангилах, ижилсүүлэх			
36	Өөрийн байрлал (өмнө, хойно, баруун, зүүн) -аас бусад юмсын байрлалыг тодорхойлох			
37	Хоногийн хэсгүүд (өглөө, өдөр, орой, шөнө)-тэй холбоотой үг хэллэгийг яриандаа хэрэглэх			
Хөгжим, дүрслэх урлаг				
38	Өөрийн мэддэг дуу болон хөгжмийн аялгууг сонсоод таних, тохирох хөдөлгөөн хийх			
39	Дууг дагаж, багш хүүхдүүдтэй хамтран дуулах, бусдыг сонсож дууг зэрэг эхэлж, төгсгөх			
40	Дуу, хөгжмийн хэмнэлийг энгийн хөгжмийн зэмсэгээр дагаж тоглох (бөмбөр, шигшүүр, дуут мод зэрэг)			
41	Дуу, хөгжмийг ойлгож байгаагаа хөдөлгөөнөөр илэрхийлж бүжиглэх, дүрээр илэрхийлэх, хэмнэлд тохируулан багшийн зааврын дагуу хөдөлгөөнөө гүйцэтгэх, эхлэх, дуусгах			
42	Зурах багаж хэрэгслээ сонгох, төрөл бүрийн материал (харандаа, будаг, бийр эсгий бал гэх мэт) ашиглан олон аргаар зурж дүрслэх			
43	Баримлын шавар, зуурмаг, цас, элсээр хялбар бүтэцтэй (2 ба 3-аас доошгүй хэсгээс бүтсэн) зүйлс дүрслэх			
44	Үндсэн дүрс хайчлан эд зүйлс, амьтан, ургамал дүрсэлж наах			
45	Барьж байгуулах, эвлүүлж угсрах тоглоом, гарын доорх, байгалийн материалаар бүтээл хийх			

ХҮҮХДИЙН ХӨГЖЛИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС

Цэцэрлэгийн нэр, дугаар.....Бүлэг.....

Хүүхдийн овог, нэр.....Хүйс.....Хүүхдийн нас.....сар.....

Үнэлгээ хийсэн огноо.....

III ТҮВШИН

Тухайн чадварыг эзэмшсэн байдлыг “√” гэж тохирох шалгуурт тэмдэглэнэ.

№	Чадвар	Чадаж байна	Хараахан чадахгүй байна	Чадахгүй байна
Нийгэмшихүй				
1	Санаа бодлоо илэрхийлэх, хамгаалах			
2	Тоглох, сурах үйлд бодож сэтгэх, эрэл хайгуул хийх, эхэлснээ дуусгах			
3	Уур бухимдлаа (бусдыг гомдоохгүй, түрэмгийлэхгүй) үгээр илэрхийлэх, өөрийгөө ойлгуулах			
4	Тоглох, ажил үйл гүйцэтгэх явцад тулгарах асуудлыг бие даан шийдвэрлэх, асуудлыг шийдвэрлэх боломжит хувилбаруудыг санал болгох			
5	Хүмүүсийн сэтгэлийн хөдөлгөөн өөр өөр байдгийг ялган хэлэх, зохицон харилцах			
6	Насанд хүрэгчдээс сонирхсон зүйлээ асуух, хүсэлт гуйлтыг нь биелүүлэх, хүндэтгэн харилцах			
7	Санаа бодлоо бусдад ойлгуулан, найзуудтайгаа найрсаг, нээлттэй харилцах			
8	Бусад хүүхэдтэй багаар үйл гүйцэтгэх, өөрөөсөө бага насныханд туслах, халамжлах			
9	Өөр өөр орчин (бусад анги, танхимд, шинэ хүүхэдтэй)-д дасах, үйл ажиллагаанд идэвхтэй оролцох			
10	Өөр хэл, соёлтой хүмүүсийг сонирхох (асуулт асуух), тэдэнтэй хүндэтгэлтэй харилцах			
11	Өгсөн зааврыг анхааралтай сонсож, биелүүлэх, хийж буй зүйлээ дуусгах, санаачилгаараа үйл гүйцэтгэх, дүрэм, заавар зохиох			
12	Гэр бүл, цэцэрлэг, анги, олон нийтийн газарт тогтсон дүрэм, журмыг баримтлах			
Хөдөлгөөн, эрүүл мэнд				
13	Алхалт, гүйлтийг янз бүрээр (өлмий дээр алхах, ухарч алхах, хөлийг хойш хаяж гүйх, хөлийг солбиж гүйх гэх мэт) гүйцэтгэх, чиглэл, хурдаа өөрчлөн гүйх			
14	2 хөлөө нийлүүлэн олсны хоёр талд гарч үсрэх, саадыг давж үсрэх, өндөр (30 см)-т харайх			
15	Янз бүрээр мөлхөх, хананд тогтоосон шатанд авирч гарах, буух			
16	Бөмбөгийг бай руу чиглүүлэн шидэж онох			
17	Хөдөлгөөнийг орон зайд зохицуулан бусадтай хамтран гүйцэтгэх			
18	Алхах, үсрэх, харайх, шидэх зэрэг хөдөлгөөн гүйцэтгэхдээ биеийн тэнцвэрээ хадгалах			
19	Гар хуруугаараа нарийн, хүндэвтэр үйл (хайчлах, эвхэх, гутлаа үдэх, шагай няслах, үсээ сүлжих, уяж зангидах гэх мэт) гүйцэтгэх			

20	Гараа бие даан дарааллын дагуу угаах, шүдээ насанд хүрэгчдийн дэмжлэгтэйгээр угаах. Бие зассаны дараа ариун цэврийн цаас хэрэглэх			
21	Гэмтэж болзошгүй үйлдэл (малын хөлөөс хол байх, машинаас болгоомжлох гэх мэт)-ээс зайлсхийх, биед сайн, муу хүнсийг ялгах			
Хэл яриа				
22	Хэлний авиа (үгийн эхэн, төгсгөлд орсон)-г ялгаж сонсох, зөв дуудах			
23	Ойролцоо дуудлагатай, эсрэг утгатай үгийг ойлгох, яриандаа хэрэглэх			
24	Зөв бүтэцтэй өгүүлбэрээр ярих			
25	Санаа бодол, үзсэн, оролцсон үйл явдлаа ойлгомжтой ярих			
26	Үлгэр, зохиолын үйл явдлыг ойлгомжтой, дэлгэрэнгүй ярих, зохиомжлон ярих			
27	Орчиндоо байгаа тэмдэг тэмдэглэгээг мэдэх, утгыг тайлбарлах			
28	Энгийн зурлага бичих			
Байгаль, нийгмийн орчин				
29	Орчны юмсын ялгааг таних, илрүүлэх			
30	Ургамал, амьтныг хайрлах, арчлах			
31	Улирал, цаг агаарын байдалд тохируулан хувцаслах, хийх үйлээ (нартай үед сүүдрэвчин дор тоглох, бороотой үед шүхэр барьж явах) тохируулах			
32	Өөрийгөө ямар үндэстэн гэдгийг хэлэх, бусад үндэстнээс юугаараа ялгаатайг тайлбарлах			
Математикийн энгийн төсөөлөл				
33	Тооны цифр, тэмдэг тэмдэглэгээ хэрэглэх, хялбар бодлого (нэгээр нэмэгдүүлэх, хорогдуулах) зохиох, бодох			
34	Төө, сөөм зэрэг уламжлалт хэмжүүр ашиглан эд зүйлсийг хэмжих, шингэн бутармаг зүйлсийг тохирох хэрэгсэл (халбага, аяга, шанагаар гэх мэт)-ээр хэмжих			
35	Юмсыг хоёр буюу түүнээс дээш шинж чанараар нь (том, гурвалжин дүрс эсвэл улаан дугуй дүрс гэх мэт) ангилах, дараалуулах, давтамж үүсгэх			
36	Нэг юмсын байрлалаар нөгөө юмсын байрлалыг тодорхойлно, харааны баримжаагаар юмсын хол, ойрыг төсөөлөн тооцоолох			
37	“Өнөөдөр”, “маргааш”, “өчигдөр” гэсэн цаг хугацаа заасан үгсийг ялгах, хэрэглэх, үйл явдлын үргэлжлэх хугацааг баримжаалах			
Хөгжим, дүрслэх урлаг				
38	Хөгжмийн хэмнэл, хурдан удаан, чанга сулыг ялган сонсох, дуу авиа, хөдөлгөөн, үгээр илэрхийлэх (алга таших, толгой дохих)			
39	Дууг өнгө, хэмнэлийг алдалгүй хөгжмийн хамсраатай болон хамсраагүй дуулах			
40	Дуу авиа, зан байдал, хөгжмийн хэмнэлийг энгийн хөгжмийн зэмсгээр илэрхийлэн тоглох			
41	Дуу, хөгжмийн агуулга, дүрийн онцлогийг хөдөлгөөн, нүүрний хувирлаар илэрхийлэн харуулах, аялгууны хэмнэлд тохируулан хөдөлгөөн гүйцэтгэх			

42	Хүрээлэн буй орчны юмс, үзэгдэл, үйл явдал, санаа бодлоо зургаар илэрхийлэх, бусадтай хамтран бүтээл хийх, зурж буй зүйлдээ бүтээлчээр хандах			
43	Баримлын шавар, зуурмаг, цас, элсээр эд зүйлс, хүн, амьтан дүрслэх			
44	Төрөл бүрийн материал (цаас, картон, бөс даавуу, үр жимс)-аар бүтээлчээр дүрслэн наамал хийх			
45	Барьж байгуулах, эвлүүлж угсрах, бүтээсэн зүйлсийн агуулга, дүрслэлийг баяжуулах			

ЗАРИМ НЭР ТОМЬЁНЫ ТАЙЛБАР

Нэр томьёо	Тайлбар
Сургалтын хөтөлбөр	Сургуулийн өмнөх боловсролын түвшинд хүүхдийн хүрэх үр дүн буюу эзэмших мэдлэг, чадвар, дадал, хандлага, хэрэгжүүлэх арга замыг тодорхойлсон сургалтын баримт бичиг
Чадамж	Мэдлэг, чадвар, хандлагын цогц
Чадвар	Эзэмшсэн арга туршлагаа ашиглан, аливаа үйлийг гүйцэтгэх ур дүй
Сургуулийн өмнөх насны хүүхэд	Цэцэрлэгт хамрагдвал зохих 2-5 насны хүүхэд
Суралцахуйн чиглэл	Хүүхдийн бүх талын хөгжлийг хангах сургалтын бүрэлдэхүүн хэсэг
Суралцахуйн зорилт	Суралцах үйл ажиллагаагаар хүрэх үр дүн
Сурах үйл ажиллагаа	Хүүхдийн танин мэдэх, төлөвших үйл, үйлдлийн цогц
Сургалтын арга зүй	Суралцахуйг дэмжих үйл ажиллагааны арга, арга барил, аргачлалын цогц
Сургалтын технологи	Сургах, сурах үйл ажиллагааг хэрэгжүүлэх үйлийн оновчтой горим, эрэмбэ дараалал
Сурах арга барил	Хүүхэд сурах үйл ажиллагаагаа төлөвлөх, зохион байгуулах, үнэлэх үйлийн цогц
Хичээл	Суралцахуйн чиглэл бүрээр зохион байгуулах сургалтын үйл ажиллагаа
Хөгжүүлэх үйл ажиллагаа	Цэцэрлэгт өдрийн дэглэмийн дагуу явагдах бүхий л үйл ажиллагаа
Цэцэрлэгийн үзэл баримтлал	Тухайн цэцэрлэгийн хамт олны хүүхдийг хөгжүүлж төлөвшүүлэх ажлын шийдэл, онцлог арга ухаан, өдөр тутмын ажилдаа баримтлах удирдамж
Цэцэрлэгийн сургалтын хөтөлбөр	Сургуулийн өмнөх боловсролын сургалтын хөтөлбөр, Цэцэрлэгийн үзэл баримтлалд үндэслэн орон нутгийн болон тухайн цэцэрлэгийн онцлог, хүүхдийн хөгжлийн хэрэгцээг тусган боловсруулсан сургалтын хөтөлбөр
Үнэлгээ	Сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийн явцад болон эцэст хүүхдийн эзэмшсэн чадамжийн төвшинг хэмжин тогтоох арга хэрэгсэл



**СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨРИЙГ
ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗӨВЛӨМЖ**

АГУУЛГА

ОРШИЛ	47
НЭГ. СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТЭД ҮЗҮҮЛЭХ ДЭМЖЛЭГ	50
1.1 НИЙГЭМШИХҮЙН ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ НЬ	50
1.2 СУРАЛЦАХУЙН ЧИГЛЭЛҮҮД БА ХҮҮХДИЙН ГҮЙЦЭТГЭХ ЖИШИГ ҮЙЛ	60
ХОЁР. СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ЗҮЙ.....	89
2.1 БАГШ, ХҮҮХЭД ХАМТДАА МЭДЛЭГ БҮТЭЭХ АРГА	89
2.2 БАГШ, ЭЦЭГ ЭХЧҮҮДИЙН ХАМТЫН АЖИЛЛАГАА	95
2.3 ТУСГАЙ ХЭРЭГЦЭЭТ БОЛОВСРОЛ ШААРДЛАГАТАЙ ХҮҮХЭДТЭЙ АЖИЛЛАХ АРГА ..	98
ГУРАВ. ХҮҮХДИЙН ХӨГЖЛИЙН ҮНЭЛГЭЭ	101
3.1 АЖИГЛАЛТ	102
3.2 ХУВИЙН ХАВТАС	105
3.3 ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС	107

ОРШИЛ

Сургуулийн өмнөх боловсролын сургалтын стандарт, үндэсний хөтөлбөрүүд нийгмийн өөрчлөлт, шинжлэх ухааны ололт нээлт, өөрийн орны онцлог, сайн туршлагад тулгуурлан сайжирч, боловсронгуй болсоор ирлээ. Бага, дунд боловсролын стандартын шинэчлэлийн хүрээнд боловсруулж хэрэгжүүлсэн 2005 оны “Сургуулийн өмнөх боловсролын стандарт”-аас эхлэн сургалтын стандарт, хөтөлбөрүүд хүүхдийн эзэмших компетенци (чадамж)-д баримжаалж, хүүхдэд юуг заах вэ гэдэгт бус, хүүхдийн хүрэх түвшинг тодорхойлсон гаралтад суурилах болсон.

Боловсролын хүрээлэнгээс 2018-2019 онд зарим аймаг, дүүрэгт явуулсан сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийн судалгаа, БСШУСЯ, Боловсролын хүрээлэн, БМДИ, их сургуулийн багш, судлаач, цэцэрлэгийн багш, арга зүйч, эрхлэгчдийг хамруулсан Үндэсний хэлэлцүүлгийн үр дүнгээс үзэхэд хөтөлбөрийн хэрэгжилтийн явцад дараах хүндрэл бэрхшээл тохиолдож байв.

- Сургалтын хөтөлбөр дэх чадварууд, тэдгээрийн түвшин, хүүхдийн жишиг үйл ерөнхий учир багш нарт цэцэрлэгийн сургалтын хөтөлбөр боловсруулахад хүндрэлтэй.
- Хүүхдийн хөгжлийн үнэлгээ хийж буй гүйцэтгэл багш нарт харилцан адилгүй, ажиглалтын хуудсын дагуу хийх ажиглалт нь ялангуяа норм хэмжээнээс хэт олон хүүхэдтэй бүлгийн багш нарт ачаалал өгдөг.
- Багшийн ажлын үнэлгээг хүүхдийн хөгжлийн үнэлгээтэй холбож ирсэн нь багшид ажил нэмдэг.

Эдгээр хүндрэл бэрхшээлийг арилгах, хэрэгжилтийг дэмжих зорилгоор БСШУСЯ-ны шийдвэрээр Боловсролын хүрээлэнгийн дэргэд байгуулагдсан ажлын хэсэг “Сургуулийн өмнөх боловсролын сургалтын хөтөлбөр”-ийг сайжруулж, түүнийг хэрэгжүүлэх зөвлөмжийн хамт багш нартаа хүргэж байна.

Сайжруулсан сургалтын хөтөлбөр ямар онцлогтой вэ?

- Хүүхдийн цогц хөгжил буюу бие бялдар, танин мэдэхүйн, нийгэмшихүйн хөгжлийн зорилтод тулгуурласан.
- Суралцахуйн чиглэл нь дээрх хөгжлийн хэрэгцээг хангахуйц, тэнцвэртэй байж хүүхэд бүрийг хөгжүүлэхэд чиглэсэн.
- Хүүхдийн эзэмших нийгэмшихүйн хөгжлийн агуулгыг бие даасан байдлаар тодорхойлсон.
- Сургалтын хөтөлбөрийн агуулга хүүхдийн сонирхол, өдөр тутмын амьдралд тулгуурласан байхад чиглэсэн.
- Хүүхдийн хөгжлийн үнэлгээ нь үр дүнгийн болон явцын гэсэн хоёр төрөлтэй ба хүүхдийн хөгжлийн ахиц өөрчлөлт, давуу талыг илрүүлэх, хүүхдийг хөгжүүлэх ажлын явц, үр дүнгийн хяналт, үнэлгээг хөгжүүлж дэмжих болсон.

Сургалтын хөтөлбөрийн зорилгыг хэрхэн ойлгох вэ?

Сургалтын хөтөлбөрийн зорилго нь бага насны хүүхэд бүрд бие, сэтгэлээр эрүүл өсөн бойжих, өөрийн онцлог, бүтээлч үйлээрээ хөгжин, бие бялдар, танин мэдэхүй, нийгэмшихүйн чадамж эзэмшихэд дэмжлэг үзүүлэхэд оршино гэж хөтөлбөрт тодорхойлсон.

“Бие, сэтгэлээр эрүүл өсөн бойжих” гэж юу вэ?

Хүүхдэд “өсөлт”, “хөгжил” гэсэн хоёр үйл явц тасралтгүй явагддаг. Өсөлтийн явцад тэдний бие махбод, эрхтнүүдэд хэмжээ, бүтцийн хувьд өөрчлөлт гарна. Бага насны хүүхдийн хувьд тэдэнд бие махбод болон сэтгэл санаагаар эрүүл өсөх боломжоор хангах нь насанд хүрэгчдийн эн тэргүүний зорилго юм.

Хүүхдийг бие махбодын талаас нь эрүүл өсгөхөд аливаа өвчин, осол гэмтлээс сэргийлэх, өвдсөн тохиолдолд яаралтай арга хэмжээ авах, багаас нь эрүүл ахуйн дадал эзэмшүүлэх зэрэг олон ажил багтана. Ялангуяа нийслэлд утаа, агаарын бохирдол ихтэйгээс өвлийн улиралд багш нар хүүхдээ гадаа агаар салхинд гаргаж, эрүүл мэндийг нь хамгаалж, бэхжүүлэх ажил орхигдох болсон. Мөн хот, суурин газар хүүхэд чөлөөтэй гүйж харайх, тоглож наадах зай талбай хязгаарлагдмал болов. Иймд багш нар ангийн орчинд болон урин дулааны үед, эцэг эхчүүд зуны улиралд бага насны хүүхдээ эрүүлжүүлж чийрэгжүүлэхэд улам илүү анхаарах шаардлага тулгарч байна. Түүнчлэн хүүхдийг зөв, зохистой хооллох асуудал ч чухлаар тавигдах болов.

Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас хүүхдийн эрүүл мэнд тухайлбал сэтгэцийн эрүүл мэндийг онцлон авч үзэж байна. Хүүхэд сэтгэл санааны хувьд тайван, эрүүл байх нь насанд хүрэгчдээс шууд хамааралтай. Айдас түгшүүргүй, дарамтгүй байх нь хүүхэд сэтгэл санаагаар эрүүл өсөн бойжиход эергээр нөлөөлдөг. Гэр бүл, цэцэрлэгийн халуун дулаан уур амьсгал, эелдэг зөөлөн харилцаа, хайр, халамж нь тэдний сэтгэл санааны таатай байдал, цаашилбал өөртөө итгэх итгэл, сурч мэдэх эрмэлзэл, идэвх зүтгэл, өөдрөг, бүтээлч байдал, бусадтай харилцах таатай суурийг бүрдүүлнэ. Иймд багш нар сургалтын хөтөлбөрт заасан сэтгэл зүйн орчныг бүрдүүлж ажиллахад анхаарна.

“Өөрийн онцлог, бүтээлч үйлээрээ хөгжих” гэж юу вэ?

Хөгжил гэдэг нь өсөлтөөс ялгаатай, хувь хүний олон талыг хамарсан, нийлмэл, цогц үйл явц билээ. Хөгжил нь “хүрээлэн буй орчны нөлөөгөөр бие организмд явагддаг биологийн процессын үр дүнд хүүхдийн бие махбод болон сэтгэц, зан төлөвт гарах дэвших хандлагатай чанарын өөрчлөлт юм” [Крайг, Г, 2000 он] Монголчуудын уламжлалт философид хүний “хөгжил”-ийг “бие, хэл, сэтгэл” гэсэн гурван талаас нь авч үзэж ирсэн байдаг.

Хүүхэд бүр ялгаатай, ижил насны хүүхэд ч мөн адил өөр байдаг. Тэд сонирхол, хэрэгцээ, суралцах хурд, арга барил, оюуны боломжоороо бие биеэс ялгагдах онцлогтой. Тусгай хэрэгцээ шаардлагатай хүүхэд ч бий. Хүүхдийн ялгаатай байдлыг хүндэтгэж, чадамж, онцлогийг нь таньж мэдэж, тухайн хүүхдэд тохирсон дэмжлэг үзүүлснээр хүүхэд бүрийг боломжит дээд хурдаар нь хөгжүүлэх боломжтой.

Бүтээлч байна гэдэг нь чөлөөтэй сэтгэх, шинэлэг санаа гаргах, өмнө нь сурч мэдсэн зүйлээ шинэ орчин нөхцөлд ашиглах, тулгарсан асуудлыг шийдэх арга замыг олох, уян хатан байх зэрэг шинэ зууны иргэнд шаардлагатай мэдлэг, чадвар агуулдаг. Бүтээлчээр үйл гүйцэтгэх нь хүүхдийн өөрийн удирдлагатай суралцахуй, насан туршийн боловсролд чухал нөлөөтэй. Өөрийн удирдлагатай суралцахуй нь хүүхэд өөрийн хөгжил дэвшил, хүрсэн үр дүнгээ мэдэрч, өөртөө итгэлтэй болох, өөрийгөө таньж мэдэх, цаашдын суралцах үйлээ бие даан шийдэж зохицуулах зэрэг олон талын ач холбогдолтой. Насан туршийн боловсрол нь хувь хүний сурч мэдэх гэсэн хүсэл эрмэлзэл, зүтгэл чармайлтаас голлон шалтгаалдаг. Иймд сургуулийн өмнөх насанд хүүхдэд тэдний хамгийн дуртай үйл болох тоглох явцдаа хөгжих, аливаа үйлээ бүтээлчээр гүйцэтгэх боломж олгох, элдэв дарамт шахалтгүйгээр төрөлхийн сонинч занг нь улам өдөөж, сурч мэдэх гэсэн хүсэл сонирхолыг төрүүлэхэд багш нар анхаарч ажиллах нь чухал.

Хүүхэд сургуулийн өмнөх насандаа ямар мэдлэг, чадвар, хандлагатай болохыг сургалтын хөтөлбөрийн зорилгоор тодорхойлон томъёолжээ. Хүүхэд нийгэмшихүй болон суралцахуйн чиглэлүүдээр ямар үр дүнд хүрэхийг тэдгээрийн “Хүрэх үр дүн”-гээр тодорхойлсон.

Сургалтын хөтөлбөрийн агуулгыг хэрхэн ойлгох вэ?

21 дүгээр зуунд олон улсын байгууллага болон дэлхийн улс орнуудын баримталж буй боловсролын чиг хандлага, үзэл санаанаас үзэхэд боловсролын зорилго нь насан туршийн боловсрол, агуулга нь компетенци (“цогц чадамж”, “чадамж”) байна гэж тодорхойлох болсон. Энэ нь маш хурдацтай өөрчлөгдөн байгаа өнөөгийн нийгэмд хувь хүний эзэмшсэн мэдлэг, чадварын хадгалагдах болон хэрэглэгдэх хугацаа ямагт богиносож байгаатай холбоотой.

Иймд манай улсын аль ч шатны боловсролын зорилго, агуулга, арга зүй, үнэлгээ бүхэлдээ компетенцид суурилан, түүн дотор хувь хүний төлөвшилд ихээхэн анхаарах болов. Үүнтэй уялдан хүний хөгжлийн үндэс бүрэлдэх насанд багш нар хүүхдийн төлөвшилд түлхүү анхаарах шаардлага тулгарч байгаа учраас сургалтын хөтөлбөрт хүүхдийн эзэмших нийгэмшихүй (хуучнаар “зан чанар, харилцаа”)-н чадваруудыг суралцахуйн чиглэлүүдийн чадвараас тусад нь томъёолж, зөвлөмжид жишээгээр харуулсан болно.

Сургалтын хөтөлбөрийн зорилго, зорилтыг хэрэгжүүлэх агуулгыг нийгэмшихүйн болон суралцахуйн чиглэл тус бүрээр хүүхдийн эзэмших чадвар буюу хөгжлийн хүрэх үр дүнгээр тодорхойлсон.

Чадваруудыг хүүхдийн нас, хөгжлийн онцлогийг харгалзсан гурван түвшнээр тодорхойлсон бөгөөд чадвар тус бүр хөнгөнөөс хүнд рүү чиглэсэн гурван түвшинтэй байна. Чадваруудын “I” түвшин 2 нас, “II” түвшин 3-4 нас, “III” түвшнийг 5 настай хүүхдэд баримжаалж болно. Энэхүү гурван түвшин нь хүүхдийн өмнөх төсөөлөл, мэдлэг, туршлагад тулгуурлан шинэ зүйлийг мэдэх болон тодорхой нөхцөлд хэрэглэх чадвар, хандлагыг хөгжүүлэхэд чиглэнэ.

Багш нар хичээл, хөгжүүлэх үйл ажиллагаагаа төлөвлөх, сэдвийн боловсруулалт хийхдээ энэхүү зөвлөмжийн нэгдүгээр хэсэгт буй хүүхдэд эзэмшүүлэх чадвар тус бүрийн “Хүүхдийн жишиг үйл”-ээс санаа авч бүтээлчээр ажиллана уу.

Зөвлөмжид мөн сургалтын чиглэл бүрээр ашиглах аргууд, хэрэглэгдэхүүн, хүүхдийн хөгжлийн үнэлгээ, тусгай хэрэгцээ шаардлагатай хүүхэд, түүнчлэн эцэг эхтэй хэрхэн хамтарч ажиллах асуудлуудыг жишээгээр тодруулан тусгалаа.

НЭГ. СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТЭД ҮЗҮҮЛЭХ ДЭМЖЛЭГ

Сургуулийн өмнөх боловсролын сургалтын хөтөлбөрийн агуулга нь хүүхдийн эзэмших чадвар, тэдгээрийн гурван түвшнээс бүрдсэн. Эдгээр түвшинд хүргэхэд хүүхдийн хийж болох “Хүүхдийн жишиг үйл”-ийг тодруулан харууллаа.

1.1 НИЙГЭМШИХҮЙН ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ НЬ

Бага насны хүүхэд гэр бүлийн орчноос цэцэрлэгийн орчинд орсноор тэдэнд өөрийгөө илэрхийлж ойлгуулах, хүүхдүүдтэй тоглох, олон хүүхдийн дунд тайван, хүлээцтэй байх гээд багагүй асуудал тулгарна. Эдгээр сорил бэрхшээлийг даван туулахад хүүхдийн зан үйл, харилцах чадвар, эерэг хандлага чухал нөлөөтэй. Багш нийгэмшихүйн чадварыг хүүхдэд суралцах үйл болон цэцэрлэгийн өдөр тутмын бусад үйл ажиллагаагаар хэрхэн эзэмшүүлж болохыг дараах жишээгээр танилцуулж байна.

Хүснэгт 1. Нийгэмшихүйн хөгжлийг дэмжих жишээ

Агуулга			
	I түвшин	II түвшин	III түвшин
	Бие, сэтгэлийнхээ тааламжтай ба тааламжгүй байдлыг мэдрэх, илэрхийлэх	Дуртай, дургүй, сонирхсон зүйлээ илэрхийлэх	Санаа бодлоо илэрхийлэх, хамгаалах
	Хүүхдийн жишиг үйл		
1.Өөрийгөө мэдрэх, илэрхийлэх	<ul style="list-style-type: none"> Тааламжгүй байдлаа уйлах, уцаарлах, дуугаа хураах гэх мэтээр илэрхийлнэ. Өлсөх, цангах, бие засахаа мэдэж, дохио зангаа, үгээр ойлгуулна. Сонирхсон тоглоом (хүүхэлдэй, машин, эвлүүлдэг соронзон тоглоом, эвлүүлдэг тоглоом гэх мэт)-оо сонгож аваад баярлана. Өөрийгөө толинд хараад хөдөлгөөнөө ажиглаж тоглоно. Дургүй зүйлээ “үгүй”, сэтгэлд нийцсэнээ “гоё” гэсэн үгээр илэрхийлнэ. 	<ul style="list-style-type: none"> Дуртай, дургүй зүйл (тоглоом, хувцас гэх мэт)-ээ нэрлэнэ. “Хэн юу хийх вэ?” тоглоомын дагуу хүүхдүүд өөрийн хийх дуртай үйл (өрж байгуулах, зохион бүтээх, эвлүүлэх гэх мэт тоглоомоор тоглох, ном үзэх, зураг зурах, жижүүр хийх)-ийн зургийг сонгоно. Өөрийн дуртай сургалтын төв, тоглоом, хэрэглэгдэхүүнээ сонгож тоглоно. Төрөл бүрийн эд зүйл барьж мэдрэх, нэрлэх дасгал хийнэ, тоглоом, тоглоно. Дуртай зүйлээ зурах, наах, барих гэх мэт үйлээр илэрхийлж харуулна. Өөрт тохиолдсон үйл явдлаа бусдад хэлж ойлгуулна. Жишээ нь: Гадаа гүйж байгаад өвдгөөрөө унасан. Их өвдсөн гэх мэт. Эрэгтэй, эмэгтэй хүүхдийг ялгаж (хувцас, үс гэх мэтээр) зурна. Чихэрлэг болон исгэлэн амттай зүйлс (чацаргана, лимон, алим, аарц, ааруул) амталж, таалагдаж байгаа эсэхээ хэлнэ. 	<ul style="list-style-type: none"> Яагаад баярлаж, уурлаж, гомдсон, уйтгарласан шалтгаанаа бусдад тайлбарлан ярина. Жишээ нь: Өнөөдөр аав намайг цэцэрлэгт хүргэж ирсэн болохоор би баярласан. Дуртай тоглоомоо ангидаа авч ирэх гэтэл ээж зөвшөөрөөгүй учраас уйлсан. Тоглоомын явцад өөрсдөө хэнтэй тоглох, ямар дүр, хэрэглэгдэхүүнээр тоглохоо сонгоно. Музей, үзвэр үзэх, аялал зугаалгын үед өөрт төрсөн сэтгэгдэл (Юу нь гоё байсан, аль баатар нь таалагдсан гэх мэт)-ээ ярина. Уламжлалт баяр, гэр бүлийнхэн, найзаа зурна, барина, наана, зохион бүтээнэ. Хамт жижүүр хийх хүүхдээ сонгоно, ажлаа хуваарилна. Тоглохдоо өөрийн санаагаа бусдад ярьж хэлнэ. Үлгэр, зохиолын үйл явдлаас төрсөн сэтгэгдлээ найз нартаа ярина.

	I түвшин	II түвшин	III түвшин
	Хувцсаа өмсөх, тайлах, хоолоо идэх зэрэг үйлийг хийх, чадахгүй зүйлдээ бусдаас туслалцаа хүсэх	Өдөр тутмын үйл ажиллагаа (жижүүр хийх, тоглох гэх мэт)-нд бүтээлчээр, бие даан оролцох	Тоглох, сурах үйлд санал гаргах, эрэл хайгуул хийх, эхэлснээ дуусгах
2. Өөртөө үйлчлэх, оролцоотой байх	Хүүхдийн жишиг үйл		
	<ul style="list-style-type: none"> • Өөрийн хувцсаа бусад хүүхдийн хувцсаас ялгаж таних, хувцаслах оролдлого хийнэ. • Ямар хувцас өмсөхийг асуухад хуруугаараа заах, толгой дохих зэргээр хариулна. • Насанд хүрэгчдийн дэмжлэгтэйгээр амаа зайлна, нүүр, гараа угаана. • Өөрийн алчуур, сам, гарын савангаа зааж үзүүлнэ, нэрлэнэ. • Халбагаа зөв барьж хооллоно, өөрийн аяга халбагаа танина, бусадтай солихгүй хэрэглэнэ. • Хоолоо асгалгүй иднэ. 	<ul style="list-style-type: none"> • Аяга, таваг, халбага сэрээг ширээн дээр байрлуулах, хураах, ширээ арчих, ороо засах, хураах зэрэг үйлийг бие дааж, бусдын туслалцаатай гүйцэтгэнэ. • Сандлаа зөөнө, хураана, тоглож дуусаад тоглоомоо байранд нь хураана. • Хэрэглэсэн зүйл (оо, сойз, тоглоом, сургалтын хэрэглэгдэхүүн)-ээ буцааж байранд нь тавина. • Ширээ болон шалан дээр асгарсан зүйлийг санаачилгаараа бие даан арчина. • Хичээлийн хэрэгслүүдийг цэвэрлэх, хураахад оролцоно. 	<ul style="list-style-type: none"> • Нийтийн хоол, зууш, жүүс, жимс зэргээс өөрийн идэх, уух хэмжээнд тохируулан сонгож авна, дуустал нь иднэ, ууна. • Хоолны ширээ засах, хураах, ширээ арчих, ороо засах, хураах зэрэг үйлийг бие даан, найз нартай хамтран гүйцэтгэнэ. • Ширээ, сандлаа хурааж цэгцлэх, тоглож дуусаад тоглоомоо байранд нь цэгцлэж өрж байрлуулна. • Бие дааж гараа угаах, амаа зайлах, сам, оо, сойзоо байранд нь буцааж тавина. • Ширээ болон шалан дээр асгарсан зүйлийг бие даан, санаачилгаараа арчина.

	I түвшин	II түвшин	III түвшин
	3. Сэтгэлийн хөдөлгөөнөө зохиистой илэрхийлэх	Сэтгэлийн хөдөлгөөнөө үйл хөдлөл, үгээр илэрхийлэх	Сэтгэлийн хөдөлгөөнийхөө учир шалтгааныг тайлбарлах
Хүүхдийн жишиг үйл			
<ul style="list-style-type: none"> Насанд хүрэгчид мэндлэхэд хариу мэндэлж, баярлалаа, гялайлаа гэж хэлнэ. Дуртай тоглоомоороо тоглох, ном үзэх, бэлэг авах зэрэгт алга таших, инээх, хуруугаараа заах, үсрэх зэргээр баярлаж байгаагаа харуулна. Хүмүүсийн баярласан, уурласан дуу авиаг сонсоод нүүрний хувирал, биеийн хэлээр хариу үйлдэл үзүүлнэ. Таагүй зүйл (тоглоомоо булаацалдах, бүдэрч унах, айх, цочих гэх мэт) тохиолдоход уйлах, хуруу гараараа заах, дуугаа хураах зэргээр өөрийгөө илэрхийлж, ойр дотны хүмүүс (ээж, аав, ах эгч)-ээ хараад тайвширна. 		<ul style="list-style-type: none"> Хуруун хүүхэлдэй, ширээний театр, жүжигчилсэн тоглолт, сэдэвт үйлийн тоглоомоор тоглох явцад инээх, хашхирах, алгаа таших, үсрэх зэргээр өөрийн сэтгэлийн хөдөлгөөнөө илэрхийлнэ. Сэтгэлийн хөдөлгөөн (уурласан, инээсэн, уйлсан гэх мэт)-ийг илэрхийлсэн нүүрний хувиралтай зургийг ялгаж нэрлэнэ. Бусдын сэтгэлийн хөдөлгөөн (уурлах, баярлах, гомдох, ярвайх)-ий илрэлийг мэдэрч, инээх, аргадах зэргээр хариу үйлдэл үзүүлнэ. Найз нар нь тусалсан, тоглоомоо хуваалцаж тоглосон зэрэгт баярлалаа гэж хэлнэ. 	<ul style="list-style-type: none"> Тоглоом, зугаалга, уралдаан тэмцээний үед уурласан, гомдсон, бухимдсан үедээ өөрийгөө тайвшруулах арга замуудыг хэрэглэнэ. Жишээ нь: Ойр орчиндоо байгаа насанд хүрэгчдэд болсон зүйлсээ хэлж тайвшрах, бусдаас холдож дуугаа хураах, тоо тоолох. Тоглоомоо булаацалдах, нэг нэгэнтэйгээ мөргөлдөх, хөл дээр нь гишгэх зэрэгт “уучлаарай”, “зүгээр ээ” гэх мэт өелдэг үг хэлнэ. Баяртай, хөгжилтэй, ууртай, гунигтай байгаагаа үгээр хэлнэ. Жишээ нь: Аами Таами хоёр хөгжилтэй санагдсан. Ангиараа музей үзэхэд сонирхолтой байсан. Миний тоглоомыг булааж авсан болохоор уур хүрсэн. Хүүхдийн сэтгэл хөдлөл харуулсан зургийг хараад гаргадаг авиаг үзүүлнэ. Жишээ нь: Уйлах-ий, ий, инээх- ха, ха, уурлах-фү, фү сэтгэл хөдлөлд шилжүүлэх Уур ямар хор уршигтайг үлгэр, зохиол, сургамжит өгүүллэг, зүйр цэцэн үг сонсож ярилцана. Жишээ нь: Уул морийг зовооно, Уур биеийг зовооно.
4. Асуудлыг өөрийн хэмжээнд шийдвэрлэх	I түвшин	II түвшин	III түвшин
	Тулгарсан асуудлаа мэдэгдэх, бусдын дэмжлэгийг хүсэх	Асуудал, зөрчлийг өөрийн хэр хэмжээнд шийдвэрлэх	Тоглох, ажил үйл гүйцэтгэх явцад тулгарах асуудлыг бие даан шийдвэрлэх, асуудлыг шийдэх боломжит хувилбаруудыг санал болгох
	Хүүхдийн жишиг үйл		
<ul style="list-style-type: none"> Бэрхшээлтэй зүйл тулгарахад насанд хүрэгчдийн дэмжлэгийг хүсэж, дуу хоолой, үйл хөдлөл, үгээр илэрхийлнэ. Бусадтай муудалцах, тоглоомоо булаацалдах явцад асуудлыг багш, эцэг эхийн тусламжтай шийднэ. 	<ul style="list-style-type: none"> Хүний зан үйл, харилцаатай холбоотой дуу, шүлэг, үлгэр, сургамжит өгүүллэг сонсоод сайн, муу, сайхан, муухай, буруу, зөв гэсэн үгийн утгыг ойлгоно, саналаа хэлнэ. Буруу зүйл хийвэл, түүнийгээ ухаарч найз нөхдөөсөө уучлалт хүснэ. Асуудлыг хэрхэн шийдсэн тухай үлгэр, өгүүллэг, түүх сонсож, өөрийн дүгнэлтээ хэлнэ. Тоглоомын дүрэм, анги, сургалтын төвүүдийн дүрмийг зөрчихгүй байна. 	<ul style="list-style-type: none"> Найз нөхдөө хүндэлж буруугаа хүлээх, найз нөхдөөсөө уучлалт хүснэ. Хүүхдүүдтэй зэрэгцэж ярих, найзыгаа цохиж авах, түлхэж унагах, тоглоомыг нь булаах нь харилцаанд сөрөг нөлөөтэй тухай ярина. Найзтайгаа муудалцсан тохиолдолд яаж шийдэх санал гаргана. Тоглоомын үед гарсан асуудлыг шийдэх саналаа чөлөөтэй гаргаж дүрмээ ярилцаж зохионо. 	

	I түвшин	II түвшин	III түвшин
	Хүмүүсийн сэтгэлийн хөдөлгөөнийг нүүрний хувирал, дуу хоолойн өнгө, хөдөлгөөнөөр ялгах	“Би” бусдаас ялгаатай гэдгээ мэдэрч таних, ойлгох, өөрийнх нь үйлдэл бусдад нөлөөлж буйг мэдэж харилцах	Хүмүүсийн сэтгэлийн хөдөлгөөн өөр өөр байдгийг мэдэх, зохицон харилцах
5.Бусдыг мэдэрч ойлгох	Хүүхдийн жишиг үйл		
	<ul style="list-style-type: none"> • Ойр дотны аав, ээж, ах, эгч гэх мэт хүмүүсийн дуу хоолойг бусад хүмүүсийн дуу хоолойноос ялган таньж, хэн болохыг хэлнэ. • Насанд хүрэгчдийн инээх, өхөөрдөх, хайрлах гэх мэт сэтгэлийн хөдөлгөөнийг мэдэрч, инээмсэглэх, тэмүүлэх зэргээр хариу үйлдэл үзүүлнэ. 	<ul style="list-style-type: none"> • Бусад хүүхэдтэй хамтарч тоглохдоо өөрийнхөө хүсэл, сонирхлыг илэрхийлж чадахгүй байгаа найзыгаа тоглоомдоо урин хамтран тоглох, ярилцах нь сайн үйл гэдгийг мэдэрч, сэтгэл хангалуун байна. • Ангид шинээр ирсэн хүүхэдтэй санаачилгаараа ярилцана, тусална. • Оньсого, таавар таах, шүлэг унших, мөрийг гүйцээж хэлэх гэх мэт үйлийг хийж чадахүй байгаа найздаа тусалсандаа сэтгэл хангалуун байна. 	<ul style="list-style-type: none"> • Үлгэр зохиолын дүрд жүжигчлэн тоглохдоо дүрүүдийн хоорондын харилцааг илэрхийлж тоглоно. Жишээ нь: Монгол ардын үлгэр “Ах дүү гурав”, орос ардын үлгэр “Алтан загасны үлгэр”, “Тариан түрүүхэн” • Уралдаант тоглоом (буухиа тоглоом, бөх барилдах, уралдах гэх мэт)-д хожсон, хожигдсон тохиолдолд бусад хүүхэд ямар сэтгэлийн хөдөлгөөн (баяр хөөртэй, сэтгэл дундуур, уурласан гэх мэт) үзүүлж байгааг мэдэрч, илэрхийлж хэлнэ. • “Та битгий уурлаарай” тоглоом тоглохдоо сэтгэлийн хөдөлгөөнөө зохистой (хүлээцтэй, бие биеэ сонсох, ээлжээ хүлээх) илэрхийлэн тоглоно. • Найзыгаа уйтгартай байхад нь тайтгаруулна. Жишээ нь: Тоглоомоо өгөх, гараас нь хөтлөх, үсийг нь илэх, нулимсыг нь арчих.

	I түвшин	II түвшин	III түвшин
	Хүүхэд талархал, дургүйцэл, сэтгэлд нийцэж байгаагаа үг, үйл хөдлөлөөрөө илэрхийлэх	Насанд хүрэгчидтэй мэндчилгээ, талархлын үгс хэлж харилцах, шаардлагатай үед тусламж хүсэх, хүссэн тохиолдолд тэдэнд туслах	Насанд хүрэгчдээс сонирхсон зүйлээ асуух, хүсэлт гуйлтыг нь биелүүлэх, хүндэтгэн харилцах
6.Насанд хүрэгчидтэй харилцах	Хүүхдийн жишиг үйл		
	<ul style="list-style-type: none"> • Сайн байна уу, баяртай гэж хэлнэ, толгой гарын хөдөлгөөнөөр илэрхийлнэ. • Бөмбөг, машин, хүүхэлдэй гэх мэт тоглоомоор тоглохдоо гүйх, үсрэх, шидэх зэрэг хөдөлгөөнийг насанд хүрэгчидтэй хамтран гүйцэтгэнэ. • Цагаан сар, шинэ жил зэрэг уламжлалт баярын өглөөлөг, өдөрлөгт насанд хүрэгчдийн дэмжлэгтэйгээр оролцоно. 	<ul style="list-style-type: none"> • Хоол, цай, тоглоом, бэлэг өгөхөд баярлалаа гэж хэлнэ. • Таньдаг хүн (хамаатан садан, багш, тогооч)-тэй мэндчилнэ. • Ярилцаж байгаа хүнийхээ нүд рүү эгцлэн харж, үгийг анхааралтай, дуустал нь сонсоно. • Төөрчихвөл чамд хэн туслах вэ?, Хэн нэгэн чамайг дээрэлхвэл хэн хамгаалах вэ? зэрэг асуултын дагуу зургуудыг харуулахад ээж аав, багш, цагдаа, эмч гэх мэт өөрт нь тусламж үзүүлэх боломжтой хүнийг зааж нэрлэнэ. • Гутлаа үдэх, хувцсаа товчлох, цахилгаандах, үсээ самнах гэх мэт үйл хийж чадахгүй байгаа тохиолдолд насанд хүрэгчдээс тусламж хүсч хэлнэ. Жишээ нь: Та миний товчыг товчлоод өгөөч, Миний машин энэ доогуур ороод алга болчихлоо. Машинаа яаж олох вэ? • Багш, туслах багш (ээж аав, ах эгч)-ийн хүссэн зүйлс (алчуур, аяга, таваг гэх мэт)-ийг авчирч өгнө. 	<ul style="list-style-type: none"> • Мэндлэх, хүндлэх, үдэх, талархал илэрхийлэх үгс (та, таны, гуай)-ийг хэлнэ. • Хүмүүсийн харилцааны тухай үлгэр, өгүүллэг сонсоно, сайн, муу талын баатрын зан чанарт дүгнэлт өгч, санаагаа илэрхийлэн хэлнэ. • Уучлаарай, Би энүүгээр гарч болох уу; Та үүнийг аваад өгөөч, надад тусална уу; би чадахгүй байна, яаж хийх вэ гэх мэт эелдэг үгсийг хэлнэ. • Юу сайн бэ?, Юу муухай вэ? Яагаад? гэх мэт асуултаар хүмүүстэй харилцахдаа эрхэмлэх зүйлс, учир шалтгааны тухай асууж, ярилцана. Жишээ нь: Яагаад бусдын эд зүйлийг зөвшөөрөлтэй авах вэ, найзынхаа толгой, мөр зэрэг биед хүрэхгүй байх вэ, дэлгүүр, үзвэрийн газар дарааллыг алдагдуулан хүний өмнүүр дайрвал, хоол, зууш, амттанаас өөрийн идэх хэмжээнээс илүү аваад идэж дуусгахгүй үлдээвэл, ахмад хүмүүс, охидод зам тавихгүй бол яах вэ гэх мэт ярилцана.


	I түвшин	II түвшин	III түвшин
7. Үеийн хүүхдүүдтэй харилцах	Бусдын дунд багш (насанд хүрэгчид)-ийн тусламжтайгаар тоглоом, эд зүйлсийг хэрэглэх	Бусадтай хамтран тоглох, ажил үйл гүйцэтгэх	Санаа бодлоо бусдад ойлгуулан, найзтайгаа найрсаг, нээлттэй харилцах
	Хүүхдийн жишиг үйл		
	<ul style="list-style-type: none"> Сайн уу? Баяртай гэх мэт үг хэллэг хэрэглэнэ. Дуртай тоглоомоороо бусадтай хамт тоглохдоо Минийх, Надад өгөөч гэх мэт үгийг хэрэглэнэ. Зугаалгын явцад найзтайгаа хөтлөлцөн явна. Бие засах, гараа угаахдаа өөрийн ээлжээ хүлээнэ. 	<ul style="list-style-type: none"> Ангийн эд зүйлсийн байрлалыг өөрчлөх, тоглоом наадгай угаах, туршилтын талбайд ажиллах зэрэг ажил үйлд бусадтай саналаа солилцож, ажлаа хуваарилан оролцоно. Бусдын эд зүйлд зөвшөөрөлгүй хүрэхгүй, авахгүй байна. Бусдын буруу үйлдэл (хог ил хаях, бүдүүлэг үг хэлэх, найзынхаа тоглоомыг булаах, нэг нэгнийгээ цохих)-ийг дуурайхгүй байна. Туслалцаа, хүндлэлд баярлаж талархсан, зөвшөөрсөн, уучилж байгаагаа хэлнэ. 	<ul style="list-style-type: none"> Бусдыг хэцүү байхад (унах, айх, уйлах) аргадна, тусална, шоолж инээхгүй байна. Буруу зүйл хийвэл алдаа (бусдын юмыг зөвшөөрөлгүй авах, ангийн дүрэм зөрчих)-аа ойлгож, уучлал хүснэ. “Бамбар, тугал хоёр”, “Алимны мод” гэх мэт нөхөрлөлийн тухай үлгэр, өгүүллэг сонсоод, дүрүүдийн хоорондын харилцаанд өөрийн дүгнэлт өгч, саналаа хэлнэ. Анги хамт олноороо тодорхой асуудал (анги, төвийн дүрэм зохиох, нэгнийгээ гомдоосон асуудлыг ярилцах)-аар ярилцах, хэлэлцэх явцад бусдын үгийг дуустал нь, анхааралтай сонсоно, өөрийн санаа бодлоо хэлнэ, бусдын гаргасан санаа өөрт нь таалагдаж байвал дэмжиж байгаагаа илэрхийлж хэлнэ.
8. Бусад хүүхэд (өөрөөсөө насаар ах, дүү)тэй харилцах	I түвшин	II түвшин	III түвшин
	Бусад хүүхдийн тоглох, хийж буй үйлийг ажиглах, хөдөлгөөн, үг хэллэгийг дуурайх	Тоглоом наадгай, эд зүйлээ хуваалцах, ээлжээ хүлээх, хамтрах, өөрөөсөө ах, эгч хүүхэдтэй хүндэтгэлтэй харилцах	Бусад хүүхэдтэй багаар үйл гүйцэтгэх, өөрөөсөө бага насныханд туслах, халамжлах
	Хүүхдийн жишиг үйл		
<ul style="list-style-type: none"> Багш болон бусад хүүхэдтэй нуугдаж тоглоно. Аялал, зугаалгын явцад чулуу, навч, мөчир түүж, ахлах насныханд өгнө. “Тоорой, тоорцог, тогоруу” тоглоомын хөдөлгөөнийг бусдыг дагаж хийнэ. “Манжин”, “Улаан малгайт” зэрэг үлгэрийн баатруудын үгийг ах, эгч насныхныг дуурайн хэлнэ. Өрж байгуулах тоглоомоор бусад хүүхдийн барьж байгуулж буй зүйлсийг ажиглана, нурааж бусниулахгүй байна. Бусад хүүхэдтэй хөөцөлдөж тоглоно. 	<ul style="list-style-type: none"> Хэсэг бүлгээрээ сонирхлоороо нэгдэн, өрж байгуулах, эвлүүлэх, спорт өрөлт зэрэг тоглоомоор хамтран тоглоно. Хуруун гогдоо, хөлөгт тоглоом болон бусад дүрэмтэй тоглоомоор ээлжээ хүлээж тоглоно. Айл гэр, Дэлгүүр гэх мэт сэдэвт тоглоомын дүрийг хуваарилахад багачуудыг оролцуулан хамтдаа тоглоно. Гадаа талбайд гулсуур, савлуур, дүүжин даажин дээр тоглохдоо дарааллаар зогсож, ээлжээ хүлээнэ. Ингэхдээ бага насныханд анхаарал тавьж, эхэлж тоглуулна. 	<ul style="list-style-type: none"> Дүрэмтэй тоглоом болон хөгжөөнт буухиа тоглоом (“Би сагчин”, “Над руу гүйгээрэй”) -оор тоглохдоо бусдыг сонсож, дүрмийг баримтлан тоглоно. Цаасан хайрцаг ашиглан барилга, машин, хашаа гэх мэт зүйлсийг томоор байгуулж (нааж, зурж, чимэглэж) дотор нь орж тоглоно. Өөрөөсөө бага насныханд чадахгүй байгаа зүйл (хувцсаа өмсөх, тайлах, гар нүүрээ угаах, ороо засах)-д нь тусална. Бага насны хүүхдийг өөртөө туслуулж, дагуулж хамтдаа ангийн жижүүр хийнэ. “Цэвэр агаар”, “Алтан намар” гэх мэт аяллаар явахдаа хэсэг, бүлгээрээ, сонирхлоороо “Хөл бөмбөг”, “Алтан гинжийг таслах”, “Муур хулгана” гэх мэт тоглоом тоглоно. Ингэхдээ бага насныхныг оролцуулна. Гадаа зугаалахдаа бага насны дүү нарын гараас нь хөтөлж явна. Ширээний театр, жүжигчилсэн тоглолт бэлтгэн бага насныханд тоглож үзүүлнэ. 	

9. Орчны өөрчлөлтөд дасах	I түвшин	II түвшин	III түвшин
	Гэр бүлийн орчноос цэцэрлэг ялгаатай гэдгийг мэдэрч, дасан зохицох	Цэцэрлэгийн амьдрал, үйл ажиллагаанд оролцох	Өөр өөр орчин (бусад анги, танхимд, шинэ хүүхэдтэй)-д үйл ажиллагаанд идэвхтэй оролцох
	Хүүхдийн жишиг үйл		
<ul style="list-style-type: none"> Өөрт ойр дотно байгаа хүнийг мэдэрч, дагана. Багш, туслах багштайгаа тоглох, ярилцах зэргээр ойртож дотносно. Багш, туслах багшийн тусламжтайгаар үйл ажиллагаа (өглөөний дасгал хийх, тойргоор зогсох, амаа зайлах, гараа угаах)-нд оролцоно. Сонирхсон тоглоомоороо тоглоно. Өөрт таалагдсан тоглоомын төвд очиж тоглоно. Ангийн хүүхдүүдтэй хамт хооллоно. Хуваарийн дагуу унтна. 	<ul style="list-style-type: none"> Ангидаа бусад хүүхэдтэй тоглох, дасгал хөдөлгөөн хийх, хоолоо идэх, нойрсох зэрэг өдөр тутмын үйл ажиллагаанд оролцож, өөрийн санаа бодол (унтахыг хүсдэг, хүсдэггүй, ямар тоглоомоор тоглох дуртай)-оо хэлнэ. Багшийн сануулгатайгаар амаа зайлах, гараа угаах, шүдээ угаах, хувцсаа өмсөх, тайлах, эвхэх зэрэг үйл гүйцэтгэнэ. Зөөлөн буйдан дээр хэвтэх, жижиг майхан дотор орж тоглох, номын төвд ном үзэх зэргээр өөрийн дуртай газраа сонгож тоглоно. Тоглоом болон сургалтын төвүүд, номын өргөөнд ганцаараа болон найзтайгаа тоглоно, үйл гүйцэтгэнэ. 	<ul style="list-style-type: none"> Хүүхдүүд гэртээ, цэцэрлэгтээ хийдэг үйлүүдийн тухай ярилцана. Цэцэрлэгийн бусад анги танхимд зочлохдоо тэнд байгаа зүйлстэй танилцаж, ангийнхаа эд зүйлстэй харьцуулж, санаа бодол (танай ангид загас, тоть байна, ном, тоглоом нь өөр байна гэх мэтээр хэлбэр, хэмжээ, өнгө, дүрс, олон цөөнөөр нь харьцуулж)-оо бусадтай хуваалцана. Бусад бүлгийн хүүхдүүдтэй буухиа тэмцээн зохион байгуулахад оролцоно. Хөгжим, биеийн тамирын танхим, гал тогоо гэх мэт өрөөнүүдтэй танилцана. Жишээ нь: Гал тогоонд юу юу байдаг, тогооч ямар багаж хэрэгсэл, хувцас хэрэглэдэг, юу хийдэг. 	
10. Хүмүүсийн хоорондох ялгаатай байдлыг ойлгох, хүндэтгэлтэй хандах	I түвшин	II түвшин	III түвшин
	Хүн бүр өөр гэдгийг мэдэрч, ялгаж заах, нэрлэх	Хүмүүс (хүүхдүүд) хүйс, царай зүс, зан ааш, чадвар, биеийн онцлогоороо ялгаатай гэдгийг мэдэх, хүлээн зөвшөөрч харилцах	Өөр хэл, соёлтой хүмүүсийг сонирхох (асуулт асуух), тэдэнтэй хүндэтгэлтэй харилцах
	Хүүхдийн жишиг үйл		
<ul style="list-style-type: none"> Гэр бүлийн гишүүд (өвөө, эмээ, аав, ээж, ах, эгч, дүү гэх мэт), багшийн зургийг харуулаад Энэ хэн бэ? гэж асуухад заана, нэрлэнэ. Зурагт үзүүлэн эсвэл карт дээрх (нялх хүүхэд, эмч, тогооч) хүмүүсийн зургийг бусдын дэмжлэгтэйгээр ялгаж нэрлэнэ. 	<ul style="list-style-type: none"> Хүүхдүүд нэг нэгнээсээ юугаараа адил ба ялгаатай байгаа талаар ярилцана. Эрэгтэй, эмэгтэй хүүхдийн тоглох дуртай тоглоом, дуртай өнгө, хувцас зэргийн тухай ярилцана. Өөрийн гэрэл зургийн доор ямар зүйл (жимс, хүнсний ногоо, тоглоом, хувцас)-д дуртайгаа бэлэн зургуудаас сонгон нааж, тайлбарлаж найзуудтай юу нь ижил, өөр байгааг ярилцана. 	<ul style="list-style-type: none"> Монгол хэл, гадаад хэлээр ярьж байгаа бичлэг сонсоод аль нь монгол хэл болохыг хэлнэ. Үндэсний хувцсаа өмссөн хүмүүс (япон, орос, монгол гэх мэт)-ийн зургаас аль нь монгол хүн болохыг зааж хэлнэ. Зураг харж монгол хүмүүсийн хувцасны ялгааг нэрлэж хэлнэ. Орос ардын бүжиг, казах, буриад бүжгийн хөдөлгөөнийг дуурайж хийнэ. 	

	I түвшин	II түвшин	III түвшин
11.Оролдлого, санаачилгатай, тууштай байх	1-2 шатлалтай зааврыг анхааралтай сонсох, биелүүлэх	Хийж буй ажил үйлдээ оролцох хугацаа нь уртсах, сонголт хийх, 2-3 шатлалтай зааврыг ойлгож биелүүлэх	Өгсөн зааврыг анхааралтай сонсож, биелүүлэх, хийж буй зүйлээ дуусгах, санаачилгаараа үйл гүйцэтгэх
	Хүүхдийн жишиг үйл		
	<ul style="list-style-type: none"> Жолооч больё, Туулай болцгооё багшийгаа дагаад хийгээрэй гэхэд хөдөлгөөнийг дуурайн дагаж хийнэ. Гулсуур руу авираарай, доошоо гулгаарай, хоолой дундуур мөлхөөрэй гэх мэт даалгаврыг биелүүлнэ. Хоолоо идээд амаа арчаарай, тоглоомоо дуусгаж, хураагаарай гэх мэт зааврыг ойлгож, биелүүлнэ. Хогоо хогийн саванд хийх, нүүрээ угаах, амаа зайлах гэх мэт үйлдлийг дахин давтан хийнэ. 	<ul style="list-style-type: none"> Тоглоом хураах, ном эмхэлж байрлуулах, цэцэг услах, хувцсаа эвхэх, ороо засах, хураах гэх мэт үйлийг бие даан гүйцэтгэнэ. Бие засаад, гараа угаагаарай, дараа нь гадаа гарч тоглоно, зурж дуусаад будгийн сав, бийрээ угааж, байранд нь тавиарай гэх мэт зааврыг хэрэгжүүлнэ. Хийж буй зүйлээ дундаас нь орхилгүй дуусгана. Ангид шинээр нэмэгдсэн тоглоом, сургалтын хэрэглэгдэхүүнийг зааврын дагуу мөн өөр хувилбараар ашиглана. Нийтээр дагах дүрмийг яагаад мөрдөх учиртай тухай ярилцана. Үлгэр зохиолыг дуустал сонсоно. Дүрд орж тоглохдоо дүрдээ итгэлтэй, үүрэг хариуцлагатай байна. 	<ul style="list-style-type: none"> Тоглож байхдаа тоглоомоо сонирхолтой болгоно. Жишээ нь: Өрж байгуулах тоглоомоор хашаа саравч барьж тоглохдоо мал, өвс хийж орчин бүрдүүлэх. Дүрэмтэй тоглоом тоглох, дүрд орж тоглох гэх мэт үйлийг санаачилж тоглоно. Сургалтын хэрэглэгдэхүүн, тоглоомоо цэгцлэх гэх мэт үйлд багшдаа санаачилгаараа тусална. Найз нөхөд, багштайгаа хамтран энгийн туршилт хийх, хамтын бүтээл хийх зэрэг даалгавар гүйцэтгэнэ. Хийсэн бүтээлээ хүмүүст танилцуулж, бэрхшээлийг даван туулж зорилгодоо хүрсэн тухай ярина. Өөрийн болон бусдын хийж бүтээсэн зүйлээс шинэлэг зүйлийг нь олж харна, дүгнэж хэлнэ. Шинээр олж мэдсэн зүйлээ өөрийнхөөрөө журна, барина, бүтээнэ, наана.
12.Дүрэм журмыг ойлгох, мөрдөх	I түвшин	II түвшин	III түвшин
	Болно, болохгүйг ойлгох, өгсөн хялбар зааврыг дагах	Тоглоомын болон ангийн дүрмийг ойлгож, бусдын сануулгатайгаар мөрдөх	Гэр бүл, цэцэрлэг, анги, олон нийтийн газарт тогтсон дүрэм, журмыг баримтлах
	Хүүхдийн жишиг үйл		
<ul style="list-style-type: none"> Халуун хоол, цайнд хүрч болохгүй, амандаа гараа хийж болохгүй гэх мэт зааврыг дагана. Хогийг хогийн саванд ялгаж хийгээрэй, нусаа арчаарай, гар, нүүрээ угаагаарай, тоглоомоо хураагаарай, хөтлөлцөж яваарай гэх мэт зааврыг дагана. Буруу (хазах, маажих, самардах) үйлдлийг хийж болохгүйг ойлгоно. 	<ul style="list-style-type: none"> Өдрийн дэглэмийн дагуу хийдэг үйл ажиллагааг (сургалт, хооллолт, нойрсолт гэх мэт) нэрлэж тэдгээрт мөрддөг дүрэм ялгаатай гэдгийг хэлнэ. Гаднаас орохдоо гутлаа арчих, хувцсаа цэвэр өмсөх, ном, дэвтэр урахгүй, малгай газар тавихгүй гэх мэт цээрлэх зан үйлийг яагаад мөрдөх хэрэгтэйг хэлнэ. Эд юмс, тоглоом наадгайг зохистой (шидэхгүй, эвдэхгүй, байранд нь тавих) хэрэглэнэ. Тоглоомын болон өдөр тутам дагаж мөрдөх дүрэм журмыг яагаад биелүүлэх учиртайг тайлбарлана. 	<ul style="list-style-type: none"> Хаалга алдлахгүй, гол, усанд бохир оруулахгүй гэх мэт цээрлэх зан үйлийг дагаж биелүүлнэ. Ангид баримтлах дүрэм (ангийн, сургалтын төвүүдийн) –ийг тайлбарлаж ярина, дагаж мөрдөнө. Музей, номын сан, үзвэрийн газар, гудамж, талбай гэх мэт олон нийтийн газарт биеэ зөв (чанга хашгирахгүй, гүйж харайхгүй, бие биеэ түлхэхгүй байх, хогоо ялгаж хийх гэх мэт) авч явна. Хэрэглэсэн тоглоом наадгай, сургалтын хэрэглэгдэхүүн, багаж хэрэгслээ байранд нь хураана. “Аяллаар явахдаа юуг анхаарах вэ?” Хамтдаа дүрэм зохионо. Жишээ нь: Хүүхдүүд ижилхэн ханцуйвч, хантааз эсвэл малгай өмсөх, тууз барих зэргийн аль нэгээр нь жигдэрнэ, автобусанд орохдоо бие биеэ хүлээж цувж орно, унаанаас буухдаа нэгнийгээ түлхэхгүй, уруудах, өгсөхдөө хурдтай гүйхгүй байх зэрэг дүрэм баримтлаагүйгээс гарах үр дагаврын тухай ярилцана. 	

Нийгэмшихүйн хөгжлийг “хөдөлгөөн, эрүүл мэнд”, “хэл яриа”, “математикийн энгийн төсөөлөл”, “байгаль нийгмийн орчин”, “хөгжим, дүрслэх урлаг” гэсэн суралцахуйн чиглэл бүрээр дэмжиж төлөвшүүлнэ.

Зураг 1. Сургалтын чиглэл бүрээр хүүхдийн нийгэмшихүйн хөгжилд нөлөөлөх зарим үйлийн жишээ




СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗӨВЛӨМЖ

- Байгаль, эд юмст гарах өөрчлөлтийг ажиглана.
- Орчноо сонирхож, учир шалтгааныг олох асуулт асууна.
- Хог хаягдлыг ялгаж, ангилж, хогийн саванд хийнэ.
- Гудамж талбайг бохирдуулахгүй байх талаар ярилцана. (шүлс, бохь, хог хаяхгүй, бие засахгүй)

Хүүхдийн цэцэрлэгийн өдөр тутам явагддаг бүх үйл ажиллагааны явцад нийгэмшихүйн агуулгыг эзэмших бөгөөд ямар үйлээр дэмжих жишээг дараах зургаас харна уу.

Зураг 2. Өдөр тутмын үйл ажиллагаагаар хүүхдийн нийгэмшихүйн хөгжилд дэмжлэг болох үйлийн жишээ



1.2 СУРАЛЦАХУЙН ЧИГЛЭЛҮҮД БА ХҮҮХДИЙН ГҮЙЦЭТГЭХ ЖИШИГ ҮЙЛ

Хөтөлбөрийн агуулга нь бага насны хүүхдийн бие бялдар, танин мэдэхүй, нийгэмшихүйн хөгжлийг дэмжихэд чиглэсэн “хөдөлгөөн, эрүүл мэнд”, “хэл яриа”, “математикийн энгийн төсөөлөл”, “байгаль нийгмийн орчин”, “хөгжим, дүрслэх урлаг” гэсэн суралцахуйн чиглэлүүдээр хэрэгжинэ.

ХӨДӨЛГӨӨН, ЭРҮҮЛ МЭНД

Хүснэгт 2. Хөдөлгөөн, эрүүл мэнд

Агуулга			
	I түвшин	II түвшин	III түвшин
	Явж, гүйж байгаад унахгүйгээр зогсох	Орон зайг баримжаалан алхах, гүйх хөдөлгөөнийг хослуулах	Алхалт, гүйлтийг янз бүрээр (өлмий дээр алхах, ухарч алхах, хөлийг хойш хаяж гүйх, хөлийг солбиж гүйх гэх мэт) гүйцэтгэх, чиглэл, хурдаа өөрчлөн гүйх
	Хүүхдийн жишиг үйл		
1. Алхах, гүйх	<ul style="list-style-type: none"> Амьтдын хөдөлгөөнийг дуурайж алхана. (Баавгай гэх мэт) Багшийг дуурайн гар гараасаа бариад дороо алхана. Хөлөө өндөр өргөж байрандаа алхана. Олсноос бариад тойргоор алхана. Саадыг сүлжиж алхана. (дарцаг, шоо гэх мэт) Туузан саадыг давж алхана. Шат өөд алхана. (3-4 гишгүүр) Вандан сандал дээгүүр багшийн тусламжтай алхана. Өнхөрч байгаа бөмбөгний араас гүйнэ. Хөлөө хойш хаяж олсны дундуур гүйнэ. Байрлуулсан саадыг давж гүйнэ. (олс, тууз) 	<ul style="list-style-type: none"> Гар гараасаа бариад тойргоор алхах, гүйхдээ чигээ өөрчилнө. Өлмий, өсгий дээр гараа алдлан алхана. Дарцаг барин тойргоор алхана. Байрлуулсан саадыг давж алхана. (олс, шоо) Цагирганаас цагаригт алхана. (жижиг) Хурдан удаан алхалтыг хослуулж алхана. Гараа барилцаад хөлөө хавсарч тойргоор алхана, гүйнэ. Алхалт, зогсолтыг хослуулна. Амьтад (үнэг, чоно, тогоруу, оцон шувуу гэх мэт)-ын хөдөлгөөнийг дуурайж алхаж, гүйнэ. Хөлийг урагш, хойш хаяж тойргоор гүйнэ. Саадыг сүлжиж хурдан, удаан алхаж, гүйнэ. Өвдөг өндөр өргөж могойчилж гүйнэ. Хөгжмийн хэмнэлд тохируулан хурдан удаан гүйнэ. Гүйлтийн дунд бөмбөг түүж сагсанд хийнэ. 	<ul style="list-style-type: none"> Өвдөг өндөр өргөж дороо, тойргоор, саваа модтой алхана. Өлмий, өсгий дээр хоёр гараа алдлан, гимнастикийн хэрэглэлтэй алхана. (уяа, дарцаг, саваа мод) Өсгий, өлмий дээр алхахдаа зүгээ өөрчлөн алхана. (урагшаа, хойшоо гэх мэт) Хурдан удаан хөгжмийн хэмнэлд тохируулан алхана. (бөмбөрийн цохилт, алга ташилт, хөгжмийн ая гэх мэт) Бөмбөгийг хөлөөрөө өнхрүүлж дарцаг сүлжиж алхана. Нарийн туузан замаар алхана. (саваа мод, вандан сандал гэх мэт) Хавсралттай алхалтыг алга ташилттай хослуулж хийнэ. Хөлийн улны гадна ба дотор талаар алхана. Спорт алхалтаар алхана. Хөлийг урагш, хойш хаяж гүйнэ. Өвдгөө өндөр өргөж гүйнэ. Бөмбөг дамжуулж гүйнэ. Зураасны хооронд гүйхдээ хоёр гараараа цагариг өнхрүүлнэ. 100 метрийн зайд хос хосоороо гүйнэ. Хөлөө солбин могойчилж гүйнэ. Гүйлтын дунд чихмэл бөмбөг дамжуулна. Өнхөрч байгаа цагариг дундуур гүйнэ.

	I түвшин	II түвшин	III түвшин
2. Үсрэх, харайх	Хоёр хөл дээрээ байрандаа болон урагш үсрэх	Хоёр хөл дээрээ тодорхой (2 метр орчим зай туулж) зайд үсрэх, өөрөөсөө өндөр зүйлд үсэрч хүрэх	2 хөлөө нийлүүлэн олсны хоёр талд гарч үсрэх, саадыг давж үсрэх, өндөр (30 см)-т харайх
	Хүүхдийн жишиг үйл		
	<ul style="list-style-type: none"> • “Туулай” болж хоёр хөл дээрээ үсэрнэ. • Цагаригт нэгээс нөгөөд үсэрч орж тоглоно. • Багшийн өндөрт барьсан бөмбөг, туузанд үсэрнэ. • Олс, туузыг давж харайна. 	<ul style="list-style-type: none"> • Хөгжмийн аянд “Туулай ба баавгай” (баавгай-удаан явах, туулай-үсрэх зэргээр) хөдөлгөөнт тоглоом тоглоно. • Багшийн барьсан тоглоомд өндөрт үсэрч хүрнэ. Тоглоомд хүрсэн тохиолдолд багш тоглоомыг бага багаар өндөрсгөж барина. • Гадаа талбайд үсэрч (тоо, дүрсний дагуу нэг, хоёр хөл дээрээ урагш, хажуу тийш үсрэх) тоглоно. • Цувуулж байрлуулсан 3-5 цагаригийн нэгээс нөгөө рүү үсэрч тоглоно. • Вандан сандал (30см өндөртэй)-аас үсэрч бууна. • Байрнаас уртад харайж, хэн хамгийн урт харайсанг тэмдэглэж олно. 	<ul style="list-style-type: none"> • Амьтдын дүрд хувиран үсэрч, харайж (туулай дэгдэх, ишиг харайх гэх мэт) тоглоно. • Буухиа тоглоом тоглоно. Жишээ нь: Модон шоог давж үсрээд, уутанд орж байруулсан тэмдэг хүртэл үсрэх, хоёр хөлийн хооронд бөмбөг хавчуулан дарцгийг сүлжин үсэрч тоглоно. • 2 хөл дээрээ 4-5 саад (олс дээс, модны тайрдас гэх мэт)-ыг давж үсэрнэ. • “Хамгийн урт зам туулья” тоглоом тоглоно. Хоёр хөлөө нийлүүлэн, бүдүүн олсны 2 талд гарч үсэрсээр нэг үзүүрээс нөгөө үзүүрт хүрнэ. • “Горхи дээгүүр харайя” тоглоом тоглоно. Шохойгоор зурж эсвэл, олс байрлуулж “горхи” үүсгээд, усанд унахгүйгээр дээгүүр нь харайна. • 1-10 хүртэлх цифртэй дүрс (дугуй, дөрвөлжин)-нд 1, 2 хөл дээрээ ээлжлэн үсэрч явна. • Өөрөөс нь 20-25см өндөрт өлгөсөн тоглоомд үсэрч хүрнэ.
3. Мөлхөх, авирах	I түвшин	II түвшин	III түвшин
	Нэг чиглэлд мөлхөх, шатаар өгсөх, уруудах	Саадыг давж мөлхөх, өндөрлөг зүйл (гулсуур, налуу шат гэх мэт) дээр авирч гарах, давж буух	Янз бүрээр мөлхөх, хананд тогтоосон шатанд авирч гарах, буух
	Хүүхдийн жишиг үйл		
	<ul style="list-style-type: none"> • 1,5 м орчим зайд байрлуулсан тоглоом (бамбарууш, бөмбөг гэх мэт)-д мөлхөж хүрнэ. • Чимээ гарч байгаа зүгт мөлхөнө. • Дарцаг сүлжиж мөлхөнө. • Мөлхөлтийн хоолой дундуур мөлхөнө. • Сандал, буйдан дээр авирч гарч, бууна. • Шатны бариулаас бариад, багшийн тусламжтайгаар шатаар өгсөж, уруудна. 	<ul style="list-style-type: none"> • Цагариг, нуман доогуур мөлхөнө. • Байрлуулж тавьсан тоглоом (машин, хүүхэлдэй, том өрж байгуулах мод гэх мэт)-ыг сүлжиж, саадыг давж мөлхөнө. • Вандан сандал дээгүүр гэдсээр гулсаж мөлхөн амьтдын хөдөлгөөнийг дуурайн хийнэ. • Жижиг гулсуурт авирч гараад гулсаж бууна. (3-5 гишгүүртэй) • Налуу шатанд авирч гараад багшийн дэмжлэгтэй алхаж бууна. (3-5 гишгүүртэй) • Овоолсон элс рүү авирч гараад үсэрч бууна. • Гадаа талбайд намхан шат өөд авирч гарч, бууж тоглоно. • Нуман шатаар авирч, бууна. • Намхан сандал дээр авирч гарч, үсэрч бууна. 	<ul style="list-style-type: none"> • Өргөн вандан дээгүүр гар, хөлийг зөрүүлэн дөрвөн хөллөж мөлхөнө. • 40 см өндөрт буй уяан доогуур тохой, өвдгийн тусламжтай гулсаж мөлхөнө. • Нуруун дээрээ ууттай элс тавин нуман доогуур мөлхөнө. • Вандан сандал дээр хоёр гарын тусламжтай нуруугаар гулсана. • “Туулай мөлхөлт” (хөл, гарыг салгахгүй урагш зөөж тавьж)-өөр мөлхөнө. • Хананд тогтоосон шатанд авирч, бууна. • Гадаа тайлбайд олон (6-гаас дээш) гишгүүртэй шатанд авирч гарна, бууна.

	I түвшин	II түвшин	III түвшин
	Бөмбөг (эд зүйлс)- ийг урагш өнхрүүлэх, шидэх, шидсэн том бөмбөгийг барьж авах	Бөмбөгийг дамжуулах, дээш шидэх, барьж авах	Бөмбөгийг бай руу чиглүүлэн шидэж онох
	Хүүхдийн жишиг үйл		
4. Шидэх, дамжуулах, барих	<ul style="list-style-type: none"> • Хосоороо, тойргоор сууж том бөмбөгийг бие бие рүүгээ өнхрүүлж тоглоно. • Том бөмбөг өнхрүүлж хол, ойр тавьсан байг ононо. • Өнхөрч ирсэн бөмбөг барьж авна. • Бөмбөгийг хоёр гараараа доороос шиднэ. • Цаасан бөмбөгийг дээш шидэж барьж авна. • Цаасан онгоцыг дээш хөөргөнө. 	<ul style="list-style-type: none"> • Суугаа байрлалаас бөмбөг өнхрүүлэн бие биедээ дамжуулна. • Олсны хоёр талд зогсож, эсрэг талынхаа хүүхэд рүү бөмбөг дамжуулж, унагахгүй барьж авна. • Туузан дээгүүр бөмбөгийг хоёр гараараа өнхрүүлнэ. • Чихмэл бөмбөг хөлөөрөө өнхрүүлж хаалга руу оруулна. • Бөмбөгийг саваа модоор өнхрүүлэнгээ гүйнэ. • Хоёр гараараа цагариг өнхрүүлж уралдана. • Бусадтай хамтран чихмэл бөмбөг даавуун дээр дээш нь ойлгож тоглоно. • Чихмэл бөмбөгийг бие бие рүүгээ шидэж дамжуулна. • Бөмбөгийг газарт ойлгож, хоёр гараараа барьж авна. • Бөмбөгийг хоёр гараараа уяан дээгүүр давуулж шиднэ. • Бөмбөг нэг гараараа шидэж цагаригт оруулах, бай ононо. • Цаасан бөмбөг шидэж бие биенээ ононо. 	<ul style="list-style-type: none"> • Хоёр гараараа бөмбөг өнхрүүлж бай ононо. • Бөмбөгийг саваа модоор өнхрүүлэнгээ саадыг сүлжин гүйж, алхана. • Бөмбөгийг хөлөөрөө өнхрүүлж саадыг сүлжиж гүйнэ. • Бөмбөгийг вандан сандал дээгүүр өнхрүүлж харилцана. • Цагаригийг хоёр гараараа өнхрүүлж алхана. • Теннисний бөмбөг үлээж өнхрүүлнэ. • Сагсны цагаригт бөмбөг шидэж барьж авна. • Бөмбөг дээш нь шидэх, газар ойлгох, залах, алга ташин барьж авна. • Хөл бөмбөг тоглоно. • Жижиг зүйлс (бөмбөг, алчуур, ууттай элс гэх мэт)-ийг дээшээ шидээд, унагалгүй барьж авна. • 2 метрийн зайд байрлуулсан босоо бай руу бөмбөгийг шиднэ. • Нисдэг таваг шидэж тоглоно.

5. Биеийн хөдөлгөөнөө хянах, зохицуулах	I түвшин	II түвшин	III түвшин
	Насанд хүрэгчдийн хөдөлгөөнийг даган хийх	Дасгал, хөдөлгөөнийг дэс дарааллын дагуу хийх	Хөдөлгөөнийг орон зайд зохицуулан бусадтай хамтран гүйцэтгэх
Хүүхдийн жишиг үйл			
	<ul style="list-style-type: none"> Багшийн хийж буй дасгал хөдөлгөөнийг дагаж хийнэ. (загас, шувуу гэх мэт) Багшийн үгэн зааварчилгааг анхааралтай сонсож, дагана. Жишээ нь: Орох, гарахдаа жагсах. Халуун, хүйтэн зүйлд гараа хүргэхгүй байна. Тоглох явдаа хөдөлгөөнөө зохицуулна. Найзтайгаа хамт хийж байгаа дасгалаа зэрэг эхэлж дуусгана. 	<ul style="list-style-type: none"> Найзтайгаа хамтран өрж байгуулах тоглоомоор тоглоно, байранд нь хураана. 4, 8 тоот дасгалыг багшийн заавар, дарааллын дагуу гүйцэтгэнэ. Бөмбөгийг олсон дээгүүр давуулан шидэж, шидсэн бөмбөгийг унагалгүй барьж авна. Дасгал, хөгжимт хөдөлгөөн (“Эрвээхий”, “Алаг эрэн аалз” гэх мэт)-ийг хөгжмийн хэмнэлд тохируулан гүйцэтгэнэ. Бусадтай хөдөлгөөнөө уялдуулж, хамтдаа тоглоно. Жишээ нь: Даавуун дээр тавьсан зүйлийг хамтдаа унагахгүйгээр зөөнө. Хоёр гартаа том бөмбөг барьж, бүдүүн олсон дээгүүр явна. 	<ul style="list-style-type: none"> “Алтан тав”, “Зургийн хичээл” гэх мэт дасгалыг хөгжмийн хэмнэлд тохируулан бие даан гүйцэтгэнэ. “Будаг”, “Гагнасан гинж”, “Цагаан тэмээцэх” гэх мэт хөдөлгөөнт тоглоомыг дүрмийн дагуу тоглоно. Дасгалын зай авч зогсоод 8 тоот дасгалыг бусадтай хамтдаа гүйцэтгэнэ. Байгаа орчиндоо хөдөлгөөнөө зохицуулан хийнэ. Жишээ нь: Загварын тайз дээр алхаж тоглох Тоглоомын явцад өгсөн дохионы дагуу хөдөлгөөнийг эхэлнэ, дуусгана. Жишээ нь: Багш дохио өгөхөд хөдөлгөөнөө зогсоох Хөгжмийн хэмнэлд янз бүрийн хөдөлгөөн (алхах, гүйх, суух гэх мэт)-ийг хослуулан гүйцэтгэнэ. Бөмбөг бариад дарцаг сүлжиж уралдана. Багшийн дохиогоор хөдөлгөөнөө зэрэг үргэлжлүүлнэ. Жишээ нь: зүгээ өөрчилж гүйх Хоёр гараараа дээс эргүүлж, дээсэнд үсэрч тоглоно.
6. Хөдөлгөөн гүйцэтгэхдээ биеийн тэнцвэрийг хадгалах	I түвшин	II түвшин	III түвшин
	Өргөн замаар биеийн тэнцвэрийг хадгалан алхах	Нарийн замаар биеийн тэнцвэрийг хадгалан алхах, үсрэх	Алхах, үсрэх, харайх, шидэх зэрэг хөдөлгөөн гүйцэтгэхдээ биеийн тэнцвэрээ хадгалах
Хүүхдийн жишиг үйл			
	<ul style="list-style-type: none"> Олсон дээгүүр гараа алдалж алхана. Хоёр хөл дээрээ дүрснээс дүрс рүү үсэрнэ. Сандал, гулсуур руу авчирч, буухдаа унахгүй бууна. (Багшийн дэмжлэгтэй) Том бөмбөг хоёр гараараа барьж унагалгүй сагсанд хийнэ. Газар байгаа тоглоомоо авахдаа явган сууж босно. Саваа модыг давж алхаад, тэнцвэрээ олж зогсоно. Цагирганаас цагаригт унахгүй үсэрнэ. 	<ul style="list-style-type: none"> Нарийн олсны дундуур хоёр гараа алдлан гүйнэ. Баруун, зүүн тийш эргээд унахгүй зогсоно. Гараа ташаандаа авч хоёр хөл дээрээ унахгүй үсэрнэ. Цагариг дотор нүдээ аньж дороо алхана. Бие даан шатаар өгсөж, уруудана. Нуруун дээрээ ууттай элс тавьж унагалгүй мөлхөнө. Модны тайрдас, вандан сандлаас үсэрч буухдаа унахгүй зогсоно. Шидсэн том бөмбөгийг алдалгүй барьж авна. Саваа модтой дасгал хийнэ. Жижиг бөмбөгийг сагснаас сагс руу хурдан зөөнө. Дүүжин даажин тоглоомыг найзтайгаа хамт тоглоно. 	<ul style="list-style-type: none"> Дээсэнд үсэрч тоглоно. Юмс (том чулуу, өрдөг том тоглоом, модны тайрдас, олс гэх мэт)-ыг дамжин явна. Вандан сандал дээр нэг хөл дээрээ зогсоно. Аягатай ус цалгиулж асгахгүйгээр зөөнө. Толгой дээрээ цагариг барьж, олсон дээгүүр алхана. Бөмбөг, тууз, дарцаг, дэвүүртэй дасгал хийнэ. Өнхөрч байгаа цагариг дундуур гүйнэ. Вандан сандал дээрээс тэнцвэрээ хадгалан унахгүйгээр бууна. Найзтайгаа уралдан налуу шатанд авирч, бууна. Олсон дээгүүр бөмбөг шидэж дамжуулна, алдахгүй барьж авна.

	I түвшин	II түвшин	III түвшин
7. Гар хурууны хөдөлгөөнөө зохицуулах	Жижиг тоглоом, эд зүйл (халбага, харандаа)-ийг алдахгүй барих	Гар хуруугаараа энгийн үйл (хаалга цоожлох, шүр хэлхэх, таглааг эргэдэж таглах, цэцэг услах, товч товчлох, бүсээ бүслэх гэх мэт) гүйцэтгэх	Гар хуруугаараа нарийн, хүндэвтэр үйл (хайчлах, эвхэх, гутлаа үдэх, шагай няслах, үсээ сүлжих, уяж зангидах гэх мэт) гүйцэтгэх
	Хүүхдийн жишиг үйл		
	<ul style="list-style-type: none"> • Тоглосон тоглоомоо байранд нь өрж тавина. • Зузаан хуудастай номын хуудсыг нэг нэгээр нь эргүүлнэ. • Суварган тоглоомыг өрж, давхарлаж тоглоно. • Өрж байгуулах тоглоомоор тоглоно. • Хэлхсэн дүрсийг хөдөлгөж тоглоно. • Жижиг бөмбөгийг базна, өнхрүүлж тоглоно. • Үдээсээр нүхэлсэн бэлдэцийг сүвлэж тоглоно. 	<ul style="list-style-type: none"> • Өөрийн хувцасны цахилгааныг татаж, товчоо товчилно, хувцсаа эвхэнэ. • Элсэн дээр хуруугаараа зурж тоглоно. Жишээ нь: Нар зурах. • Шигтгэдэг тоглоомоор дүрс шигтгэж тоглоно. • Савны таг эрэгдэж онгойлгоно, таглана. • Амьтдын зурагтай картыг эвлүүлж тоглоно. (4-5 хэсэгтэй) • Нүхэлсэн шагай, шүрийг хэлхэж тоглоно. • Нойтон цаас базаж, бөмбөг хийнэ. 	<ul style="list-style-type: none"> • Цаасыг янз бүрээр хайчилна, эвхэнэ. Жишээ нь: Эрвээхий хайчлах, онгоц эвхэх. • Шагайгаар тоглоно. • Хоёр, гурваар сүлжиж тоглоно. • Үдээс сүвлэж, үдэж тоглоно. • Савх модоор байшин бүтээнэ. • Шүрийг хавчаараар хавчиж, саванд хийнэ. • Теннисийн бөмбөг халбагаар зөөж, тавганд хийнэ. • Усыг нэг савнаас нөгөө саванд асгахгүйгээр юүлнэ. • Дүүрэн савтай усыг цалгиулахгүйгээр зөөнө. • Төрөл бүрийн цоож онгойлгоно, түгжинэ. • “Сүмбэр уул” тоглоом тоглоно. • Юм оёж тоглоно. Жишээ нь: Цүнхний бэлдэцийн нүхээр сүвлэж оёх.

	I түвшин	II түвшин	III түвшин
	Насан хүрэгчдийн дэмжлэгтэйгээр амаа зайлах, хамраа цэвэрлэх, нүүр гараа угаах	Бусдын сануулгатайгаар гараа дарааллын дагуу угаах, хоолойгоо зайлах	Гараа бие даан дарааллын дагуу угаах, шүдээ насанд хүрэгчдийн дэмжлэгтэйгээр угаах. Бие зассаны дараа ариун цэврийн цаас хэрэглэх
8. Хувийн ариун цэврийг сахих	Хүүхдийн жишиг үйл		
	<ul style="list-style-type: none"> • Багш, эцэг эхийн тусламжтайгаар амаа зайлна, хамраа цэвэрлэнэ. • Өөрийн таних тэмдэгтэй эд зүйл (сандал, сам, сойз гэх мэт)-ийг таньж, хэрэглэнэ. • Гараа хоолны өмнө, бие зассаны дараа насанд хүрэгчдийн дэмжлэгтэй угаана. • Хоол идсэний дараа амны цаас хэрэглэнэ, арчсан цаасаа зориулалтын саванд хийнэ. • Насанд хүрэгчдийн дэмжлэгтэй шүдээ угаана. • Багшийн дэмжлэгтэй хувцсаа эвхэж, унтлагын хувцасыг өмсөж унтана. • Багшийн дэмжлэгтэй нүүр, гараа угааж, үсээ самнуулна. • Цэцэрлэгт өөрийн сандал дээр, гэртээ заасан байрлал (тавиур, шүүгээ гэх мэт)-д хувцсаа эвхэж тавина. 	<ul style="list-style-type: none"> • Бэлтгэсэн ус (давс, сод эсвэл нимбэгтэй)-аар хоолойгоо зайлна. • Хамраа цэвэрлэнэ. • Гараа хоол идэхийн өмнө, бие зассаны дараа угаана. • Хоолны ширээнд цэвэрхэн хооллоно. • Хог хаягдлыг зориулалтын саванд хийнэ. • Өөрийн сам, ам зайлах аяга зэрэг хэрэгслээ ялган таньж, хэрэглэнэ. • Өөрийн хувцсаа эвхэж, гутал, оймс, хамрын алчуураа бусадтай солихгүй, зохих байранд нь тавина. • Багшийн дэмжлэгтэй шүдээ угааж, унтлагын хувцас өмсөж унтана. • Идэж буй зүйлээ бусдад дамжуулалгүй иднэ. • Ариун цэврийн цаасыг бусдын тусламжтай хэрэглэнэ. • Нүүр гараа бие даан угааж үсээ самнуулна. • Өмссөн хувцсаа бохирдсныг мэдэж насанд хүрэгчдийн дэмжлэгтэй солино. 	<ul style="list-style-type: none"> • Давс, сод, нимбэгтэй усаар бие даан хоолойгоо зайлна. • Хамраа цэвэрлэнэ. • Гараа хоолны өмнө, бие зассаны дараа, бохирдсон тохиолдолд дарааллын дагуу бие даан угаана. • Хоолны ширээ засаж, хураана, цэвэрхэн хооллоно. • Шүд угаах дарааллыг хараад, шүдээ багш, эцэг эхийн дэмжлэгтэй угаана. • Ариун цэврийн хэрэгсэл ариун цэврийн цаас, саван, шүдний оо, сойзыг бусадтай солихгүй, хэрэглэнэ. • Ариун цэврийн цаасыг бие даан хэрэглэж зориулалтын саванд хийнэ. • Хоол ундаа асгасан даруйд арчиж цэвэрлэнэ. • Хэрэглэсэн тоглоом болон сургалтын хэрэглэгдэхүүнээ хураана, цэвэрлэнэ. • Бие даан ороо засаж унтлагын хувцас өмсөж унтана. • Хувцсаа эвхэж, сандал дээр, гутлаа сандлын дор зэрэгцүүлэн тавина. • Хумстай байгаагаа мэдэж ээж аавдаа хэлнэ. • Аав ээжтэйгээ гадуур явахдаа гудамж талбайд нус, шүлсээ хаяхгүй байна.

	I түвшин	II түвшин	III түвшин
	Насан хүрэгчдийн анхааруулсан зарим үйлдэл (бохирдсон хүнсийг идэхгүй байх гэх мэт)-ийг хийхгүй байх	Өөрийн эрүүл мэндэд хортой зүйлсээс зайлсхийх, эрүүл мэндээ хамгаалах үйлдэл (түүхий ус уухгүй байх, ханиадны эсрэг массаж хийх гэх мэт)-үүд хийх	Гэмтэж болзошгүй үйлдэл (малын хөлөөс хол байх, машинаас болгоомжлох гэх мэт)-ээс зайлсхийх, биед сайн, муу хүнсийг ялгах
9. Гэмтээс болгоомжлох, өвчлөхөөс сэргийлэх	Хүүхдийн жишиг үйл		
	<ul style="list-style-type: none"> • Халуун цай, хоол, хүйтэн мөсөнд гараа хүргэхгүй байна. • Харандаа, эсгий бал зэргийг амандаа хийхгүй байна. • Тоглоомоо амандаа хийхгүй тоглоно. • Шатаар өгсөж, уруудахдаа бие биеэ түлхэхгүй явна. • Насанд хүрэгчдийн сануулгаар бохирдсон, муудсан хүнсний зүйлийг идэхгүй. Жишээ нь: Өнгө нь өөрчлөгдсөн жимс. 	<ul style="list-style-type: none"> • Хайч, харандаа дамжуулахдаа үзүүрийг өөр рүүгээ харуулж дамжуулна. • Шатаар өгсөж, уруудахдаа бие биеэ түлхэхгүй, бариулаас барьж явна. • Хоолны махыг хахахаас болгоомжлон олон дахин зажилж иднэ. • Гадуур явах, цэцэрлэгтээ ирэх, буцахдаа замын хөдөлгөөнд болгоомжтой (гэрлэн дохио, гарцаар гарахдаа аав, ээжийнхээ гараас хөтлөх) оролцоно. • Багшийг даган дуурайж, ханиадны эсрэг цэгэн массаж хийнэ. • Газарт унаж бохирдсон зүйлийг амандаа хийхгүй, амнаасаа чихэр найздаа өгөхгүй байна. • Цахилгааны залгуурт хуруугаа хийхгүй, ширээн дээр гарч зогсохгүй, цонх руу авирч гарахгүй байна. Танихгүй хүнийг дагаж явахгүй машины зам дээр тоглохгүй байна. • Машинд сууж явахдаа машины цонхоор толгойгоо гаргахгүй, арын суудалд сууж суудлын бүсээ зүүж явна. • Өвөл утаа ихтэй үед, өвдсөн тохиолдолд, өвдөхөөс хамгаалж амны хаалт зүүнэ. • Сайн, муу хүнс, хүнснийг ялгаж, биед хэрэгтэй хүнсийг насанд хүрэгчдийн тусламжтай хэрэглэнэ. • Аюулын дохио дуугарахад насанд хүрэгчдийн дэмжлэгтэй ширээн доогуур орох, ном толгой дээрээ бариад гадагшаа гарна. 	<ul style="list-style-type: none"> • Орчны эд юмсаар тоглохдоо аюулгүй тоглох дүрмийг нийтээр хэлэлцэн ангийн болон сургалтын төвүүдэд тоглоно. Жишээ нь: Цаасыг хайчлахдаа болгоомжтой байна. Тоглоомын жижиг хэсгийг амандаа хийхгүй • Хагарсан шил, шаазан барихгүй, гишгэхгүй байна. • Аав, ээжийнхээ утасны дугаарыг цээжээр хэлнэ эсвэл цифрээр харуулна. • Төөрсөн үед бусад дэлгүүрийн худалдагч, цагдаа ах зэрэг хүмүүсээс тусламж хүснэ. аав, ээжийнхээ утасны дугаарыг хэлж залгуулна. • Шаардлагатай утасны дугаарууд (101, 102, 103, 108) мэднэ, шаардлагатай тохиолдолд залгаж тусламж хүснэ. • Аяллын үед машины цонхоор толгой, гараа гаргахгүй, суудлын бүсээ зүүж явна. • Гал гарах, газар хөдлөх, үер болох, төөрөх үед хэрхэн өөрийгөө хамгаалах талаар дасгал сургуулилалт хийнэ. Жишээ нь: Толгой дээрээ ном, хатуу зүйл барих, ширээн доогуур орох, тусламж дуудах, цэцэрлэгийн ослын гарц руу очно. • Бусадтай хамтран цэцэрлэг, гэртээ хэрхэн аюулгүй байх тухай санаануудын жагсаалт гаргана. Жишээ нь: Булан тойрох, аяга таваг барьсан үедээ гүйхгүй байна. • Цахилгааны залгуурт хүрэхгүй, машины зам дээр тоглохгүй байх, хүчтэй салхи, аянгатай ширүүн бороотой үед гэртээ байна. • Аюулын дохио дуугарахад ширээн доогуур орох, насанд хүрэгчдийн дэмжлэгтэй ном толгой дээрээ бариад гадагшаа гарна. • Байгалийн гамшиг тохиолдох үед ямар арга хэмжээ авдаг тухай төсөлт ажил, сургуулилтад оролцоно. • Өвөл утаа ихтэй үед, өвдсөн тохиолдолд, өвдөхөөс хамгаалж амны хаалт зүүнэ. • Сайн, муу хүнсийг ялгаж, биед хэрэгтэй хүнсийг хэрэглэнэ. • Хөдөө явахдаа малын хөл (үхэр, адуу)-өөс хол явна.

ХЭЛ ЯРИА

Хүснэгт 3. Хэл яриа

Агуулга		
I түвшин	II түвшин	III түвшин
Орчноосоо сонссон дуу авиаг дуурайх	Орчны дуу авиаг ялгаж сонсох, дуурайх	Хэлний авиа (үгийн эхэн, төгсгөлд орсон)-г ялгаж сонсох, зөв дуудах
Хүүхдийн жишиг үйл		
<p>1. Орчны болон хэлний авиаг ялгаж сонсох</p> <ul style="list-style-type: none"> • “Хөвөн бөмбөг үлээе” тоглоом тоглоно. • Амьтдын зураг зааж дуугарахыг (нохой, муур, морь, үхэр, хонь гэх мэт) сонсож дуурайна. • “Сая ямар амьтан дуугарсан бэ?” тоглоомоор сонссон авиагаа дуурайж, нохой-хав, хав, муур-мяу мяу, шувуу жив жив гэх мэтээр дуугарна. • Орчны дуу авиа (машины чимээ, цагны чимээ, тэнгэр дуугарах, тахиа донгодох, нохой хуцах гэх мэт)-г сонсоод, зургаас тохирохыг нь олно. • Хүүхэддэйгээ унтуулъя: “бүү-вэй, бүү-вэй, машинаа асаая: “үүн-үүн, галыг унтраая: фүү, фүү, хонхоо цохъё: жин-жин гэж дуу авиагаар илэрхийлэн тоглоно. • Аяга долоох, уруулаа цорвойлгох, уруулаар хамраа “таглах”, хацраа бөмбийлгөж тоглоно. 	<ul style="list-style-type: none"> • “Бороо орлоо.” Ширүүн бороо орлоо, бороо намжлаа, бороо зогслоо гэх мэтээр чимээг нь дуурайн алга ташиж тоглоно. • Амьтдын дуу авиа (чоно улих, нохой хуцах, тахиа донгодох, болжмор жиргэх гэх мэт), тээврийн хэрэгсэл (машин, онгоц, түргэний машин, хогны машин гэх мэт)-ийн дуу чимээг ялган сонсож, дуурайх, зурган картнаас олж харуулна. • Таван хошуу малын тэмээ буйлах, морь янцгаах, үхэр мөөрөх, хонь, ямаа майлахыг дуурайн дуугарна, ямар малын дуу авиа болохыг нэрлэнэ. • Хүн инээж, хүүхэд уйлж байгаа дуу авиаг сонсоод, дуурайн дуугарна, ялгаж хэлнэ. • Янз бүрийн дуу чимээ гаргаж тоглоно. Жишээ нь: Гуурсаар үлээж, ус “буцалгах”, “Хаалга тогшлоо” тог тог тог, “Хонх дуугарлаа” дин дон, дин дон, “Бороо орлоо” хуудас цаасан дээр савхаар цохих. • Хэлээ өргөж хамартаа хүргэх гэж тэмүүлэх, уруулаа тойруулан долоох, хэлний үзүүрийг хоёр завжинд ээлжлэн хүргэж тоглоно. 	<ul style="list-style-type: none"> • Байгалийн дуу чимээг дуурайж дуугарна. Жишээ нь: Ссссссс салхи салхилах, горхины чимээг дуурайж (шорр, шорр) дуугарна. • Байгалийн болон хүн, мал, амьтны дуу (салхи- салхилах, бороо орох, хүн дуулах, хөхөө донгодох, тэмээ буйлах, морь янцгаах, нохой хуцах гэх мэт)-г сонсоод, зургуудыг бүлэглэж дуу авиаг нь дуугарч үзүүлнэ. • Дуу авиа, чимээ бүхий тоглоом зохионо, тоглоно. Жишээ нь: өрөмдөх дrrrrr, дrrrrr, бороо орох под, под, под • Цаасыг жижиглэн урж гарын алга дээр тавьж үлээн салхи үүсгэн (үүү, үүү, үүү) хийсгэж тоглоно. • Хэл зүгшрүүлэх аман наадам түргэн хэллэг хэлнэ. • Хэлийг өргөж хонхойлгож, тагнай ташиж тоглоно.

	I түвшин	II түвшин	III түвшин
	Үгийг сонсоод ойлгох, дуурайж дагаж хэлэх	Үгийн утгыг ойлгох, өдөр тутам хэрэглэгддэг үгсийг яриандаа хэрэглэх	Ойролцоо дуудлагатай үг, эсрэг утгатай үгийг ойлгох, яриандаа хэрэглэх
2. Үгийн утгыг ойлгох, хэрэглэх	Хүүхдийн жишиг үйл		
	<ul style="list-style-type: none"> • Тоглоом, эд юмсын зурагтай карт хараад нэрлэнэ. (аяга, ширээ, сандал, хүүхэлдэй гэх мэт) • Хэн, юу асуултыг ойлгож (Энэ хэн бэ? ээж, Энэ юу вэ? мод гэх мэт) хариулна. • Зарим эрхтнээ зааж, нэрлэнэ. Жишээ нь: толгой, гар, чих, нүд, гар, хамар, ам. • Ойр дотны хүн, тоглоом, эд юмсыг өөртөө хамаатуулж (миний бөмбөг, миний ээж) хэлнэ. • Гэр бүлийнхээ зургийг харж Хэн бэ гэсэн асуултанд хариулна. • Ном, бичлэг үзээд мэддэг дүрийг зааж, дуурайж тоглоно. • Тоглодог тоглоом, таньдаг амьтнаа зааж нэрлэнэ. 	<ul style="list-style-type: none"> • “Үг дамжуулах” тоглоом тоглоно. • Хүүхэлдэй хооллох, хувцаслах, үс самнах, унтуулах зэрэг хийж байгаа үйлээ нэрлэнэ. • “Будаг авъя” хөдөлгөөнт тоглоом, “Хувцасны өнгийг нэрлэе” гэсэн өнгийг нэрлэх, таних тоглоом тоглоно. • Өөрийн хэрэглэдэг эд зүйлийн нэрийг лавлан асууна. • Насанд хүрэгчдийн энгийн асуултыг ойлгож, хариулна. Жишээ нь: Чи цэцэрлэгтээ хэнтэй хамт ирсэн бэ? Би цэцэрлэгтээ ээжтэйгээ хамт ирсэн. • Үзсэн киноныхоо таалагдсан дүрд хувирч тоглоно. • Найзынхаа тоглоомыг өөрийнхтэйгээ харьцуулан ярина: Жишээ нь: Арай том, илүү хурдан. • Сая ирлээ, одоо унтъя, орой явна гэх мэтээр цаг хугацаа заасан үгийг ашиглан ярина. 	<ul style="list-style-type: none"> • Үгийг үйл үг, тэмдэг нэрээр идэвхжүүлж тоглоно (хүүхэд гэсэн үгийг -тэмдэг нэрээр: хөөрхөн хүүхэд, нялх хүүхэд; -үйл үгээр: хүүхэд инээж байна. хүүхэд дуулж байна; -эсрэг утгатай үгээр өндөр хүүхэд, намхан хүүхэд гэх мэт). • Ойролцоо ба эсрэг утгатай үг (баярлалаа талархлаа, гялайлаа, цэвэр бохир, том жижиг гэх мэт) хэлнэ. • Янз бүрийн зурагтай картыг ерөнхий нэр (хувцас, амьтан, жимс, хүнсний ногоо)–ээр нь ангилна. • Танил мэргэжлийг нэрлэж, дүрд хувирч сэдэвт тоглоом (эмч, багш, жолооч, тогооч, нисгэгч, мужаан) тоглоно. • Тогооч, багш, эмч, барилгачин, жолоочид юу хэрэгтэйг зургаас нэрлэж, ижилсүүлнэ. • Би, чи, бид, та нар, чамд гэх мэтээр төлөөлүүлэн ярина. • Хаана юу байна вэ? гэсэн асуултанд хариулж юмсын байрлалыг тодорхойлж хэлнэ. Жишээ нь: Ширээний хажууд сандал байна. Цонхны тавцан дээр цэцэг байна. Модны мөчир дээр шувуу сууж байна. • Дөрвөн улирал, өглөө, өдөр, орой гэх мэт хугацаа заасан үгийг яриандаа ашиглана. • Зураг дээрээс хэн олон зүйл харж нэрлэх вэ? тоглоом тоглоно. • Таавар зохионо, бусдаар таалгана. Жишээ нь: Би дөрвөлжин хэлбэртэй, дээр нь юм зурж, бичиж болдог нэг зүйлийг харж байна. Тэр юу вэ? (самбар)

	I түвшин	II түвшин	III түвшин
3. Өгүүлбэрийг ойлгох, өгүүлбэрээр ярих	Хураангуй өгүүлбэр хэлэх	Энгийн ба дэлгэрэнгүй өгүүлбэр ойлгох, хэлэх	Зөв бүтэцтэй өгүүлбэрээр ярих
	Хүүхдийн жишиг үйл		
	<ul style="list-style-type: none"> • Энгийн богино өгүүлбэр (Одоо гараа угаацгаая)-ийг ойлгож, хэрэгжүүлнэ. • “Энэ хэнийх вэ?” Хувцаснуудаас өөрийнхийг олж хэлнэ. Энэ миний гутал байна гэх мэт. • Хоёроос гурван үгтэй өгүүлбэр хэлнэ. (Би явлаа) • Асуултад хариулна. • Номын зураг дээр хэн юу хийж байгааг хэлнэ. Жишээ нь: Үйл явдал харуулсан зураг дээр 	<ul style="list-style-type: none"> • Хэн юу хийж байна вэ? зургийн үйл явдлыг дарааллуулан тоочиж ярина. • Зураг (малгай, цув, гутал) харж өгүүлбэр зохиож хэлнэ. • Үйл үг, нэр үг, тэмдэг нэр оролцуулан өгүүлбэр зохиож ярина. (Хоёулаа нуугдаж тоглоё. Улаан машинаараа тоглох уу?) • Онъсого таавар, зүйр цэцэн үгс (Хүн ахтай, дээл захтай.) хэлнэ. • Нийлмэл өгүүлбэрийг ойлгож, биелүүлнэ. (Бат шүүгээнээс өөрийн дэвтэр, тавиур дээрээс харандаагаа аваад, ширээн дээр тавиарай.) 	<ul style="list-style-type: none"> • Багшийг дагаж богино шүлэг уншина, утгыг өөрийн үгээр тайлбарлаж хэлнэ. • Яагаад? гэсэн асуултад учир шалтгааныг тайлбарлаж нийлмэл өгүүлбэр хэлнэ. Жишээ нь: Бороо орж байгаа болохоор усны гуллаа өмсөж гарна. • Өгүүлбэрийг дэлгэрүүлж, нийлмэл өгүүлбэр хэлнэ. Жишээ нь: Аав ирсэн. Аав хөдөөнөөс ирсэн. Аав хөдөөнөөс очигдөр ирсэн. Аав хөдөөнөөс ирсэн болохоор би баярласан. • 2-3 үйл явдлыг илэрхийлсэн хавсарсан нийлмэл өгүүлбэрээр өөрт тохиолдсон үйл явдлаа ярина.
4. Санаа бодлоо илэрхийлэн ярих	I түвшин	II түвшин	III түвшин
	Өөрт тулгарсан, сонирхсон зүйлээ хураангуй өгүүлбэрээр илэрхийлэн хэлэх	Үзэж харсан, оролцсон үйл явдлынхаа тухай бусдад ярих	Санаа бодол, үзсэн, оролцсон үйл явдлаа ойлгомжтой ярих
	Хүүхдийн жишиг үйл		
<ul style="list-style-type: none"> • Мэддэг хүүхэлдэйн баатрынхаа зургийг харж, нэрлэнэ. • Бие засах, уух, идмээр байгаагаа дохио зангаа, үгээр хэлнэ. • Өөрийн хэрэглэдэг эд юмс (миний сандал, миний гутал)-ыг нэрлэнэ. • Санаа бодлоо (Самаа авч ирээд “май” гэж өгөх) үгээр илэрхийлэн хэлнэ. • Өөрийн дуртай тоглоом, хэрэглэдэг эд юмс, тоглоомыг зааж нэрлэнэ. • Энэ хэн бэ, юу вэ? асуулт тавина. 	<ul style="list-style-type: none"> • Өөрт тохиолдсон баярт үйл явдлын тухай ярина. Жишээ нь: Төрсөн өдөр тэмдэглэсэн, тоглоомын газар тоглосон, зугаалгаар явсан, тэмцээн, уралдаан, өдөрлөг, өглөөлөгт оролцсон гэх мэт. • Гэр бүл, ангиараа тоглоомын газар тоглосон, музей үзсэн, айлд зочилсон тухайгаа бусдадаа ярина. • Хөдөө явсан тухай гэрэл зургаа тайлбарлан ярина. • Багш, найз нөхөд, гэр бүлийнхэнтэйгээ сэтгэл хөдлөлөө илэрхийлэн дууны өнгөө хувиргаж ярина. • Үеийн нөхдийнхөө яриаг анхааралтай сонсоод, яагаад, юуны учир, яах гэж? гэх мэт асуулт асууна. 	<ul style="list-style-type: none"> • Үлгэр сонсоод асуулт тавьж, ярилцлагад идэвхтэй оролцоно. • Тойргийн цагаар “Миний хүсэл” сэдвээр ярилцана. • Үлгэр, өгүүллэгийн үргэлжлэл, төгсгөлийг зохион ярина. • Дуртай киноныхоо өөрт таалагдсан дүрээ төсөөлж, зохиомжлон ярина. • Гэр бүлээрээ аяллаар явсан тухайгаа ярина. • Өөрийн болон хамтын бүтээл (зурсан, өрж байгуулсан, зохиож бүтээсэн) –ээ тайлбарлаж ярина. • Юмс, үйл явдлын учир шалтгаан, холбоо хамаарлыг тайлбарлаж ярина. Жишээ нь: Цастай ойд явсан анчин цагаан туулайг яагаад харсангүй вэ? • Яаж, хаана, хэзээ, яагаад ийм юм бэ? асуултыг тавина. 	

	I түвшин	II түвшин	III түвшин
	Уншиж, ярьж өгсөн богино үлгэр, өгүүллэгийн агуулгыг ойлгох, асуултад 1-2 үгээр хариулах	Уншиж, ярьж өгсөн үлгэр, өгүүллэгийн агуулгыг ойлгох, өөрийнхөөрөө давтан ярих	Үлгэр, зохиолын үйл явдлыг ойлгомжтой, дэлгэрэнгүй ярих, зохиомжлон ярих
Хүүхдийн жишиг үйл			
5. Уншиж, ярьж өгсөн эхийг ярих	<ul style="list-style-type: none"> • Номын зургийг анхааралтай харна. • Зурагт хэн, юу байна, хийж байгаа үйлийг зааж нэрлэнэ. • Номыг сонирхон үзэж “Энэ юу вэ? гэж асууна. • Шинээр мэдэж авсан үгээ давтан хэлнэ. • “Үлгэрийг сонирхон сонсоно. (Энэ хэн бэ?, Өвгөн хэнийг дуудсан бэ?, Өвгөн, эмгэн хоёр хэнийг дуудсан бэ?) • “Туулай дэгдүүлэх” аман наадмыг сонсож, асуултад үйл хөдлөлөөр хариулна. • Хуруун хүүхэлдэйгээр сонссон үлгэрийнхээ дүрд хувирч, үгийг нь давтана. 	<ul style="list-style-type: none"> • Богино үлгэрийг анхааран сонсоод, ойлгосон хэсгээ багшийн тусламжтай ярьж өгнө. • Үлгэр, өгүүллэг сонсоод, дүрүүдийн хэлсэн үгийг өөр өөр дууны өнгө аясаар илэрхийлж ярина. • Ярих үедээ ая дуу ашиглана. Жишээ нь: Өнхрүүш үлгэрийг ярьж байхдаа холбогдох хэсэгт нь аялгуулан дуулна. • Шүлэг, зүйр цэцэн үг, оньсогыг зургаар уншина. Зурагтай номын эхийг хуруугаараа зааж зохиож уншина. • Үлгэрийн баатруудын дүрд хувиран тоглоно. 	<ul style="list-style-type: none"> • Үлгэр, зохиол (Жишээ нь: А.С.Пушкин “Алтан загасны үлгэр”)-ыг анхааран сонсоно, бусдадаа хэсэг хэсгээр нь нэг нэгээрээ үргэлжлүүлэн ярина. • Үзсэн хүүхэлдэйн киногоо бусдад ярина. • Багшийн эхэлсэн яриаг үргэлжлүүлэн зохиож (Марал ээж аавтайгаа ойд зугаалж явтал гэнэт ширүүн бороо орлоо) ярина. • Үлгэрийн эхлэл, өрнөл, төгсгөлийг зохиож ярина. Жишээ нь “Зараанд тохиолдсон явдал” үлгэрт зараа зугаалахдаа юу юу бэлтгэсэн бэ?, Ой мод руу явах замдаа ямар сонирхолтой зүйлтэй тааралдсан бэ?, Түүнд юу тохиолдсоныг зохиож яриарай гэх мэт • Мэддэг зохиолын агуулгаар багш (эцэг эх)-тай хамтран ном бүтээнэ, тайлбарлан ярина.

	I түвшин	II түвшин	III түвшин
	Зургаас өөрийн мэддэг зүйлийг заах, нэрлэх	Үйл явдлыг харуулсан зургийн агуулгыг ойлгох, тайлбарлан ярих	Орчиндоо байгаа тэмдэг тэмдэглэгээг мэдэх, утгыг тайлбарлах
6. Зураг, тэмдэг тэмдэглэгээний утгыг хэлэх	Хүүхдийн жишиг үйл		
	<ul style="list-style-type: none"> Зургийг ижилсүүлж тавина. Хүүхэд өөрийн таних тэмдгийг таньж хэрэглэнэ. Тоглоом болон эд зүйлсийг зурган тэмдэглэгээний дагуу байранд нь тавьж хураана. Жишээ нь: машины машины зурагтай тавиур дээр, бөмбөгийг бөмбөгийн зурагтай сагсанд хийх, халбагыг халбаганы зурагтай сагсанд хийх. 	<ul style="list-style-type: none"> Гар угаах дарааллын зургийг дагаж хийнэ. Ангийн дүрмийг зургаар уншиж, утгыг тайлбарлана. Жолооч, замын цагдаа болж тоглохдоо замын тэмдэг тэмдэглэгээг ашиглаж тоглоно. Сургалтын төвүүдийн таних тэмдэг, зургийн утгыг хэлнэ. Замын хөдөлгөөний зөвшөөрсөн, хориглосон тэмдгийн тайлбарлана. Зургаар өгсөн аргачлалыг дагаж наах, барих, бүтээх үйл хийнэ. 	<ul style="list-style-type: none"> Шатаар өгсөх, уруудахдаа зургаар харуулсан шатны дүрэм (баруун гар талыг барьж явах, шатаар уруудахдаа нэгнийгээ түлхэхгүй гэх мэт)-ийг баримтална. Гар угаах дарааллын зургийг тайлбарлана, дагаж хийнэ. “Болно, болохгүй” Хүүхдийн хийж болох, болохгүй зүйлсийг харуулсан зургийг “зөвшөөрсөн”, “хориглосон” тэмдгээр тэмдэглэнэ. Цэцэрлэг, ангид байгаа аюулгүйн гарц, ариун цэврийн өрөө, эмчийн өрөөний тэмдгийг нэрлэнэ, тайлбарлана. Цэцэрлэгийн гадаа талбайд (эсвэл ангид байгуулсан) 4 замын уулзвар дээр жолооч, явган зорчигч болж, гэрлэн дохио хэрэглэн тоглоно. Зурган аргачлал, зааврын дагуу барьж байгуулна, наана, угсарна, эвлүүлнэ.
7. Төрөл бүрийн зураас (шулуун, долгион тахир, нуман,...) зурах	I түвшин	II түвшин	III түвшин
	Харандааг зөв барих, эрээчиж сараачих	Харандаагаар хүрээнээс гаргахгүй будах, цэг холбон зурах	Энгийн (шулуун, долгион) зурлага бичих
	Хүүхдийн жишиг үйл		
	<ul style="list-style-type: none"> Хананд байрлуусан самбар, ватум цаасан дээр тосон, эсгийн харандаагаар сараачина. Хуудас цаасан дээр тосон харандаагаар эрээчинэ. Усан будаг, гуашаар толбо үүсгэн тоглоно. Жишээ нь: хуруу, гарын алгаар дарах 	<ul style="list-style-type: none"> Резин, савх, шүдэнзний модоор дүрс бүтээж тоглоно. Дүрс, эд зүйлс, хүн амьтныг хүрээнээс гаргахгүй будна. Дүрс, эд зүйлс, амьтан, шувууг ижлийг олж зураасаар холбоно. Цэгүүдийг холбож эд зүйлс дүрслэн зурж, тоогоор нь өнгө ялгаж будна. 	<ul style="list-style-type: none"> Шулуун зураасаар авто машины зам, явган хүний зам зурна. Самны шүдийг эгц, хооронд нь ойролцоо зайтайгаар гүйцээн зурна. Хуудас цаасан дээрх цэгүүдийг холбож дүрс, цифр үүсгэнэ. Харандаагаа салгалгүйгээр өндөр уул зурна. Голын урсгалыг долгионтуулан зурна. Үүлэн болон алхан хээг цэгүүдийн дагуу харандаагаар хээлж зурна.

БАЙГАЛЬ, НИЙГМИЙН ОРЧИН

Хүснэгт 4. Байгаль, нийгмийн орчин

			Агуулга			
			I түвшин	II түвшин	III түвшин	
			Орчны юмсыг сонирхох, нэрлэх	Орчны юмсын онцлог, шинж чанар(хатуу, зөөлөн гэх мэт)-ыг нэрлэх	Орчны юмсын ялгааг таних, илрүүлэх	
			Хүүхдийн жишиг үйл			
1. Орчны юмсыг сонирхох, таних, нэрлэх				<ul style="list-style-type: none"> • Ойр орчинд байгаа эд юмсыг сонирхож, барьж үзнэ, нэрлэнэ. • Нэрлэсэн юмс, тоглоом наадгайг заана, авч ирнэ. Жишээ нь: “Тоглоомоо нэрлэцгээе”, “Хүүхэлдэйд хувцас сонгоё” гэх мэт. • “Шидэт хайрцаг” тоглоом тоглоно. Хайрцаг дотор байгаа зүйлсийг тэмтэрч юу олсноо хэлнэ. • Ойр орчинд байгаа эд юмс (ширээн дээр хоолоо тавьж иднэ, сандал дээр сууна, харандаагаар зурна, хүүхэлдэй, машинаар тоглоно гэх мэт)-ыг юунд хэрэглэдгийг асуухад зориулалтаар нь заана, хэлнэ. • Усыг нэг савнаас нөгөө саванд юүлэх, усанд хүүхэлдэйн хувцас угаах зэрэг үйлдэл хийж тоглоно. • Тоглоомын талбайн элсээр тоглох, машин, байшин, гэр хийж үзнэ. 	<ul style="list-style-type: none"> • Өөрийн болон бусдын эд зүйл (миний цамц, багшийн цүнх, ангийн тоглоом гэх мэт)-ийг ялгаж хэлнэ. • Ойр орчиндоо байгаа юмсыг тэмтрэх, барьж үзэх зэргээр шинжийг судална. Жишээ нь: Бөмбөг зөөлөн, аяга шилэн, ус шингэн гэх мэт. • Өөрийн эргэн тойрны эд юмсыг ажиглаж болгоомжтой харьцана. Жишээ нь: Хаалга хаахдаа гараа хавчуулахаас болгоомжлох, шилэн аяга хагалахаас сэргийлэх гэх мэт. • Усаар тоглож, усны шинжийг тодорхойлно. Жишээ нь: Ус урсгах, саванд хийх, дүүргэх, халиулж асгах, хэд хэдэн шингэн зүйлсийг холих • Амьгүй зүйлсийг байрнаас нь хөдөлгөхийн тулд түүнийг түлхэх, татах, шидэх гэх мэт туршилт хийж үзнэ. • Ажиглаж олж мэдсэн зүйлийнхээ талаар (чулуу өргөж үзэхэд хүнд, бас хатуу байсан гэх мэтээр шинж чанарыг нь тодорхойлон) ярина. • Мэдрэхүйн тусламжтайгаар эд зүйлс, хүнсийг дуу чимээ, үнэр, амт, хийсэн материалаар нь ялгаж таних (чихэртэй, чихэргүй аарц амтлах, хатуу зөөлөн ааруул идэж үзэх гэх мэт) туршилт хийнэ. 	<ul style="list-style-type: none"> • Сургалтын хэрэгсэл томруулагч шил, жинлүүр, шугам, гэх мэт зүйлсийг ашиглан ойр орчныхоо юмс, ургамлыг судална. • Сонирхолтой ажиглалт туршилтууд хийнэ. Жишээ нь: Цасан дээр мөр гаргах, урсгал усанд цаасан болон модон завь хийж урсгах, цаасаар сэнс хийж эргэлдүүлж тоглох. • Юмсын шинж чанарыг туршиж үзнэ, тодорхойлж ярина. Жишээ нь: Ноос хөнгөн учраас хийсдэг, баримлын шаврыг халуун усанд хийхэд зөөлөрдөг. • Юмсын талаар таамаглал дэвшүүлнэ, туршиж үзнэ. Жишээ нь: Хөвдөг, живдэг, уусдаг, уусдаггүй зүйлс. • Байгалийн болон хүний бүтээсэн эд юмсыг ялгана. Жишээ нь: Модоор ширээ, сандал хийсэн. • Юмс, үзэгдэлтэй холбогдох “Яагаад?” гэсэн асуулт дэвшүүлж, хамтдаа хариулт олно. Жишээ нь: Яагаад мөс долоож болохгүй вэ? Яагаад мод навчаа гөвдөг вэ?, Яагаад цагаан идээ идэх хэрэгтэй вэ?

I түвшин	II түвшин	III түвшин
Орчныхоо ургамал, амьтныг сонирхох, нэрлэх	Орчны ургамал, гэрийн тэжээмэл амьтдыг онцлог шинжээр нь таньж ялгах, тайлбарлах	Ургамал, амьтныг хайрлах, арчлах
Хүүхдийн жишиг үйл		
<p>2. Ургамал, амьтныг ажиглах, таньж мэдэх, арчлах</p> <ul style="list-style-type: none"> • Ойр орчиндоо байгаа цэцэг, мод, амьтныг нэрлэнэ. Жишээ нь: Нохой, шувуу, загас. • Мэддэг амьтныхаа дуу авиа, хөдөлгөөнийг дуурайж тоглоно. Жишээ нь: Шувууд нислээ, Нохой гүйлээ, Туулай дэгдлээ. • Цэцэг услах, навч арчихыг ажиглаж дуурайна. • Мэддэг зүйлээ мод, нохой, шувуу, цэцэг зэргийг зурагнууд дотроос ялгаж, танина, заана. 	<ul style="list-style-type: none"> • Гадаа талбай дахь ургамлыг судална, олж мэдсэнээ тайлбарлаж ярина. Жишээ нь: Цэцгүүдийн өнгө, хэлбэр дүрс, модны навчны ялгаа. • Байгалийн булан дахь ургамлуудыг ажиглаж, гарч байгаа өөрчлөлтүүдийг (навч цухуйсан байна, навч бүтэн гарсан байна, цэцэг дэлгэрсэн байна гэх мэтээр) зурж, тэмдэглэн ярилцана. • Аяллаар модны навч улирал бүр хэрхэн өөрчлөгддөгийг ажиглана, зурна. • Байгалийн музей үзэх, амьтны дэлгүүрт очихдоо нохойны бие үстэй, шувуу өдтэй байдаг гэх мэт гадаад онцлогийг ажиглаж сонирхоно, ярилцана. • Амьтдыг хөдөлгөөнөөр нь таагаарай, Сүүдрээр нь таниарай, Амьтдыг дуугаар нь ялгаарай гэх мэт тоглоом тоглоно. • “Аль нь хурдан вэ?” Хорхой шавжны зургийг хурдан, удаан явдгаар нь дараалуулж байрлуулна. • Яагаад? гэсэн асуулт дэвшүүлж, учрыг нь хамтдаа ярилцаж олно. Жишээ нь: Нохойны бие яагаад үстэй байдаг вэ? Загас яагаад усанд амьдардаг вэ? 	<ul style="list-style-type: none"> • Ургамал арчилж ургуулах ажилд оролцоно. Жишээ нь: Ургамал шилжүүлэн суулгах, үрслүүлэх, зөв услах, нартай газар тавих, савны амсрын шороог арчих, навч цэвэрлэх. • Хүнсний ногоо (төмс, сонгино гэх мэт) үрслүүлнэ, ургаж буй явцыг ажиглана, туршлагын талбайд хөрс бутлах, төмс тарих, хураах гэх мэт ажилд оролцоно. • Цонхны гэрэл болон харанхуй газарт ижил үрсэлгээ хийж тавиад, хооронд нь харьцуулна, ялгаа гарч буй эсэхийг ажиглана, зурж тэмдэглэнэ, ярилцана. • Ижил савтай 2 цэцгийн нэгийг нь усалж, нөгөөхийг нь услахгүй байхад гарах ялгааг олж харна, ярилцана. • Ангидаа буюу гэртээ байгаа амьтанд хоол тэжээл өгөх, байр савыг нь цэвэрлэх ажилд оролцоно, дараа нь яагаад гараа заавал угаахыг тайлбарлана. • Малчны хотонд очиж малд өвс өгөх, малын хашаа цэвэрлэх ажилд чиглүүлгийн дагуу оролцоно. • Яагаад ус бохирдуулж болохгүй вэ? сэдвээр (голын усыг бохирдуулбал ус ширгэж амьтан, ургамал үхнэ гэх мэт) хамтдаа ярилцана. • “Морь уная” Мориныхоо аль талаас мордох, ташуураа яаж барих, хэрэглэх гэх мэтээр морьтой хэрхэн харьцахыг ярилцана. • Аяллын явцад байгальтай хэрхэн харьцах (ургамал гэмтээхгүй, мод хугалахгүй, хог хаяхгүй гэх мэт) талаар дүрэм зохионо.

	I түвшин	II түвшин	III түвшин
	Байгалийн үзэгдэл (цас, бороо, салхи)-ийг нэрлэх	Ямар улирал болж байгаа, тухайн үед цаг агаар, амьтан, ургамалд гардаг өөрчлөлтийг сонирхох, тайлбарлах	Улирал, цаг агаарын байдалд тохируулан хувцаслах, хийх үйлээ (нартай үед сүүдрэвчин дор тоглох, бороотой үед шүхэр барьж явах) тохируулах
Хүүхдийн жишиг үйл			
3. Улирал, цаг агаарын өөрчлөлтийг сонирхох, ялган таних	<ul style="list-style-type: none"> • “Бороо орлоо” Багш ус шүүшигч ашиглан хүүхдүүдийн дээрээс цацахад, борооноос нуугдаж шүхэр доогуур орно. • Тогтоол ус туучих, цасан дээр гишгэж явах, цасыг бөөрөнхийлж бөмбөг хийх зэргээр ус, цасаар тоглоно. • Зугаалгаар цаасан сэнс гартаа барьж гараад салхитай, салхигүй байгааг хэлнэ. • Цасан дээр мөр гаргана. • “Цас хаачив?” туршилт хийж, цасыг хайлуулж үзнэ. 	<ul style="list-style-type: none"> • Хавар, зун, намар, өвлийн улирлын өөрчлөлтийн талаар (хавар мод нахиалж ургадаг, намар модны навч шарлаж унадаг гэх мэт) зурагт ном, кино үзэж ярилцана. • “Өвөл, зуны хувцас” Хувцаснуудын зургийг өвөл, зуны байгалийг харуулсан зургийн дор аваачиж байрлуулна. • Сэнсээр салхи үүсгэх, солонго, бороо үүсгэх (буцалж байгаа усыг хүйтэн тагаар таглаж 2-3 минутын дараагаар таглаж, усан дуслууд үүсгэх) зэрэг туршилт хийнэ. • “Шувууд сүрэглэн ирлээ.”, “Шүрэн цох хаачсан бэ?” тоглоом тоглоно. • Өдөр бүрийн цаг агаарын өөрчлөлтийг ажиглаж, багштай хамтран “Цаг агаарын хуанли” хөтөлнө. 	<ul style="list-style-type: none"> • Улирал бүрийн хувцасны загвар үзүүлж тоглоно. • Цаг агаарын байдал харуулсан зурагнуудаас ээлжилж авч, дулаахан өдөр гадаа тоглож болно, хүйтэн салхитай байвал дулаан хувцсаа өмснө, бороотой үед шүхэр барьж гадаа гарна гэх мэтээр нэрлэж тоглоно. • Навч, боргоцой, цас, мөс, чулуу, цэцгийн хатаамал зэргийг ашиглаж улирлын ялгааг харуулсан бүтээл хийнэ. • Хөтөлсөн “Цаг агаарын хуанли”-гаа ашиглан хүүхдүүд хоорондоо ярилцаж, хийх үйлээ сонгоно. Жишээ нь: Өнөөдөр нартай байна гадаа тоглоё, салхитай байгаа тул сэнс хийж тоглоё. • “Аврагч мазаалайн зөвлөмж” цуврал (зуд, шуурга, газар хөдлөлт, үер ус) хүүхэддэйн кино үзэж, хүчтэй цасан болон шороон шуурганаар гадаа явбал төөрөх, даарах аюултай тул бусдаас тусламж хүсэх, дулаан хувцас өмсөх тухай ярилцана. • Гадаа талбайд тоглохдоо хэт нартай байвал сүүдрэвчинд тоглох, гарахдаа нарны малгай өмсөх, шингэн зүйл сайн уух гэх мэт санаанууд гарган ярилцана, Зөв үү, буруу юу тэмдэглэл хийнэ.

	I түвшин	II түвшин	III түвшин
	Өөрийгөө болон гэр бүлээ танилцуулах, ойр орчныхоо хүмүүсийн хийж буй үйлийг сонирхох, нэрлэх	Өөрийн амьдардаг газар (аймаг, хот, дүүрэг, сум), хүмүүсийн ажил хөдөлмөрийн тухай ярих	Өөрийгөө ямар үндэстэн гэдгийг хэлэх, бусад үндэстнээс юугаараа ялгаатайг тайлбарлах
4. Ойр орчныхоо хүмүүсийн онцлогийг таньж мэдэх	Хүүхдийн жишиг үйл		
	<ul style="list-style-type: none"> • Гэр бүлийн зураг дээр аав, ээж, ах, эгч, дүү нарын зургийг заана, нэрийг хэлнэ. • Өөрийнхөө талаар бусдад ярина. Жишээ нь: Гэр бүлийн зургаа харж, Би энэ байна, би алим идэх дуртай, би пүүзээ өмсөнө гэх мэт. • Ойр дотны хүмүүсийнхээ хийж буй үйл (аяга угаах, ногоо арилгах гэх мэт)-ийг сонирхоно, дуурайн оролцоно. • Машин жолоодно, хүүхэлдэйгээ хооллоно, үсийг нь самнаагэх мэтээр тоглоно. • Хүмүүс юу хийж байгааг асуухад багш дуу дуулж байна. Ээж хоол хийж байна гэх мэтээр хариулна. 	<ul style="list-style-type: none"> • Өөрийн улсын нэрийг хэлнэ. • Өөрийн амьдардаг хот (аймаг, сум)-ын нэрийг хэлнэ. Жишээ нь: Улаанбаатар хот, Завхан аймаг, Цэцэрлэг сум. • Аав, ээж нь ямар ажил хийдэг тухай ярина. • Хүмүүс янз бүрийн ажил хийдэг. Эмч хүмүүсийг эмчилдэг, үсчин хүмүүсийн үсийг засдаг гэх мэт тэдгээрийн ялгааг харуулсан зураг харж ярина. • Ажил мэргэжилтэй холбоотой “Зургийг холбоорой”, “Надад туслаарай” зэрэг дасгал ажиллана. • Хүмүүсийн ажил мэргэжлийн онцлогийг дуурайн эмч, тогооч, багш, малчин гэх мэт сэдэвт тоглоомоор тоглоно. • Малчин, Хот айл сэдвээр (чулуугаар, шагайгаар) өрж байгуулж тоглоно. • Цэцэрлэгт ажилладаг хүмүүсийн ажил мэргэжилтэй танилцах аялал хийнэ. Жишээ нь: Гал тогоотой танилцах, эмчийн өрөөгөөр орж үзэх. 	<ul style="list-style-type: none"> • Янз бүрийн (орос, англи, монгол)хэлээр ярьж буй хүмүүсийн бичлэг сонсоод, монголоор ярьж байгаа хүний яриаг ялгаж хэлнэ. • Монголын далбаа мандаж, төрийн дуулал эгшиглэж байгаа бичлэг (баяр ёслолоор, тамирчид олон улсын уралдаан, тэмцээнд түрүүлэхэд гэх мэт) үзнэ. • Төрийн далбаа зурна. • Манай улсад амьдардаг үндэстэн (монгол, казах), баярын тухай кино үзнэ. • Монгол үндэсний тоглоом наадмаар тоглоно. Жишээ нь: Алаг мэлхий өрөх, оньсон тоглоомоор тоглох, аман наадам хэлэх. • Айл гэр болж тоглохдоо дээл мялаах ерөөл хэлнэ, малгай, бүсээ дээш нь тавьж тоглоно. • Монгол гэр (тоглоомон) барьж, буулгаж тоглоно.

МАТЕМАТИКИЙН ЭНГИЙН ТӨСӨӨЛӨЛ

Хүснэгт 5. Математикийн энгийн төсөөлөл

Агуулга		
I түвшин	II түвшин	III түвшин
Нэг ба олныг ялгах	Тоолох, тоогоор нь харьцуулах, нэмэгдүүлэх, хорогдуулах, дэс тоо хэрэглэх	Тооны цифр, тэмдэг тэмдэглэгээ хэрэглэх, хялбар бодлого (нэгээр нэмэгдүүлэх, хорогдуулах) зохиох, бодох
Хүүхдийн жишиг үйл		
<p>1. Тоолох, тоо бодох</p> <ul style="list-style-type: none"> Нэг эд зүйл, хүн, амьтныг заагаад “Хэдэн байна вэ?” гэж асуухад хариулна. “Багшдаа олон тоглоом (бөмбөг, машин гэх мэт), эд зүйл (харандаа, халбага гэх мэт) аваад ир дээ?” гэхэд олныг авч ирнэ. Нэг нэг бөмбөгийг нийлүүлж, олон болгоно. Олон, цөөн хүний зураг хараад олон, цөөнийг ялгаж хэлнэ. Орчиндоо байгаа зүйлээс олон ба нэг юмыг олж харж хэлнэ. Жишээ нь: Манай ангид хүүхэлдэй олон байна уу, нэг байна уу? гэхэд хариулна. 1-3 тоглоомыг тоолоод, дүн тоог хуруугаараа харуулна, хэлнэ. 	<ul style="list-style-type: none"> 10 хүртэл эд зүйл(шагай, савх, бөглөө, дүрс, зурган карт, тоглоом, чулуу гэх мэт)-ийг оноож тоолоод, дүн тоог хэлнэ. Тодорхой тооны эд зүйлээс нэг нэгээр хорогдуулж, үлдсэнийг нь тоолж дүн тоог хэлнэ. Хоёр бүлэг зүйлсийг тоолж, харьцуулна, аль нь олон байгааг хэлнэ. Жишээ нь: Тавиурын дээд талд 5 машин, доод талд 3 машин 10-ын доторх эд зүйл, хүн, амьтны зургийг тоолоод тэнцүү биш байгаа тохиолдолд нэг нэгээр нэмэгдүүлэх буюу хорогдуулах замаар тэнцүү болгоно. Тоглохдоо дэс тоо хэрэглэнэ. Жишээ нь: Би эхлээд, хоёрдугаарт Мөнхөө, гуравдугаарт Жаргалмаа “Уутан дотор хэдэн шагай байна вэ?” Тэмтэрч тоолоод, дүн тоог хэлнэ. Дуу чимээ, хөдөлгөөнийг тоолж тоглоно. Жишээ нь: Багшийн бөмбөрийн цохилтоор тохирох тооны дүрс байрлуулах, ширээ тогших эсвэл алга таших. Ширээнд суусан хүүхдийн тоогоор аяга, халбага, сэрээ авч байрлуулна. 2 шар, 1 улаан, 2 хөх дугуй дүрстэй туузны дор өнгө, тоогоор нь ижилхэн дүрс байрлуулж тавина. 	<ul style="list-style-type: none"> Савх, шүдэнзний мод, баримлын шавраар, нэмэх, хасах тэмдэг, цифрийг дүрслэн тоглоно, агаарт дуурайлган бичнэ. Хэвлэмэл цифр дээр хуруугаараа давхарлан бичнэ. 0-10-ын цифрийг нэрлээд, дэс дарааллын дагуу байрлуулна. 10-ын доторх тооны дүрс, эд зүйлс, амьтны зургийг тоолоод, тохирох цифртэй холбоно. Багштайгаа хамтран сургалтын хэрэглэгдэхүүн бэлтгэнэ. Жишээ нь: Янз бүрийн тооны эд зүйлстэй картууд, сургах тоглоомын материал, цифр Төрсөн өдөр, гэрийнхээ хаалганы дугаарыг хэлнэ, цифрээр харуулна, утсанд дуудлага хийнэ. 1 ба 2-оор нэмэгдүүлэх буюу хорогдуулах сонирхолтой бодлого зохиож, бусад хүүхдээр бодуулна. Жишээ нь: Чамд 3 шагай байна гэж бодъё, 1 шагай нэмж өгвөл чи нийт хэдэн шагайтай болох вэ?, 2 алимыг 4 хүүхэд яаж тэнцүү хувааж идэх вэ? гэх мэт. Эд зүйлс, дүрс, зураг ашиглан тоог хоёр буюу хэд хэдэн бага тоо болгон задлах дасгал хийнэ. Жишээ нь: 5-ийг 1,1,1,1,1 мөн 4 ба1, 3 ба 2 болгох. “Шагай түүх, шүүрэх”, “Чулуу таалцах”, “Хорол” гэх мэт ардын тоглоомоор тоглоно. Шүрийг давтамж (1 шар, 2 улаан, 1 шаргэх мэтээр) үүсгэн хэлхэнэ. Хэмжээ (2 том дугуй, 2 жижиг дугуй гэх мэтээр үргэлжлүүлэн байрлуулах), хэлбэр дүрс (1 дөрвөлжин, 3 гурвалжин), хөдөлгөөн (2 удаа алга ташаад 1 удаа хөлөө дэвсэх)-өөр давтамж үүсгэн тоглоно.

	I түвшин	II түвшин	III түвшин
	Эд юмсыг хэмжээгээр нь (том, жижиг) ялгаж заах, нэрлэх	Энгийн хэрэгсэл (харандаа, бичгийн хавчаар гэх мэт) ашиглан эд зүйлсийг хэмжих	Төө, сөөм зэрэг уламжлалт хэмжүүр ашиглан эд зүйлсийг хэмжих, шингэн бутармаг зүйлсийг тохирох хэрэгсэл (халбага, аяга, шанагаар гэх мэт)-ээр хэмжих
Хүүхдийн жишиг үйл			
2. Хэмжих, хэмжээг ялгах	<ul style="list-style-type: none"> • Аавын гар том, миний гар жижиг, том бөмбөг, жижиг бөмбөг, багшийн сандал том, миний сандал жижиг гэх мэтээр том, жижгийн ялгааг хэлнэ. • Хэмжээгээрээ эрс ялгаатай тоглоом (том, жижиг бөмбөг, хүүхэлдэй гэх мэт), эд юмсыг ижил ижлээр нь сагсанд хийнэ, тавиурт байрлуулна. • Том хайрцаг дотор жижиг хайрцгийг хэмжээгээр нь дараалуулан хийнэ. • Суварган тоглоомыг давхарлан тавьж өрж тоглоно. • Том машинд том бамбарууш, жижиг машинд жижиг хүүхэлдэйгээ суулгах гэх мэтээр тоглоно. 	<ul style="list-style-type: none"> • Харандаа, үдээс, туузыг, хамгийн уртаас нь богино руу нь, модыг өндөр, нам хэмжээгээр нь дараалуулан байрлуулна. • Янз бүрийн урт, өргөнтэй эд зүйлс (тууз, хүзүүний ороолт гэх мэт)-ийг давхцуулан, урт, богино, өргөн, нарийныг харьцуулж хэлнэ. • Тууз, утас, үдээс, шугам, харандаа, савх мод зэргийг хэмжүүрийн нэгж болгон авч, ангид буй тавилга, эд зүйл (ширээ, тавиур, ном, дэвтэр гэх мэт)-ийг хэмжээд, үр дүнг дүрс, зургаар тэмдэглэж, хэлнэ. Жишээ нь: Ширээний урт нь хэмжиж байгаа 8 харандаатай тэнцэж байна. • Өндөр, намаараа жагсана. Манай ангийн хамгийн өндөр нь хэн бэ?, Хамгийн намхан нь хэн бэ? • Баримлын шаврыг хоёр тэнцүү хэсэгт хуваагаад бүдүүн, нарийн болгоно. • Бөмбөг өнхрүүлж тоглож байхдаа надад хэн ойр, хэн хол байгааг хэлнэ. 	<ul style="list-style-type: none"> • Ширээний урт, өргөнийг төө (сөөм)-гөөр хэмжиж, урт нь 10 төө, өргөн нь 5 төө гэх мэтээр хэмжээг нэрлэж хэлнэ. • Олс, бүс, уяаг алдлан хэмжиж, хэдэн алд болсныг хэлнэ. • Найзынхаа дээлний уртыг төөлж хэмжинэ. • Жин туухайгаар тоглоомон жимс, хүнсний ногоог хэмжиж, хүнд хөнгөнөөр ялгаж байрлуулна. • Алхмаар хаалганаас ширээ хүртэлх зайг хэмжээд, алхмын тоог дүрсээр тэмдэглэнэ. Дүрсээ тоолж хэдэн алхам зайтайг хэлнэ. • Хуудас цаас, туузан цаасыг хоёр, дөрөв ба найман хэсэгт тэнцүү хуваана. • Ус, сүү, будаа, элсэн чихрийг аяга, халбага, уутаар хэмжинэ. Жишээ нь: Хэмжилтийг том ширхэгтэй зүйлээс эхэлнэ. (Гоймон, үр тариа, будаа, ус гэх мэт. Шилэн аягаар усыг хэмжихдээ дундуур, дүүрэн хийх, усны түвшинг ижил хэмжээнд байлгах гэх мэт) • Бүхлээс хэсэг, хэсгээс бүхэл үүсгэнэ. Жишээ нь: Алим, пицца, бялуу хуваах, талх зүсэх, угсардаг тоглоомыг задлах, угсрах. • Тоглоомын явцад “хурдан”, “удаан” гэсэн үгийг хэрэглэнэ. Жишээ нь: Үлээж бэлтгэсэн бөмбөлөгийн нэгийг нь цоолоод, нөгөөгийнх нь амыг нээлттэй тавихад аль бөмбөлөгийнх нь хий хурдан гарч байгааг хэлнэ. • Зузаан номыг аваад өгөөрэй, нимгэн дэвтрээ хураагаарай гэх мэт үгсийг ойлгож, биелүүлнэ.

	I түвшин	II түвшин	III түвшин
	Эд зүйлсийг ижлээр нь ялгах, нэгийг нөгөөд оноох	Эд зүйлсийг аль нэг шинж чанараар нь (хэмжээ, хэлбэр, дүрс, өнгө, хийсэн материал зэргийн аль нэгээр нь) ангилах, ижилсүүлэх	Юмсыг хоёр буюу түүнээс дээшшинж чанараар нь (том, гурвалжин дүрс эсвэл улаан дугуй дүрс гэх мэт) ангилах, дараалуулах, давтамж үүсгэх
Хүүхдийн жишиг үйл			
3. Хэлбэр дүрс, өнгийг тодорхойлох	<ul style="list-style-type: none"> • Савтай дүрснээс дугуй дүрсийг авч дугуй дүрсний зурагтай сагсанд хийнэ. • Адил зүйлсийг олно, хамтад нь тавина. Жишээ нь: Бөмбөг, машинуудыг тус тусад нь тавих. • Гурвалжин, дөрвөлжин, дугуй дүрсийг ялган таньж, тохирох хэвэнд хийж тоглоно. • Янз бүрийн хэлбэр дүрстэй соронзон (лего) өрж байгуулах, угсрах тоглоомоор тоглоно. • Өрж байгуулах тоглоомыг адилхан өнгө (улаан, шар, хөх зэрэг)-өөр тэмдэглэсэн тавиурт хураана. • Зааврын дагуу дөрвөлжин, дугуй, гурвалжин дүрсээр энгийн зүйл (ор, хашаа, байшин гэх мэт) бүтээнэ. 	<ul style="list-style-type: none"> • Эд юмс янз бүрийн хэлбэртэй байдгийг ажиглаад хэлбэр дүрс, (бөмбөг шиг бөөрөнхий, цонх шиг гэх мэт)-ээр зүйрлэж хэлнэ. • Манай ангид дөрвөлжин дүрстэй юу юу байна вэ? Ангид буй тавилга, тоглоом, хэрэгслээс дөрвөлжин дүрстэй зүйлс (цонх, хаалга, ширээний тавцан, ном, дэвтэр гэх мэт)-ийг олж, зааж харуулна, нэрлэнэ. • Дугуй дүрс өнцөггүй, гурвалжин 3 өнцөгтэй, дөрвөлжин 4 өнцөгтэй гэх мэтээр өнцөг, талыг тоолно, ялгааг хэлнэ. • Бэлэн дүрсүүдээс дугуй дүрсийг олоорой, бүх дөрвөлжин дүрсийг ялгаарай, бүх гурвалжинг түүж аваарай, байшинг дээвэрлээрэй зэргээр тоглоно. • Эд юмсыг хэлбэр ба хэмжээ, хэлбэр ба өнгө гэх мэт 2 шинж чанараар харьцуулна. Жишээ нь: Том, жижиг дугуй, дүрс, ижил өнгөтэй дугуй, дөрвөлжин дүрс. • Тоглоомоо цаасан, хуванцар, модон, үстэй гэх мэт хийсэн материалаар нь ялгаж ангилна. • Савх, шүдэнз, утсаар дүрс үүсгэж тоглоно. 	<ul style="list-style-type: none"> • “Дүрсүүдийг ялгая.” Дугуй, дөрвөлжин, гурвалжин дүрсүүдийг хэлбэр, хэмжээ, өнгөөр нь ангилна. • Дүрсүүдийг тэмтэрч мэдрэн, шинж чанарыг нь тодорхойлон хэлнэ, тоолно. Жишээ нь: Өнцөгтэй, хатуу, зөөлөн, гөлгөр, барзгар. Өнцөгтэй дүрсүүд хатуу байна. • Бөмбөгүүдийг өнгөөр нь ялгаж, ижил өнгөтэй сагсанд хураагаарай, Улаан өнгөтэй дугуй дүрсүүдийг ялгаарай, Том дугуй дүрсүүдийг ялгаарай гэх мэтээр өнгө, хэмжээ, хэлбэр дүрсээр ангилна. • Бэлтгэсэн дүрсүүдээс дугуй дүрсийг улаан хайрцагт, бөөрөнхий зүйлсийг ногоон хайрцагт, дөрвөлжин дүрсийг сагсанд, шоог хайрцагт гэх мэтээрхавтгай ба биет дүрсүүдийг ялгаж хураана. • Дугуй, дөрвөлжин, гурвалжин дүрсийг өнгө, хэмжээгээр нь дараалуулж давтамж үүсгэж тоглоно. Жишээ нь: Нэг улаан дөрвөлжин, нэг хөх дугуй, нэг шар гурвалжин, нэг улаан дөрвөлжин, том улаан дугуй дүрс, жижиг цэнхэр дугуй дүрс, том улаан дугуй дүрс гэх мэт. • Тоглох явцад дүрсийг өнгөтэй нь нэрлэнэ. Жишээ нь: “Долоодой” • Шүрийг өнгөөр нь давтамж үүсгэн хэлхэнэ.

	I түвшин	II түвшин	III түвшин
	“Дээр”, “доор”, “гадаа”, “гэрт” гэсэн байрлал заасан үгийг ойлгох, хэрэглэх	Өөрийн байрлал (өмнө, хойно, баруун, зүүн) -ээс бусад юмсын байрлалыг тодорхойлох	Нэг юмсын байрлалаар нөгөө юмсын байрлалыг тодорхойлно, харааны баримжаагаар юмсын хол, ойрыг төсөөлөн тооцоолно.
Хүүхдийн жишиг үйл	<p>4. Орон зайг баримжаалах</p> <ul style="list-style-type: none"> Ширээн дээр тавиарай, сандал дээр суугаарай, орон доогуур орж нуугдаарай, гадаа гарч тоглоцгооё гэх мэт байрлал заасан үгийг ойлгож биелүүлнэ. Ширээн дээр юу байна вэ?, Ширээн доор юу байна вэ? гэх мэт асуултад хариулна. Өөрийн бие эрхтнийг заана, нэрлэнэ. Эд зүйлсийн байрлалыг асуухад заана. Жишээ нь: Орон дээр хүүхэлдэй байна, тавиур дээр аяга байна гэх мэт. Гэрт хэн хэн байна вэ? Хэн гэрийн гадаа байна вэ? зэрэг асуултад хариулна. Хувцас, эд зүйлсийг хэлсэн байрлалд тавина. Жишээ нь: Сандал дээр хувцсаа тавиарай, Сандал дооргутлаа тавиарай. 	<ul style="list-style-type: none"> Сэдэвт тоглоомын явцад байрлал заасан үгийг хэрэглэнэ. (Жишээ нь: Авдар дээр толь байна, орон дээр дэр байна.) “Миний баруун гар талын сандал сул байна.” тоглоомоор тоглоно. (Хүүхдүүд тойргоор сууж байхад 1 хоосон сандал байна. Сул сандлын хажууд сууж буй хүүхэд “Миний баруун гар талын сандал сул байна. Энэ сандал дээр би цэнхэр цамцтай, хөх өмдтэй, эрэгтэй хүүхэд суухыг урьж байна” гэхэд хүүхдүүд өөрийнхөө хувцсыг хараад тухайн өнгийн хувцас өмссөн эрэгтэй хүүхэд сул сандал дээр очиж сууна. Баруун гар талынх нь сандал суларсан хүүхэд тоглоомыг үргэлжлүүлнэ) Хэний хажууд юу байна вэ? Хүүхдүүд өөрийн хаана юу байгааг нэрлэнэ. Жишээ нь: Миний урд самбар байна, баруун гар талд Болд сууж байна, ар талд цэцгийн тавиур байна. Орон зайг заасан үгийг ойлгож, тоглоно. Жишээ нь: Ширээнээс 5 алхаад зогсоорой, сандлыг 3 тойроорой. 	<ul style="list-style-type: none"> “Юу, хаана байна вэ?” Хүүхдүүд эргэн тойрондоо юу байгааг нэрлэнэ. Жишээ нь: Тавиур дээр тоглоомууд, ширээн дээр аяга байна. Цонхны дэргэд сандал, наана нь бөмбөг байна. Авдрын урд талд ширээ байна, ширээн дээр данх, халуун сав байна. “Багшийн заасан зүгт гүйгээрэй” хөдөлгөөнт тоглоом тоглоно. (Багшийн баруун талд зогсоорой, зүүн талд суугаарай, багшийн хойно зогсоорой.) Монгол гэрт байрлах эд хогшлыг байрлуулж тоглоно. “Юу өөрчлөгдсөн байна вэ?“, “Нэрлэсэн зүйлийг олоорой” зэрэг тоглоом зохиож тоглоно. Зурсан зурган дээрээ хаана нь юу байгааг тодорхойлж хэлнэ. Жишээ нь: Тавиур дээр бамбарууш байна, замын хажууд мод байна. Гэрт аав байгаа, гэрийн гадаа дүү байна. Үүлний цаана нар байна, ээж гэр дээрээ ааруулаа тавьж байна. Харааны баримжаагаар юмсын хол, ойрыг төсөөлөн зурна. Орон зайн байрлал заасан агуулгатай үлгэр, шүлэг, өгүүллэгийг сонсож жүжигчлэн тоглоно, ярилцана. Жишээ нь: Орос ардын үлгэр “Чоно ба долоон ишиг”

	I түвшин	II түвшин	III түвшин
	Одоо, дараа гэсэн хугацаа илэрхийлсэн үгсийн утгыг мэдэх, хэрэглэх	Хоногийн хэсгүүд (өглөө, өдөр, орой, шөнө)-тэй холбоотой үг хэллэгийг яриандаа хэрэглэх	Өнөөдөр, маргааш, өчигдөр гэсэн цаг хугацаа заасан үгсийг ялгах, хэрэглэх, үйл явдлын үргэлжлэх хугацааг баримжаалах
5. Цаг хугацаа заасан үг хэрэглэх	Хүүхдийн жишиг үйл		
	<ul style="list-style-type: none"> • Одоо хоолоо иднэ, дараа нь шүдээ угаана гэх мэт үгсийг ойлгож, хэрэглүүлнэ. • Цайгаа уугаад дараа нь аягаа хураагаарай, Тоглосныхоо дараа тоглоомоо байранд нь тавиарай гэх мэтийг ойлгож, хэрэглүүлнэ. • Одоо дөрвөлжин дүрс наагаарай, дараа нь гурвалжин дүрсийг дээр нь наагаарай гэсэн багшийн зааврыг ойлгож, наамал хийнэ. • Одоо биеийн тамирын хувцсаа өмсөөд, дараа нь заал руу явцгаая гэх мэт багшийн зааврыг ойлгож дагана. 	<ul style="list-style-type: none"> • Өдөр бүр юу хийдэг талаар ярилцана. Жишээ нь: Өглөө цэцэрлэгтээ ирсэн, өдөр найзуудтайгаа тоглосон, унтсан, орой үлгэр сонссон. • Цаг хугацааг илэрхийлсэн дуу дуулна, шүлэг, үгэн наадам, хэлнэ. Жишээ нь: О.Одончимэг “Галт тэрэг” шүлгийг уншиж ярилцана. • Өөрийн төрсөн жилийг хэлнэ. • Тоглох явцдаа цаг хугацаатай холбогдох үг хэллэг, ашиглана. Жишээ нь: “Өдөр ба шөнө” • Хэзээ нар манддаг (өглөө), хэзээ нар жаргадаг (орой)-ийг хэлнэ. • Гэр бүлийнхээ болон өөрийнхөө гэрэл зургийн цомог үзэж, миний хоёр настай үеийн зураг. Өнгөрсөн зун хөдөө явж байхдаа авахуулсан зураг гэх мэтчилэн цаг хугацааг тодорхойлж ярина. 	<ul style="list-style-type: none"> • Өдөр бүр өчигдөр орой гэртээ юу хийсэн болон өнөөдөр, маргааш юу хийх тухай ярилцана. • Өнөөдөр, маргааш, өчигдөр гэсэн үгийг яриандаа хэрэглэнэ. Жишээ нь: Өнөөдөр бид зураг зурна. Маргааш кино үзнэ. Өчигдөр ногоотой шөл, бууз идсэн. • Хоногийн хэсгийг тодорхойлон яриандаа хэрэглэнэ. Жишээ нь: Дугуй эсвэл дөрвөлжин дүрсийг дөрвөн хэсэг (өглөө, өдөр, орой, шөнө)-т хуваагаад тохирох, зургуудыг сонгож, өдрийн хэсгүүдэд байрлуулж наана. Зургаа ашиглан нэг өдөр юу юу хийснийг тайлбарлан ярина. • Цаг хугацаатай холбогдох үлгэр, өгүүллэг сонсож, үйл явдлыг цаг хугацаагаар илэрхийлэн ярилцана. • Хэн хэдэн сард төрсөн бэ? Багштай хамтран төрсөн өдрийн булан бүтээж, хүүхдүүдийн зургийг төрсөн сард нь байрлуулна. • Өнөөдөр ямар гараг болохыг нэрлэнэ. • 12 жилийг дарааллаар нь нэрлэнэ. Өөрийнхөө гэр бүлийн гишүүдийн жилийг хэлнэ.

ХӨГЖИМ, ДҮРСЛЭХ УРЛАГ

Хүснэгт 6. Хөгжим, дүрслэх урлаг

Агуулга			
	I түвшин	II түвшин	III түвшин
	Хөгжмийн аялгууг сонсоод баярлах, толгой, биеэ хөдөлгөх зэргээр сэтгэл хөдлөлөө илэрхийлэх	Өөрийн мэддэг дуу болон хөгжмийн аялгууг сонсоод таних, нэрлэх, тохирох хөдөлгөөн хийх	Хөгжмийн хэмнэл, хурдан удаан, чанга сулыг ялган сонсох, дуу авиа, хөдөлгөөн, үгээр илэрхийлэх (алга таших, толгой дохих)
	Хүүхдийн жишиг үйл		
1. Хөгжмийн аялгууг сонсох, мэдрэмжээ илэрхийлэх	<ul style="list-style-type: none"> Хүүхэлдэйн кино, хүүхдийн нэвтрүүлгийн хөгжмийн аялгууг сонсоод тохирох зургийг заана. Жишээ нь: "Маша ба баавгай", "Тог, тог, тог", "Пороро" "Маамуу нааш ир", "Тоглоом", "Хүүхэлдэй", "Бугын байшин" гэх мэт хөдөлгөөнт дууны хөдөлгөөн хийнэ. <p><u>Тайлбар:</u> "Хэл яриа" сургалтын чиглэлийн "сонсох"-той холбогдох үйлүүдийг сэдэвтэйгээ уялдуулан мөн ашиглаж болно.</p>	<ul style="list-style-type: none"> Хөгжим болон дууны аяыг сонсоод нэрийг хэлнэ. Жишээ нь: "Хоёр нар", "Дэлхийгээ би мэднэ", "Хамгийн сайхан ээжүүд", "Хүүхэд, шувуу хоёр", "Могжоохон даагатай Жогжоохонхүү", "Алтанзул". Төрийн дууллыг сонсоод бусад дуунаас ялгаж нэрлэнэ. Хөгжим сонсоод, аянд тохируулан амьтдын хөдөлгөөн хийнэ. Жишээ нь: "Хулгана" дууны аянд хоёр гараа цээжний өмнө бугуйгаар нугалан барьж хөнгөн гүйнэ, "Амьтдын ертөнц" дууны аянд шувуудын хөдөлгөөн хийнэ. Хөгжим сонсоод, хэмнэлд нь тохируулан "Яргуй дэлгэрлээ", "Шар шувуу чи хаана байна?", "Шувуухай" хөгжимт хөдөлгөөнийг хийнэ. <p><u>Тайлбар:</u> "Хэл яриа" сургалтын чиглэлийн "сонсох"-той холбогдох үйлүүдийг сэдэвтэйгээ уялдуулан мөн ашиглаж болно.</p>	<ul style="list-style-type: none"> Хурдан аяанд гүйж, удаан аянд алхана. Жишээ нь: "Гүйгээрэй", "Би жагсаж чадна" аянд гүйх. Аялгууг сонсоод хурдан ая байвал цэнхэр тууз, удаан ая байвал цагаан туузыг сонгон авч туузтай дасгал хийнэ. Хөгжим сонсоод, аялгууны чанга дуугаралтыг урт туузаар, сул дуугаралтыг богино туузаар ялгаж харуулна. Сонсгол шаардсан тоглоом тоглоно. Жишээ нь: "Хаана юу дуугарав?", "Сонор, соотон чих", "Шувууд юу гэж жиргэв?" Хөгжим ("Морины төвөргөөн", "Амьтдын ертөнц", "Шувуудын жиргээ" гэх мэт)-ийг сонсоод юу төсөөлөгдөж байгааг ярина. Хөгжмийг сонсоод, уйтгартай бол урвайж байгаа зураг, хөгжилтэй байвал инээж байгаа зураг өргөнө. Сонсох эрхтнээ хэрхэн хайрлаж хамгаалах талаар зурагт үзүүлэн дээр ярилцана, дүрэм зохионо.

	I түвшин	II түвшин	III түвшин
	Дууны үгийг аялгуулан хэлэх, дагаж аялах	Дууг дагаж болон бие даан дуулах, бусдыг сонсож дуулах, дууг зэрэг эхэлж, төгсгөх	Дууг өнгө, хэмнэлийг алдалгүй хөгжмийн хамсраатай болон хамсраагүй дуулах
	Хүүхдийн жишиг үйл		
2. Дуулах	<ul style="list-style-type: none"> • Дуулах явцад амьсгалаа яаж авах, гаргахыг багшийг дуурайн хийнэ. • “Маамуу нааш ир”, “Мөндөө би” дууны үгийг багшийг дагаж хэлнэ, аялна, дуулна. • “Хүүхэлдэй”, “Аа гоёо гоё”, “Бугын байшин” зэрэг дууг багш (насанд хүрэгчид)-ийг даган дуулж, хөдөлгөөнийг дуурайна. 	<ul style="list-style-type: none"> • Төгөлдөр хуур хөгжмөөр өгсөн өнгөний дагуу хоолойн дасгал хийнэ. • Дууны утга санааг харуулсан зургийг ярилцана. • Дууг дуулахдаа өөрийгөө болон найз нөхдийгөө сонсож, зэрэг дуулна. • Янз бүрийн хурдтай дууг хөнгөн, намуун, чанга хашхирахгүйгээр, хэмнэлийг дагаж дуулна. • Дууны эхлэл, дахилтыг сонсож ялгаж дуулна. • Дууг дуудахдаа бусдыг сонсож, эхлэл, төгсгөлийг хамтдаа гүйцэд дуулна. 	<ul style="list-style-type: none"> • Амьсгалаа зөв авах тоглоом (“Хул тоолох”, “Лонх тоолох” “Сэнс үлээх” гэх мэт) тоглоно. • Дуулах явцдаа амьсгалаа зөв хуваарилан, хэмнэлийг алдалгүй дуулна. • Дууны аяыг аялгуугаар нь таньж, хөгжмийг дагаж дуулна. • Дууны үгийн утгыг тайлбарлана, үйл хөдлөлөөр илэрхийлэн дуулна. • Дууг дуулахдаа бусдыгаа сонсож дуулна. • Дууг ганцаараа, хосоороо, нийтээр, хөгжмийн хамсраатай дуулна. • Дууг мөр мөрөөр, бадаг, бадгаар (эхний 4 хүүхэд 1 дүгээр бадгийг, дараагийн 4 хүүхэд 2 дугаар бадгийг, бүгд хамтдаа дахилтыг дуулах гэх мэт) дуулна.

	I түвшин	II түвшин	III түвшин
	Дуу, хөгжмийн хэмнэлийг илэрхийлэх (биеэр ганхах, алга таших, толгойгоо дохих)	Дуу, хөгжмийн хэмнэлийг энгийн хөгжмийн зэмсэг (бөмбөр, шигшүүр, дуут мод зэрэг)-ээр дагаж тоглох	Дуу авиа, зан байдал, хөгжмийн хэмнэлийг энгийн хөгжмийн зэмсгээр илэрхийлэн тоглох
Хүүхдийн жишиг үйл			
3. Хөгжимдөх	<ul style="list-style-type: none"> • “А гоёо гоёо”, “Би жагсаж чадна” дууны хэмнэлд тохируулан алгаа ташна, дороо алхана. • Бүүвэйн дуу болон удаан, намуун аяыг сонсоод хоёр тийш найгах, ганхах хөдөлгөөн хийнэ. • “Цас орлоо шар-шар, шар-шар-шар” Гялгар уутыг хооронд нь үрж гарах чимээг сонсоод, удаан үрвэл алхах, хурдан үрвэл гүйх хөдөлгөөн хийнэ. • Дууны хэмнэлд тохируулан багш (насанд хүрэгчид)-ийн хийж буй хөдөлгөөнийг даган дуурайж хийнэ. 	<ul style="list-style-type: none"> • Ойр орчныхоо дуу чимээнээс давтамжийг мэдэрч, дагаж дуурайна. Жишээ нь: Бороо дусаллаа под-под, Бороо ширүүслээ под-под-под-под, салхи салхиллаа шш, шш, шш, Шуурга шуурлаа сшш, сшшш, шшшш. • Багшийг дагаж алга таших, ширээн дээр товших зэргээр мэддэг дууныхаа хэмнэлийг гаргаж тоглоно. • Энгийн хөгжмийн зэмсэг (бөмбөр, хонхот бөмбөр, дуут мод, шагшуур, эгшигт хонх зэрэг)-ийг нэрлэнэ. • Энгийн хөгжмийн зэмсгээр өндөр, нам өнгө; чанга, сул дуугаралт гаргана, хөгжмийн хэмнэлийг мэдэрч, дагаж тоглоно. • Мэддэг дууныхаа хэмнэлийг бусадтай хамтдаа энгийн хөгжмийн зэмсгээр тоглоно. 	<ul style="list-style-type: none"> • Гарын доорх материал ашиглан энгийн хөгжмийн зэмсэг (бөмбөр, шагшуур, хэлхсэн шагай) хийж, дуугаргана. • Дуу болон аялгууны хэмжээ, хэмнэлийг алга ташиж, энгийн хөгжмийн зэмсгээр тоглож харуулна. • Байгалийн дуу чимээ (борооны дусал, тэнгэрийн дуу), орчны дуу чимээ (цагны цохилт, түргэн тусламжийн машины дуу)-г энгийн хөгжмийн зэмсгээр тоглож үзүүлнэ. • Дуу, хөгжмийн хэмнэлийг энгийн хөгжмийн зэмсгээр тоглохдоо түргэн, хөгжилтэй аянд инээмсэглэх, удаан аянд нүүрний хувиралгүй байх зэргээр сэтгэлийн хөдөлгөөнийг харуулна. • Амьтдын хурдан, удаан хөдөлгөөнийг бөмбөр, шагшуураар илэрхийлж тоглоно. Жишээ нь: “Туулай” гэхэд ойр ойрхон олон цохилт, “Баавгай” гэхэд хоорондоо зайтай цөөн цохилт. • Хэмнэлд тохируулан хурдан, удаан хөгжимдөнө. Жишээ нь: “Бөмбөрчин хүүхдүүд” • Багшийн удирдлагаар хэмнэлийг хамтлагаар тоглоно. Жишээ нь: Аялгууны онцлогоос шалтгаалан нэг хэсэг нь цохилуурт хөгжим, бөмбөрөөр, шагшуур, дуут модоор тоглож байхад, нөгөө хэсэг нь үлээдэг даралтат хөгжим, хөгтэй модоор тоглоно.

	I түвшин	II түвшин	III түвшин
	Дуу, хөгжмийн аянд тохируулан гараасаа барьж тойргоор алхах, алга таших, дороо эргэх хөдөлгөөн хийх	Дуу, хөгжмийг ойлгож байгаагаар хөдөлгөөнөөр илэрхийлж бүжиглэх, дүрээр илэрхийлэх, хэмнэлд тохируулан багшийн зааврын дагуу хөдөлгөөнөө гүйцэтгэх, эхлэх, дуусгах	Дуу, хөгжмийн агуулга, дүрийн онцлогийг хөдөлгөөн, нүүрний хувирлаар илэрхийлэн харуулах, аялгууны хэмнэлд тохируулан хөдөлгөөн гүйцэтгэх
Хүүхдийн жишиг үйл			
4. Хөгжмийн аялгуу, хэмнэлд тохируулан бүжиглэх, жүжиглэх	<ul style="list-style-type: none"> • “Жижигхэн болжмор” дууны аянд шувууны дэвэх, будаа тонших, дороо эргэх хөдөлгөөн хийнэ. • Туулай, баавгай (алхаа, үсрэлт)-г дүрслэн хөдөлнө. • Хөгжмийн аянд ганцаараа буюу бусад хүүхэдтэй алхана, тойрог болно, хөлөө товшино, гараа бугуйгаараа хөдөлгөнө, алгаа ташина. • Хөгжмийн аянд Шувуу нислээ, Дэгдээхэй нойрсож байна гэх мэтээр багш (насанд хүрэгчид)-ийг дуурайн хөдөлгөөн хийнэ. 	<ul style="list-style-type: none"> • Хөгжмийн хэмнэлд тохируулан дасгал, хөдөлгөөн хийнэ. Жишээ нь: Янз бүрийн хэмнэлтэй дуунд багш (насанд хүрэгчид)-ийг дагаж, дасгал, хөдөлгөөнийг дуурайж хийнэ. • Хөгжмийн хэмнэлд тохируулан алхах, хөнгөн гүйх, хоёр хөл дээрээ үсрэх, гар, гараасаа барин тойргийг тэлэх, хумих зэргээр тойрон бүжиг хийнэ. • Дүрс бичлэг үзэж, бүжгийн хөдөлгөөнийг дуурайж хийнэ. • Хэмнэлд тохируулан хөдөлгөөн хийнэ. Хөдөлгөөнийг өгсөн дохионы дагуу зэрэг эхэлж, дуусгана. • Өгсөн зааврын дагуу зай талбайг баримжаалан ганцаараа буюу хосоороо эргэх, товших зэрэг хөдөлгөөнийг хөгжмийн аянд тохируулан хийнэ. • Хөгжимт тоглоом, хөгжимт хөдөлгөөн, дуут бүжигт оролцож, амьтдын дүрд хувирч тоглоно. • Дуу, хөгжмийн утга санаа, дүрүүдийн үйл хөдлөлийг илэрхийлсэн хөдөлгөөн хийж, дуут бүжиг бүжиглэнэ. Жишээ нь: “Туулай”, “Алга ташаарай” 	<ul style="list-style-type: none"> • Хөгжмийн аянд хөнгөн алхах, хурдан гүйх, өвдөг өргөж явах, нэг хөл дээрээс нөгөө хөл дээрээ ээлжлэн үсрэх хөдөлгөөн хийнэ. • Тухайн үед ангид явагдаж буй сэдэвт тохируулан сонгосон дууны хэмнэлд хөгжимт дасгал хийнэ. Жишээ нь: “Эрвээхий”, “Наадацгаая”, “Таван төл” • Хөгжим сонсоод төрсөн сэтгэгдлээ янз бүрийн хөдөлгөөнөөр дүрсэлж бүжиглэнэ. Жишээ нь: “Ишиг” Хүүхдүүд хөгжим болон багшийн ишигний тухай ярьсан зүйлээс санаа авч, ишигний дүр төрхийг харуулсан хөдөлгөөн хийж бүжиглэнэ. Хүүхдээс гарсан сонирхолтой хөдөлгөөнийг авч, зохиомжит бүжиг хамтран бүтээж болно. • Дүрийг хөдөлгөөн (айсан, гомдсон, уурласан, ялалт байгуулсан)-өөр жүжиглэн илэрхийлнэ. • Аялгуунд тохируулан дуут бүжиг хийнэ. Жишээ нь: “Цэцэг”, “Дагаад хийгээрэй”, “Найзалцгаая”. • Дууны хэмнэлд тохируулан дүрд хувиран амьтдын хөдөлгөөн хийнэ, дуулна. Жишээ нь: “Цовоо ишиг”, “Мэлхий ба цох”, “Шувуухай” • Дүрд хувиран хөгжимт хөдөлгөөн (“Анд явья”, “Шүрэн цох”, “Ууртай баавгай”, “Туулай ба үнэг”) хийнэ. • “Байраа солиорой”, “Амьтан болж тоглоё”, “Хонхот гутал”, “Мэлхий” хөгжимт хөдөлгөөнд тохирсон утга санааг илэрхийлэн хөдөлгөөн хийнэ. • Дууны утга санаа, үгийг хөдөлгөөнөөр илэрхийлэн дуулна. Жишээ нь: “Алаг эрээн аалз”, “Хөгжилтэй хөгжимчин”, “Алтан тав”, “Зургийн хичээл”

	I түвшин	II түвшин	III түвшин
5. Хүрээлэн буй орчноос ажигласан зүйл, төсөөллөө зурж дүрслэх	Зурах үйлийг сонирхох, орчны юмсыг өөрийнхөөрөө зурж дүрслэх	Зурах багаж хэрэгслээ сонгох, төрөл бүрийн материал (харандаа, будаг, бийр, эсгий бал гэх мэт) ашиглан олон аргаар зурж дүрслэх	Хүрээлэн буй орчны юмс, үзэгдэл, үйл явдал, санаа бодлоо зургаар илэрхийлэх, бусадтай хамтран бүтээл хийх, зурж буй зүйлдээ бүтээлчээр хандах
	Хүүхдийн жишиг үйл		
	<ul style="list-style-type: none"> • Том хэмжээтэй (ханын цаас, дэлгэц цаас, ватум цаас) цаас болон самбар дээр харандаагаар эрээчиж сараачина. • Хуудас цаасан дээр эрээчиж, сараачна. • Бөмбөг, дугуй дүрсийг дүрсэлж зурна. • Гуаш, усан будаг ашиглан хуруу, гарын хэв, дардсаар бэлдсэн дүрс (алчуур, хувцас гэх мэт)-ийг хээлж чимэглэнэ. • Бийрээр дарж цэг, толбо үүсгэнэ. Жишээ нь: “Борооны дусал”, “Будаа”, “Цас” 	<ul style="list-style-type: none"> • Харандаагаар шулуун зураас татаж, орчны эд юмс (нарны цацраг, самны шүд, хогийн шүүр, модны шилмүүс, хашаа гэх мэт)-ыг дүрсэлж зурна. • Гурвалжин, дөрвөлжин дүрсийг торлож, дугуй дүрсийг тойргоор будна. Жишээ нь: Авдар, бөмбөг, лууван • Хэв тавьж тойруулан зураад, өнгөөр ялгаж будна. Жишээ нь: Хонь, ямаа, тэмээ, үхэр, машин, хүүхэлдэй. • Хүнсний ногооны дардсаар эд юмсыг дүрслэн зурна, чимэглэнэ. • Лаа болон тосон харандаагаар зурж, усан будгаар будна. • Ноосон утсыг усан будганд дүрээд, цаасанд хавчуулан татаж дүрс үүсгэнэ. Үүссэн дүрсийг харандаагаар хүрээлнэ, нэр өгнө. • Цаасан дээр усан будаг дусааж гуурсаар тал тал тийш үлээж дүрсэлж зурна. Жишээ нь: Цэцэг, зараа, өвс. 	<ul style="list-style-type: none"> • Нуман, долгиолсон зураас ашиглан үүлэн хээ, усан хээ дүрсэлж зурна. • Аяга, монгол гэр, гутал гэх мэт бэлтгэсэн дүрсийг хээлж цэг, зураас, дүрсээр чимэглэнэ. • Бодит юмс, амьтан (лууван, усан үзэм, төрийн далбаа, туулай, тэмээ гэх мэт)-ыг аргачлалын дагуу зурна. • Үндсэн өнгийг хольж өөр өнгө (улбар шар, ногоон, саарал) үүсгэнэ. • “Хавар”, “Зун”, “Намар”, “Өвөл” сэдэвт зураг зурна. • Үлгэрийн баатруудаас сонгож, усан будгаар зурж дүрслэнэ. • Үлгэр, зохиол (“Цагааханы зүүд”, “Туулайн байшин”, “Алунгуа эхийн сургаал” гэх мэт) сонсоод, үйл явдлыг өөрийн ойлгосноор дүрсэлж зурна. • Усан будаг ашиглан сойзоор шүршиж “Намрын мод”, “Шинэ жилийн чимэглэл”, “Ой мод” зэргийг зурж дүрсэлнэ. • Хэв дардас, хөвөн, шүдэнз ашиглан хамтын бүтээл хийнэ. Жишээ нь: Хонь, адуу, үхэр, тэмээ, ямааг хэв дардсаар, хашаа хороог шүдэнзээр.

	I түвшин	II түвшин	III түвшин
	Баримлын болон байгалийн шавар, зуурмаг, элсээр нэг цул бүтэцтэй зүйлс хийх, хэв ашиглан хэлбэр гаргах	Баримлын шавар, зуурмаг, цас, элсээр хялбар бүтэцтэй (2 ба 3-аас доошгүй хэсгээс бүтсэн) зүйлс дүрслэх	Баримлын шавар, зуурмаг, цас, элсээр эд зүйлс, хүн, амьтан дүрслэх
Хүүхдийн жишиг үйл			
6. Шавраар эд зүйлс, хүн, амьтан дүрсэлж бүтээх	<ul style="list-style-type: none"> • Нойтон элсэн дээр гурвалжин, дөрвөлжин, дугуй, бамбарууш, загас, цэцэг гэх мэт дүрстэй хэвээр дарж хэлбэр дүрс гаргана. Бүтээсэн зүйлээ нэрлэнэ. • Нойтон элсийг бөөрөнхийлж, баримлын шаврыг атгаж зөөллөн “Бөмбөг” хийнэ. • Баримлын шавар, гурилан зуурмагийг хавтгайлж янз бүрийн хэвээр дарж хэлбэр дүрс (гурвалжин, дөрвөлжин, дугуй дүрс, баавгай, загас, туулай гэх мэт) гаргана. • Нойтон элс, зуурмагийг янз бүрийн хэлбэр дүрс (усан үзэм, машин, бөмбөг, бамбарууш, цэцэг, усан онгоц)-тэй хэвэнд хийж хэвлэнэ. 	<ul style="list-style-type: none"> • Баримлын шаврыг гонзгойлж, бөөрөнхийлж жимс, хүнсний ногоо барина. Жишээ нь: Лууван, улаан лооль, лийр • Зурган аргачлал харж, баримлын шавар, давсан зуурмагаар эд зүйлс, амьтан (гэрлэн дохио, дэгдээхий, туулай, бамбарууш гэх мэт) барина. • Баримлын шавраар шинэ жилийн чимэглэл хийж, утсаар зүүлт хийн гацуур модоо чимэглэнэ. • Өвөл цасаар бялуу хийж, будаг эсвэл чулуугаар чимэглэнэ. • Элс, усаар гэр, байшин, хашаа, хороо барьж тоглоно. • Баримлын шавартай зөв (шаврыг амандаа хийхгүй, энд тэнд шавахгүй байх, хормогч ханцуйвч өмсөх, суурь хулдаас ашиглах, ажлын дараа заавал гараа угаах) харьцаж хэрэглэх дүрэм зохиож дүрслэн урлах төвд байрлуулна. 	<ul style="list-style-type: none"> • “Цагаан сар” сэдвийн хүрээнд баримлын шавар, зуурмагаар хөөрөг, хүн, тавгийн идээ, ширээ сандал барьж дүрсэлнэ. • Хатуурч биеждэг баримлын шавраар хялбар эд зүйлс бүтээж, түлхүүрийн оосор, сургалтын тараах материал болгон ашиглана. • Үлгэр, өгүүллэг (“Шаазгай хүү” гэх мэт) сонсоод, өөрийн сонгосон дүрийг барьж дүрсэлнэ. • Гурил зуурч элдэж хавтгайлан банш чимхэнэ. • Элсээр уул, голын эрэг хийж, ус урсгаж тоглоно. • Цасан дээр гишгэж, элсэн дээр хөлийн ул, гарын хуруу, алганы даралт үүсгэн тоглоно. • Хуурай элсэн самбар дээр хуруу болон савхаар зураг зурна. • Цасаар бялуу бүтээж, самрын яс, чулуу шигтгэж чимэглэнэ.

	I түвшин	II түвшин	III түвшин
	Наамал хийх үйлийг ажиглах, бэлэн дүрсээр наамал хийх	Хялбар дүрс хайчлан нааж, эд зүйлс, амьтан, ургамал дүрслэх	Төрөл бүрийн материал (цаас, картон, бөс даавуу, үр жимс)-аар бүтээлчээр дүрслэн наамал хийх
7. Хүрээлэн буй орчноос ажигласан зүйл, төсөөллөө наах	Хүүхдийн жишиг үйл		
	<ul style="list-style-type: none"> • “Намрын мод” бүтээл хийнэ. Түүсэн навчнаас нэгийг сонгон авч, цавуу түрхээд багшийн бэлтгэсэн модны мөчир дээр наана. • “Цас орлоо.” Цасан ширхэгийн бэлдсэн дүрс авч, цавуу түрхэж цаасан дээр наана. • “Машины дугуй” Дугуй дүрс авч, цавуу түрхээд машины дугуйны хэсэгт наана. • Цавуу хэрэглэж дуусаад таглана. 	<ul style="list-style-type: none"> • Нугалаасны дагуу гурвалжин, дөрвөлжин, дүрс хайчилна. Хайчилсан дүрсээ том цаасан дээр наана. • Нарийн туузан цаасыг зураасны дагуу хайчилж, эд юмс (үс, самны шүд, шүдний сойз) дүрслэн наана. • Зураасны дагуу дугуй, зууван дугуй дүрс хайчилж, бүтээл (бөмбөг, бөмбөлөгүүд) хийнэ. • Өнгийн цаасан дээр зурсан жимс, хүнсний ногоог тойруулан хайчилж, жимс, хүнсний ногоогоор нь ангилж наана. • Цасан ширхэг хайчилж, сүлд модоо чимэглэнэ. • Өнгө, хэлбэр, дүрс (1 улаан дугуй дүрс, 2 шар дөрвөлжин гэх мэт)-ээр давтамж үүсгэн наана. • Гурвалжин, дөрвөлжин, дугуй дүрс ашиглан байшин, цэцэг, галт тэрэг, машин гэх мэт зүйлс бүтээж наана. • Хайчилж дуусаад хайчны амыг хамхиж тавина. 	<ul style="list-style-type: none"> • “Хүүхдийг хувцаслая.” Өнгийн цаас эсвэл даавуугаар өмд, цамц, даашинз, малгай хайчлан нааж, эрэгтэй, эмэгтэй хүүхдийг хувцаслана. • Харандаа үзүүрлэхэд гарсан хаягдлаар цэцэг наана. • Зурсан зургаа будаагаар нааж чимэглэнэ. Будаагаа усан будгаар өнгө ялган будна. • Янз бүрийн хэлбэртэй гоймонгоор наамал хийнэ. Жишээ нь: Машины дугуйг дугуй хэлбэртэй гоймонгоор • Цэцгийн үрээр зурсан зургаа чимэглэнэ. • Навчаар амьтан, ургамал (туулай, дэгдээхий, хулгана, ой мод) дүрслэн наана. • Даавуу, ноос, утас гэх мэт янз бүрийн материал ашиглан орчны эд юмс, амьтан, ургамал дүрслэн наана. Жишээ нь: модыг ногоон өнгийн утас, хүүхэлдэйн хувцсыг даавуу, ноосоор. • Цаасаар “зиг заг” нугалаас үүсгэн хүүхэд зурж хайчилна. Хайчилбарыг дэлгэж, “Найзууд” сэдэвт наамал хийнэ.

	I түвшин	II түвшин	III түвшин
	Барьж байгуулах тоглоомоор эд зүйлс бүтээж тоглох	Барьж байгуулах, эвлүүлж угсрах тоглоом, гарын доорх болон байгалийн материалаар бүтээл хийх	Бүтээсэн зүйлсээрээ тоглох, агуулга, дүрслэлийг баяжуулах
8. Барьж байгуулах, зохион бүтээх	Хүүхдийн жишиг үйл		
	<ul style="list-style-type: none"> • Багштай хамтран том өрж байгуулах модыг зэрэгцүүлэн тавьж хашаа, шоонуудыг давхарлан өндөр байшин барина. • Соронзон тоглоомыг хооронд нь нийлүүлж машины зам, хашаа зохион бүтээж тоглоно. • Цаасан аягыг давхарлан өрж цамхаг бүтээнэ. 	<ul style="list-style-type: none"> • Сүүний сав, ундааны бөглөө гэх мэт гарын доорх материал ашиглан тээврийн хэрэгсэл, эд зүйлс (автобус, машин, байшин, робот гэх мэт) зохион бүтээж, тоглоно. Жишээ нь: Уралдааны машин зохион бүтээж, налуу зам дээгүүр явуулж тоглох. • Өрж байгуулах тоглоомоор зам, гүүр, өөрийн цэцэрлэг, малын хашаа хороо барьж бүтээж тоглоно. • Багштай хамтран цаасаар өвлийн өвгөн, гацуур мод, хүүхэлдэй, цасан ширхэг зэрэг шинэ жилийн чимэглэл хийж, ангиа чимэглэнэ. • Бүтээл хийж дуусаад багаж хэрэгслээ цэвэрлээд хурааж байранд нь тавина. 	<ul style="list-style-type: none"> • Зузаан өнгийн цаасыг эвхэж нугалан, хайчилж “Долоодой”-н дүрсүүдийг бүтээнэ. Бүтээсэн дүрсүүдээрээ гурвалжин, дөрвөлжин дүрс, хүн, амьтан, лаа, 1-10 хүртэлх цифр гэх мэт зүйлс бүтээж тоглоно. • Дөрвөлжин алчуураар хүүхэлдэй, усан онгоц, дэгдээхий, алим, шүдний оо, малгай, оцон шувуу гэх мэт зүйлсийг эвхэж, зохион бүтээнэ. • Даавуу, цаасаар цэцэг хийж ээждээ бэлэглэнэ. • Зурагт заасан зураас болон аргачлалын дагуу цаасаар нугалж, хайчилж, нааж машин, байшин, онгоц гэх мэт зүйлс зохион бүтээнэ, түүгээрээ тоглоно. • Өөрийн хийсэн үсний зүүлт, байшин, машин, зэргийг бусдад танилцуулан, юугаар, яаж хийснээ тайлбарлана. • Туузан цаасыг сүлжин нааж сагс хийнэ. • Олс, үдээс зэргийг хоёр, гурваар сүлжин дээс хийж тоглоно. • Хүүхэлдэйн үс сүлжиж, зүүлт зүүнэ.

ХОЁР. СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ЗҮЙ

2.1. БАГШ, ХҮҮХЭД ХАМТДАА МЭДЛЭГ БҮТЭЭХ АРГА

Сургалтын хөтөлбөрт (2019) багш суралцахуйн чиглэлүүдийн зорилго, агуулгыг хэрэгжүүлэхийн тулд ямар хичээл, үйл ажиллагааг зохион байгуулж байна вэ, залуу багш уу туршлагатай багш уу гэдгээс үл хамааран бага насны хүүхдийг хөгжүүлэх ерөнхий багшлахуйн болон хүүхдийн сурч танин мэдэх аргууд, ашиглах сургалтын хэрэгслийг тусгасан юм. Энэхүү зөвлөмжид суралцахуйн **тодорхой чиглэлүүдээр** багш тухайн хичээл, үйл ажиллагааны зорилго, агуулгыг хэрэгжүүлэхийн тулд багшийн хэрэглэдэг аргуудыг танилцуулж байна (Хүснэгт 7). Учир нь зарим багш нарын ээлжит хичээлийн боловсруулалтад шинжилгээ хийхэд аль ч хичээл байсан дасгалын арга, тайлбар ярианы арга, харилцан ярилцах, асуудал дэвшүүлэх арга зэрэг нэгэн хэвшмэл аргуудыг давтаж бичсэн байдаг. Гэтэл математикийн энгийн төсөөллийг хөгжүүлэх хичээлд хүүхдэд юмсын урт-богино, өргөн-нарийн эсэхийг ойлгуулахын тулд зэрэгцүүлж, давхцуулах замаар харьцуулах аргыг хэрэглэдэг, хэл яриаг хөгжүүлэх хичээлд хүүхдэд авиаг сонсох, ялгуулж хэлүүлэх, үлгэрийг жүжигчлэн болон хуруу хүүхэлдэй ашиглан ярьж өгөх арга илүү үр дүнтэй байх жишээтэй.

Орчин үед бага насны хүүхдийн хөгжлийг дэмжихэд уламжлалт багшлахуйн аргуудыг багш, хүүхэд аль аль нь **идэвхтэй** байж, **хамтдаа бүтээж бий болгох** (ко-конструктив суралцахуй) аргатай хослуулан хэрэгжүүлэх улмаар эцэг эхийн дэмжлэг оролцоог хангах нь чухлаар тавигдаж байна.

Конструктив онолоор хүүхэд мэдлэгийг өөрөө идэвхтэй бүтээгч гэж үздэг бол социал конструктив (social constructiv) онолоор нийгэм дэх хүмүүс хоорондын харилцан үйлчлэл (social interaction) нь **мэдлэг бүтээх-утга учрыг олж нээх** түлхүүр [E.Fthenakis, 2015] гэж үздэг. Багш, хүүхэд хамтдаа мэдлэг бүтээх гэдэг нь сургалтын баялаг орчинд хүүхэд ямар нэг зүйлийг сонирхон ажиглах, заах нэрлэх, хэлбэр, хэмжээ, өнгө гэх мэт шинж чанараар нь ангилах, дүрсэлж бүтээхийн зэрэгцээ тухайн юмс, үзэгдлийн учир шалтгаан, зориулалтыг мэдэх, асуулт дэвшүүлэх, түүнд хамтдаа хариулт олоход оршино. Энэ аргыг багш суралцахуйн чиглэлүүдээр болон өдөр тутам явагддаг бүхий л үйл ажиллагааны явцад хэрэглэх боломжтой.

Багш суралцахуйн чиглэлүүдээр ямар аргуудыг хэрэглэх вэ?

Багш та ангийнхаа хүүхдүүдийн хөгжлийн түвшин, суралцахуйн чиглэлүүдийн онцлог, хичээлийн сэдэв, зорилго, агуулга, хэрэглэгдэхүүний хүрэлцээ, бүлгийн хүүхдийн тоог харгалзан сургалтын дараах аргыг хэрэглэнэ. Өөрөөр хэлбэл, та ээлжит хичээлийн боловсруулалтын арга, арга барил хэсэгт доорхи аргуудаас сонгож бичиж болно гэсэн үг.

Суралцахуйн чиглэл	Арга, арга барил
Математик төсөөллийг хөгжүүлэх	<ul style="list-style-type: none"> • Зэрэгцүүлэх, давхцуулах аргаар харьцуулах • Тоолох (цээжээр болон оноож тоолох, шууд, урвуу тоолох, мэдрэхүйн эрхтний тусламжтайгаар тоолох) • Нэмэгдүүлж, хорогдуулах замаар юмсыг тэнцүү, тэнцүү биш болгох • Энгийн бодлого бодох, зохиох • Асуулт тавьж, хариулт авах: тухайлбал, хэд вэ?, хэчнээн? асуулт тавьж тооны дүн хэлэх • Дүрс бүтээх (бага насанд загварын дагуу, арай том насанд өөрсдөө зохиох гэх мэт) • Хэмжих (урт-богино, өргөн- нарийн, өндөр-нам хоёр хэмжээсээр, ахлах насанд урт-өргөн- өндөр гурван хэмжээсээр стандарт бус хэмжүүрийн нэгж ашиглаж хэмжих) • Өөрөөсөө болон хавтгай дээр юмсын байрлал, зүг чигийг тодорхойлох • Нэг юмсын байрлалаас нөгөө юмсын байрлалыг харьцуулж орон зай, зүг чигийг тодорхойлох • Сургах тоглоомыг ашиглах • Дасгалын арга (тоолох, ангилах, төрөлжүүлэх) • Мэдээлэлд дүн шинжилгээ хийх (хуанлид цаг агаарыг тэмдэглэж, нартай өдөр хэд байсан, бороотой өдөр хэд байсан гэх мэт)
Хүүхдийн хэл яриаг хөгжүүлэх	<ul style="list-style-type: none"> • Авиа (дан ба битүү үе, үг, өгүүлбэр)-г хэлүүлэх дасгалын арга • Өгүүлэх эрхтэн хөгжүүлэх дасгал • Сонсгох • Дагуулж хэлүүлэх • Зөв, тод яриагаар үлгэрлэх • Харилцан ярилцах • Ярилцах төлөвлөгөөг зураглаж гаргах • Хуруу болон бээлийн хүүхэлдэй, таягт хүүхэлдэй ашиглан үлгэр ярих • Сүүдэр жүжиг, ширээний театр ашиглан үлгэр, богино өгүүлэл ярьж өгөх • Цуврал болон сэдэвт зургийн дагуу ярилцах • Номын зургийг таниулах, тайлбарлах • Үлгэр, богино өгүүллэгийг уран тод унших • Үг, өгүүлбэр, үлгэрийг тогтоох аргууд (мнемотаблиц, зурагтай карт ашиглах) • Үлгэрийн номтой ажиллах • Үсэг, тоо, дүрс нүдлэх
Хүүхдийн урлагийн мэдрэмж, чадварыг хөгжүүлэх	<ul style="list-style-type: none"> • Хөгжмийн хурд, аялгууны өнгө, хэмнэлийг сонсгох • Биеэр үзүүлэн, таниулах • Дасган хэвшүүлэх • Олон удаа давтах • Цомнолыг сонсгож мэдрүүлэх • Хөгжимт хөдөлгөөнт тоглоомоор тоглуулах • Дүрсэлж зурах зүйлийг ажиглуулах • Зурах, будах, наах, хайчлах аргачлалыг тайлбарлах • Биечлэн үзүүлэх • Өнгө, будгийг найруулах энгийн туршилт • Зурах, будах энгийн арга техник (уусгаж , шүршиж , хавсарч будах) • Баримлаар юмс бүтээх арга барил (бөөрөнхийлөх, базах, гонзгойлох, цувих)

Хүүхдийн идэвхтэй хөдөлгөөнийг дэмжих	<ul style="list-style-type: none"> • Дасгал, гимнастикийн хөдөлгөөнийг дагуулж хийлгэх • Хүүхдийн биеийн галбирыг хөгжүүлэх дасгал • Биечлэн үзүүлэх • Биеийн галбирын буруу хөгжлийг засах дасгал хийх • Олон удаа давтах • Хөдөлгөөнт тоглоом тоглох • Хүчний чадавхыг хөгжүүлэх дасгал, тоглоом • Тэсвэр, хатуужилыг хөгжүүлэх дасгал, тоглоом • Хөдөлгөөний хурдыг хөгжүүлэх дасгал, тоглоом • Гимнастикийн дасгал
Байгаль, нийгмийн орчинтой танилцуулах	<ul style="list-style-type: none"> • Ажиглах • Асуулт дэвшүүлж, харилцан ярилцах • Таамаглал дэвшүүлэх • Энгийн хялбар туршилт зохион байгуулах • Байгалийн булан, туршилтын талбай болон гэрт хөдөлмөр хийлгэх (цэцэг, ургамлыг услах, хамтдаа хөрс шороог солих, загас хооллох гэх мэт)

Тоглоом наадгай, хэрэглэгдэхүүн

Бага насныханд тоглоом наадгайг сонгохдоо хүүхдийн тоглох хэрэгцээ, танин мэдэхүй, хөдөлгөөний зохицуулалт, бүтээлч байдал, анхаарлын төвлөрөл, бусад хүүхэдтэй харилцах харилцаанд хэр зэрэг нөлөөтэй вэ, аль насныханд тохиромжтой, хүүхдийн эрүүл мэндэд хоргүй байж чадах уу гэдэг талаас нь авч үзнэ. Сургуулийн өмнөх насанд хүүхэд тоглох явцдаа суралцаж, хөгждөг тул сургалтын хэрэглэгдэхүүнийг тоглоом наадгайтай хамтатган авч үзлээ.

2 настнууд

2 насныханд хөдөлгөөнөө зохицуулж, өөртөө итгэлтэйгээр биеэ авч явж сурах, томчуудын өдөр тутмын үйлүүдийг даган дуурайх, ойр орчноо мэдэрч хүртэн таньж мэдэх хэрэгцээ бий.

Энэ насанд тохиромжтой тоглоом, хэрэглэгдэхүүн:

- Савлуур, жижиг гулсуур, унаж явдаг тоглоомон машин, татаж, түлхдэг тоглоом, чирч тоглодог тоглоом, бөмбөг, сүвлэх тоглоом, том хэмжээтэй угсрах тоглоом зэрэг хүүхдийн биеийн болон хараа гар хурууны хөдөлгөөний зохицуулалтыг дэмжсэн тоглоомууд
- Баримлын шавар, хуруугаар будах усан будаг, гуаш, бүдүүн тосон харандаа, ус, элс, хэв зэрэг мэдрэмжийг дэмжих болон зурах, урлах хэрэгсэл
- Том хэмжээтэй өрж байгуулах тоглоом, леги, чихмэл амьтад, хүүхэлдэй, картонон хуудастай ном
- Хүмүүсийн үйлийг даган дуурайхад шаардлагатай сэдэвт тоглоомын хэрэгсэл (аяга, таваг, сав суулга, машин гэх мэт)

3 ба 4 настнууд

Биеийн хөдөлгөөний эвсэл, эв дүй, хараа гар хурууны хөдөлгөөний зохицуулалт нь сайжирна. Гадаа талбайд тоглох дуртай байна. Гурван дугуйт унаж чаддаг болно. Эхний өгүүлбэр хэлж эхэлснээс хойш, тэдний асуулт, яриа тасрахгүй. 4 настнууд тоглоом наадгай, эд зүйлсийг янз бүрээр ашиглаж эхэлнэ. Хүйсээ мэдэрнэ, ямар тоглоомыг илүү сонирхож байгаа нь мэдэгдэнэ. Гэхдээ хүүхэд бүрийг хувь хүн талаас нь сайтар ажиглах шаардлагатай. Жишээлбэл, охид хүүхэлдэйгээр, хөвгүүд машин, хөл бөмбөг тоглох дуртай гэвэл өрөөсгөл болно. Хөвгүүдийн тоглоомоор тоглох сонирхолтой охид ч байдаг. Үүнтэй адил хөвгүүдийн сонирхол, сонголт мөн харилцан адилгүй. Тэд бусадтай хамтран тоглох сонирхолтой болно.

Энэ насныханд тохиромжтой тоглоом, хэрэглэгдэхүүн:

- Савлуур, гулсуур, дүүжин даажин, савладаг морь, тоглоомон машин
- Төсөөлөл сайжруулахад туслах зориулалттай тоглоомууд
- Зурах, урлах хэрэгсэл (будаг, бийр, тосон болон өнгийн харандаа, цавуу, шавар, ус, элс)
- Богино үлгэрийн ном
- Танин мэдэхүйн ном
- Айл гэр, Дэлгүүр зэрэг сэдэвт тоглоом
- Хэсгүүдийг эвлүүлэх, нийлүүлэх, тагийг хаах, нээх тоглоом
- Хэлхэх шүр
- Соронз, томруулдаг шил
- Өрж байгуулах, угсрах тоглоом
- Шагай
- Таван хошуу мал, ан амьтдын дүрст тоглоом

5 настнууд

Тэдний асуулт тасрахгүй, юмс, үзэгдлийн холбоо хамаарал, учир шалтгааныг олохыг эрмэлзэнэ. Зураг нь өргөн агуулгатай болох тул янз бүрийн өнгө ашиглах хэрэгцээ бий болно. Зохиож бүтээх сонирхолтой байна. Сургах, хөдөлгөөнт, хөлөгт, аман наадам зэрэг янз бүрийн тоглоомыг сонирхон, нэлээд нарийн дүрэмтэй нийтээр тоглох тоглоомд оролцоно.

Энэ насанд тохиромжтой тоглоом, хэрэгдэгдэхүүн:

- Юмс, үзэгдлийн учрыг олохтой холбоотой танин мэдэхүйн ном
- “Долоодой” мэтийн хүндэвтэр эвлүүлэх дүрсүүд, гар урлалын материалууд
- Шагайн наадмууд
- Хөлөгт тоглоом
- Техникийн тоглоом
- Бичих, унших бэлтгэлтэй холбогдох тэмдэг тэмдэглэгээ, зурлага, цифр
- Богино үлгэр, өгүүллэгийн ном
- Өөрсдийн урлаж бүтээсэн тоглоомууд
- Охидын сонирхдог тоглоомууд (хүүхэлдэйн булан, хэлхэх шүр, шигтгэх, сүлжих тоглоом)
- Хөвгүүдийн сонирхдог тоглоомууд (конструктор, машин уралдуулах зам, хөл бөмбөг, техникийн ном)

Санамж:

Өдөр тутмын амьдралд хэрэглэдэг эд зүйлс, хэрэгсэл болон байгалийн материалууд хүүхдэд чөлөөтэй, бүтээлчээр тоглох боломж олгодог. Аль ч насны хүүхэд элс, усаар тоглох дуртай. Мөн навч, чулуу, цэцэг, үр жимс, дэрс, модны мөчир зэрэг байгалийн материалаар хүүхэд харьцуулж, ангилахаас гадна урлан бүтээдэг. Байгалийн материал нь олдоцтой, үнэгүй, эко байдгаараа ач холбогдолтой. Алчуур, даавуу, сав суулгыг хүүхэд “Дэлгүүр”, “Айл гэр” гэх мэт сэдэвт тоглоомд ашиглаж болно. Эдгээр материалууд нь хүүхдийн төсөөлөн бодох чадвар, бүтээлч байдлыг хөгжүүлэхэд нэн тустай. Хүүхэд өөрсдийн урлаж бүтээсэн тоглоом наадгай (машин, хүүхэлдэй, цүнх гэх мэт)-гаар тоглох дуртай байдаг.

Багшлах арга зүй (хэрэглэгдэхүүн)-н жишээ

Математик төсөөллийг хөгжүүлэх хичээл, хөгжүүлэх үйл ажиллагаагаар багшийн зүгээс хүүхдийн хэмжигдэхүүний төсөөллийг хөгжүүлэхэд юмсыг давхцуулж, зэрэгцүүлж харьцуулах аргыг хүүхдийн насны онцлогоос хамаарч, ямар хэрэглэгдэхүүн ашиглан хэрхэн хэрэглэх [Алтансүвд, Л, 2012 он]-ийг жишээ болгон авч үзье. Багш та санаа авч, баяжуулан хэрэглэнэ үү.

2 нас. Энэ насны хүүхдийн мэдрэхүйн туршлагад тулгуурлан хэмжигдэхүүний төсөөллийг хөгжүүлнэ. 3 хүртэлх насандаа хүүхэд хэмжээгээрээ эрс тэс ялгаатай хоёр зүйлийг л (урт богино, өндөр нам, өргөн нарийн гэх мэт) харьцуулна.

Жишээ 1. 10 цагариг бүхий суварган тоглоомоор тоглоно. Юуны түрүүнд багш хүүхдүүдийн анхаарлыг түүний хэмжээнд хандуулна. Цагиргийг дээр дээрээс нь давхарлах явцад энэ насны хүүхэд хэмжээ нь өөр өөр байгааг анзаарч харна. Багш эхлээд хамгийн том, дараа нь хамгийн жижгийг нь хийлгэнэ. Үлдсэн цагиргаас хамгийн томыг нь сонгосноор хамгийн сүүлд жижиг нь үлдэнэ. Энэ аргаар хүүхэд том, жижиг гэсэн ойлголттой танилцана. Эргээд цагиргийг жижгээс нь эхлээд томыг дуустал нь авч тавина. Ийнхүү давхцуулах, зэрэгцүүлэх аргыг хэрэглэх явцад хүүхэд хамгийн том, хамгийн жижиг гэсэн ойлголттой болно. Энэхүү ойлголтыг бататгахын тулд хүүхэд нэг бүрээр ээлжилж хийлгэж дасгалжуулна. Энэ насны хүүхдэд багш эхлээд өөрөө үзүүлж тайлбарлана. Дараа нь хүүхдээр хийлгэнэ.

Жишээ 2. Энэ насны хүүхдэд урт, богино юмсыг харьцуулахын тулд хэмжээгээрээ хоёр өөр өнгөтэй зүйлийг авна. Жишээ нь: улаан тууз нь шар туузнаас урт гэдгийг ойлгуулахын тулд улаан туузан дээр шар туузыг давхцуулж тавина. Багш эхлээд энэ аргыг үзүүлээд аль тууз нь илүү гарч байна, тэр нь урт гэдгийг ойлгуулна. Дараа нь хүүхэд нэг бүрт өнгөөрөө эрс тэс ялгаатай урт богино туузнуудыг өгч, дасгалыг давтаж хүүхдийн ойлголтыг бататгана. Дараа нь зэрэгцүүлэх аргыг хэрэглэхдээ уртаараа өөр өөр мөртлөө ижил өнгөтэй ижил туузнууд өгнө.

Жишээ 3. Өндөр, нам гэсэн ойлголтыг өгөхийн тулд хэмжээгээрээ ялгаатай хоёр өөр хайрцгийг зэрэгцүүлэх аргаар ялгуулна. Хүүхэд урт, богино, өргөн, нарийн, өндөр, нам гэх мэт үгсийг хэрэглэж сурна.

3 нас. Тэд юмсын хэмжээг давхцуулан зэрэгцүүлэх аргаар харьцуулж сурдаг.

Жишээ 1. Хүүхэд нэг бүрт тарааж өгөх материалыг урьдчилан бэлтгэж хэрэглэнэ. Тухайлбал, том, жижиг дүрсүүд байж болно. Тэдэнд тарааж өгөх материалын хэмжээ нь хоорондоо 10-15 см-ын ялгаатай байна. Эхний үед хүүхэд харааны тусламжтайгаар юмсын хэмжээг бүхэлд нь хүртэнэ. Дараа нь хүүхдээр юмсын хэмжээг харьцуулах дасгал хийлгэхдээ нэг төрлийн юмсыг сонгоно. Том жижиг бөмбөг, том жижиг хүүхэлдэй, урт богино харандаа гэх мэт. Гэхдээ хэмжээгээр нь харьцуулах юмс нь хэмжээ ба өнгөөрөө ялгаатай байх шаардлагатай. Хүүхдэд өгөх дасгал даалгаврыг аажмаар хүндрүүлнэ. Хүндрүүлнэ гэдэг нь юмсын хэмжээний **хоорондох ялгааг багасгана** гэсэн үг. Үүнд л энэхүү аргачлал нь өмнөх 2 настай хүүхдэд заах арга зүйгээс ялгарна. Ер нь багш юмсын хэмжээ, хэлбэрийг хүүхэд нэлээд багаасаа сонирхож эхэлдэг онцлогтой гэдгийг мэдэх учиртай. Хүүхэд эд юмстай үйлдэл хийх замаар буюу юмсыг барьж, атгаж, тэмтрэх, шидэх үедээ тэдгээрийн хэлбэр, хэмжээг танин мэдэж, тэр хэрээр мэдрэхүйн хөгжил аажмаар сайжирдаг.

Жишээ 2. 10 цагариг бүхий суварган тоглоом авна. Багш хүүхдийн анхаарлыг эхлээд цагаригийн шинж чанарт хандуулна. Цагаригийг илээд үзэхэд гөлгөр, тэгшхэн, ижил өнгөтэй гэх мэтээр хүүхэдтэй ярилцана. Хүүхэд өөрөө барьж тэмтэрч үзэж болно. Багш хэмжээний талаар хүүхдүүдээс асууна:

- Цагаригууд бүгд ижил хэмжээтэй байна уу? Та нар юу гэж бодож байна вэ? гэж хүүхдээс асууна.

Хүүхдүүд цагаригийг авч нэг нэгээр нь харьцуулж үзнэ. Дараа нь бүгд өөр өөр хэмжээтэй болохыг мэднэ. Багш ээлж ээлжээр суваргад хамгийн том, арай жижиг, дунд зэрэг, бүр жижигхэн цагаригуудыг хийх даалгавар өгнө. Ийм байдлаар хүүхдүүд том, жижиг, арай том, хамгийн жижиг гэсэн ойлголттой болж түүнийгээ үгээр илэрхийлж сурна. Түүнчлэн хүүхдүүд цагаригийг гараараа барьж үзээд бүгд дугуй байна гэсэн дүгнэлтэд хүрнэ. Дараа нь багш дөрвөлжин хүрэнүүдийг сонгож аваад жижгээс нь том руу хийх даалгавар өгнө. Өмнөх цагаригаас ямар ялгаатай байгааг асууна. Хүүхдүүд эхний цагаригууд гөлгөр, тэгшхэн, өнцөггүй

байсан бол хоёр дахь нь өнцөгтэй, тэгшхэн биш байна гэх мэт хүүхдүүд харьцуулж ярина. Давхцуулж буюу зэрэгцүүлж үзээд дөрвөлжин хүрээнүүд нь бас өөр өөр хэмжээтэй болохыг мэдэрнэ. Хүүхдүүд ээлж ээлжээр эхлээд хамгийн жижиг, дараа нь арай том, дунд зэрэг, бүр том, хамгийн том цагиргийг сонгон хийж суварга босгоно.

4 нас. Өмнөх насанд ялгаатай хэмжээтэй хос зүйлсийг харьцуулдаг байсан бол одоо гурав, дөрөв, цаашилбал, таван юмсыг хэмжээгээр нь харьцуулж, өгсөх, буурах дарааллаар байрлуулна. Энэ насны хүүхдүүд жижгээс нь том руу, эсвэл томоос нь жижиг рүү байрлуулна. Юмсыг өгсөх, буурах дарааллаар байрлуулахдаа хэмжээнд нь анхаарлаа хандуулахыг багш хүүхдэд сануулна.

Нэг эгнээнд юмсыг байрлуулахдаа хос хосоор нь харьцуулна. Эхлээд зүүн талд байгааг дараа нь баруун талд байгаа юмсыг харьцуулах жишээтэй. Дараа нь зүүн талд байгаа шоо нь баруун талд байгаа шооноос том, эсвэл жижиг гэх мэтээр харьцуулна. Ийм дасгал нь хүүхдэд юмсын хэмжээ нь харьцангуй байдаг гэсэн ойлголтыг өгнө.

Жишээ 1. Багш нэг хичээл дээр 3 юмсыг уртаар нь харьцуулж, түүнийгээ үгээр илэрхийлэх дасгал хийлгэж болно. Тэрээр самбар дээр 10 см-ээр ялгаа бүхий урт, богино туузуудыг байрлуулна. Тэгээд дараах асуултуудыг тавина.

- Хэдэн тууз байна вэ?
- Ямар өнгийн туузууд байна вэ?
- Аль нь урт (богино) байна вэ?

Багш дараа нь гурав дахь туузыг дунд нь байрлуулаад асууна. Гэхдээ уртаас нь эхлээд байрлуулсан бол хүүхэд хамгийн урт, арай богино, хамгийн богино гэх мэт үгсийг хэрэглэж сурна. Дараа нь багш туузуудыг зүүн талаас нь хамгийн богиноос нь эхлэн дэс дараагаар нь байрлуулна. Байрлуулсан туузууд нь яг шат шиг харагдана. Ингэхэд хүүхдэд аль тууз нь хамгийн урт, аль нь хамгийн богино байгаа нь тодорхой харагдана. Туузны хэмжээг хос хосоор нь харьцуулна. (Улаан ба шар туузны аль нь урт вэ? Аль нь богино вэ?) гэх мэт.

Дараа нь багш хүүхдэд хэмжээгээрээ өөр өөр юмсыг тавьж, хос хосоор нь харьцуулах даалгавар өгнө. Олонлогийн элемент бүрийг өмнөх зүйлтэй нь харьцуулна гэдгийг сануулна.

5 нас. Энэ насны хүүхдүүд юмсыг хоёр эсрэг хэмжээгээр нь давхцуулах, зэрэгцүүлэх аргаар хэмжихээс гадна юмсын урт, өндөр, өргөнийг ямар нэг стандарт бус хэмжүүрийн нэгжээр хэмжиж тооцоолно. Мөн шингэн ба бутармал юмсыг ч хэмжинэ. Нарийн гэсэн ойлголт нь саваа мод, модны мөчир, харандаа гэх мэтийг харьцуулахад хэрэглэхээс гадна эзлэхүүнтэй юмсыг ч бас илэрхийлж болох юм. Энэ үед хүүхдийн харааны мэдрэхүй чухал үүрэгтэй.

Жишээ 1. Хүүхдэд баримлын шавар өгөөд хоёр тэнцүү хэсэгт хуваахдаа бүдүүн, нарийн болгох, эсвэл ижил урттай болгох гэх мэт олон хувилбартай даалгаврыг өгч болно. Даалгаврыг гүйцэтгэх үед хүүхдүүд өөрсдөө харьцуулан жишнэ. Харьцуулж буй зүйлээ багшдаа болон бусад хүүхдэд хэлж болно.

Жишээ 2. Дэлгүүрийн үйл ажиллагаатай танилцах ажил зохион байгуулж болно. Эсвэл энэ сэдвээр урьдаас бэлтгэсэн видео бичлэг үзүүлж болно. Дэлгүүрт хүмүүс юм худалдан авахын тулд өмсөж хэмжиж үздэг, сүү авахдаа литрээр, даавуу авахдаа метрээр хэмждэгийг хүүхдүүд харна. Дараагийн үйл ажиллагаагаар юу хийхээ багш, хүүхдүүд хамтран ярилцаж шийдэж болно.

Жишээ 3. Хэмжүүрийн нэгж болсон тууз, шугам, савх мод, аяга, халбага зэргийг хэрэглэж болно. Багш эхлээд дээрх хэмжүүрийн нэгжүүдээр юмсыг яаж хэмжихийг харуулж үзүүлнэ, тайлбарлана. Ширээний урт, өргөн, өндрийг харандаагаар хэмжихдээ ширээний эхлэл, харандааны эхлэл хоёр давхцана гэдгийг хүүхдүүдэд тайлбарлаж өгнө. Дараа нь харандааны төгсгөлөөс эхлэн хэмжинэ гэдэг аргыг зааж өгнө.

Жишээ 4. Энэ насны хүүхдэд шингэн зүйлийн хэмжээг тооцоолохдоо тухайлбал, шилэн аягаар усыг хэмжихэд дундуур, дүүрэн хийж болохгүй, усны төвшин яг ижил хэмжээнд байна. Хэрэв ижил хэмжээнд баримжаалж чадахгүй бол шилэн аяганы гадна талд тэмдэг тавьж болох юм гэдгийг хэлж өгнө. Ийм учраас хэмжих гэж буй усыг хийсэн сав болон хэмжих сав нь тунгалаг гадна талаасаа харагддаг байвал тохиромжтой. Хүүхэд хэмжээд дараа нь тооцоолж, тоогоор илэрхийлнэ.

2.2. БАГШ, ЭЦЭГ ЭХЧҮҮДИЙН ХАМТЫН АЖИЛЛАГАА

Энд эцэг эх (асран хамгаалагч) яагаад багштай хамтран ажиллах шаардлагатай, цэцэрлэг, багш нарын зүгээс эцэг эхтэй ямар ажлууд зохион байгуулж болох болон цэцэрлэгүүдэд хэрэгжиж буй зарим туршлагыг харууллаа.

Яагаад эцэг эх багштай хамтран ажиллах шаардлагатай вэ?

Цэцэрлэг бол хүүхдэд сургуулийн өмнөх боловсрол олгодог байгууллага, эцэг эх цэцэрлэгийн үйлчилгээ хүртэгчид гэсэн уламжлалт ойлголтоос хөндийрч, **“эцэг эх, багш хамтран ажиллагч”** гэсэн үзэл санааг эцэг эх, багшийн аль аль нь ойлгон хэрэгжүүлэх шаардлагатай байна. Учир нь бага насны хүүхэд гэртээ эсвэл цэцэрлэгтээ, хаана ч байсан ялгаагүй тэндээ тасралтгүй, эмх цэгцгүй, идэвхтэй суралцаж байдаг онцлогтой. Гэр бүл бол тэдэнд тасралтгүйгээр, хүчтэй нөлөөлж байдаг сургалтын орчин. СӨБ-ын сургалтын талаар баримтлах бодлого (2013 он)-ын зарчимд “Эцэг эх, багш хамтран ажиллах түншүүд” гэж үзсэн бөгөөд энэ нь тухайн хүүхдийн хөгжил, төлөвшилд эцэг эх, багш адил тэгш үүрэг, хариуцлага хүлээж мөн адилхан оролцоотой, оролцогч талууд бие биеийн давуу талыг батжуулж, сул талыг нөхөж хамтран ажиллана гэсэн үг юм.

Бага насны хүүхдэд зан чанарын үнэт зүйлсийн үндэс бүрэлдэн тогтох болон гар, шүдээ угаах, ариун цэврийн цаас хэрэглэж сурах зэрэг эрүүл ахуйн дадлаас эхлэн мэндлэх, талархал илэрхийлэх, уучлалт хүсэх, бусадтай зохицон тоглох, эергээр харилцах, түүнчлэн хог, цаасаа ил хаяхгүй байх, амьтан, ургамлыг хайрлаж хамгаалах зэрэг чадвар, эв дүй, дадлуудыг эзэмшүүлэхэд багш хэчнээн их зүтгэл чармайлт гарган ажилласан ч, эцэг эх түүнийг нь анзаарахгүй, ойлгохгүй, ижил шаардлага тавихгүй бол сайн үр дүнд хүрэхгүй. Бага насны хүүхдийн хөгжилд эцэг эхийн үүрэг оролцоо дийлэнх хувийг эзэлдэг бөгөөд үүнд ээж илүү чухал үүрэгтэй байдаг. Тухайн хүүхдийг сайн хүн болгох суурийг тавих, боломжоор нь хөгжүүлэх гэсэн эцэг эх ба багшийн зорилго бол адилхан. Иймд хүүхдийн сайн сайхан, бүх талын хөгжлийн төлөө эцэг эх багштай зайлшгүй хамтран ажиллах шаардлагатай.

Цэцэрлэгээс ямар төрлийн ажлуудыг зохион байгуулж болох вэ?

Юуны өмнө мэргэжлийн байгууллагын хувьд цэцэрлэгээс эцэг эхийн боловсролын түвшин, үнэт зүйлс, хүсэл сонирхол, эрэлт хэрэгцээнд нь нийцүүлэн сургуулийн өмнөх боловсролын онцлог болон хүүхдээ ойлгох, хүүхэдтэйгээ зохистой, эерэг харилцах, хүүхдээ зөв хөгжүүлж, төлөвшүүлэхэд арга барилд нь туслах, ойлголт, хандлагыг нь өөрчлөх мэдлэг, мэдээлэл түгээж байх хэрэгтэй. Цэцэрлэгийн үйл ажиллагааг эцэг эхэд ойлгуулан таниулах, багш эцэг эхэд хүүхдийнх нь хөгжлийн талаар бодитой мэдээлэл өгөх нь хамтын ажиллагааг идэвхжүүлэх, дэмжлэг тусалцаа авах боломж бий болгодог.

Эцэг эхийн дунд олон төрлийн ажил зохион байгуулж болно. Энд ерөнхий байдлаар 4 төрлийн ажлыг авч үзлээ.

А. Үгэн бус нөлөөлөл

- Өрөөний зохион байгуулалт, уур амьсгал
- Хүүхдийн гүйцэтгэж буй үйлүүдийн ажиглалт
- Багштай эерэг, хүндэтгэсэн харилцаа
- Хүлээн авалт, таралтын үе дэх эцэг эхийн ажиглалт

Б. Бичгэн мэдээлэл

- Цэцэрлэгийн үүдэн дэх мэдээллийн самбар
- Сургалт үйл ажиллагааны зорилгын танилцуулга
- Ангиудын үүдэн дэх эцэг эхэд зориулсан самбар, танилцуулга (сургалт бусад үйл ажиллагааны хуваарь, сэдвийн хүрээнд явагдсан үйл ажиллагааны гэрэл зургууд гэх мэт)
- Эцэг эхэд зориулсан захидал, санамж, урилга
- Эцэг эхийн сонин
- “Facebook” групп

В. Ганцаарчилсан үйл ажиллагаа

- Ганцаарчилсан ярилцлага
- Утсаар хийх ярилцлага
- Ангид явагдаж буй үйл ажиллагаатай танилцуулалт
- Хүүхдийн хувийн хавтсын мэдээллийн бүрдүүлэлт

Г. Нийтийн үйл ажиллагаа

- Эцэг эхийн сургалт, цуглаан
- Судалгаа
- Нээлттэй хаалганы өдөр
- Ээж, аавтайгаа (Ээжийн өдөр, Аавуудын өдөр, Хамтдаа урлая гэх мэт)
- Аялал
- Спортын тэмцээн
- Эцэг эхийн зөвлөлийн ажил
- Хамтарч зохион байгуулах баяр ёслол

Эцэг эхийн оролцоог хэрхэн нэмэгдүүлэх вэ?

Эцэг эхийн оролцоог зөвхөн сургалтын орчин бүрдүүлэхээр хязгаарлахгүй, хүүхдийн хөгжил төлөвшилд хамтдаа нөлөөлөх талаас нь харж, ажлаа зохион байгуулдаг цэцэрлэгүүд нэмэгдсээр байна. Түүнчлэн сургалтын орчинг бүрдүүлэхдээ эцэг эхэд хүүхэдтэй хамтран оролцох боломж олгодог практик ч бий. Жишээ нь: Хүүхэдтэйгээ хамтран том ном хийх нь эцэг эхэд хүүхэдтэйгээ санаа бодлоо солилцон ойр дотно харилцах, хүүхдийнхээ хөгжлийн давуу ба сул талыг ойлгох, хэрхэн дэмжиж туслахаа мэдэх боломж олгохоос гадна хүүхдэд нэн тааламжтай үйл байдаг.

Хүүхдийн ар гэрийнхэнтэй харилцаа тогтоож, эерэг уур амьсгал, харилцан итгэлцлийг бий болгох нь эцэг эхийн оролцоог нэмэгдүүлэх таатай суурийг бүрдүүлнэ. Эцэг эхтэй харилцаагаа дараах байдлаар сайжруулж, оролцоог нь нэмэгдүүлж болно.

- **Ярилцах цаг зав гаргах.** Хүүхдээ цэцэрлэгт нь хүргэж өгөх, авах богинохон хугацаанд эцэг эхтэй ярилцах нь харилцааг эерэг болгох алхам байж болно. Жишээлбэл, хүүхдийг нь тоглуулах эсвэл аль нэг үйл гүйцэтгэх зуур эцэг эхтэй нь ярилцаж болно.
- **Сайн мэдээлэгч байх.** Эцэг эхчүүд хүүхдээ бүхэл өдрийн турш юу хийснийг мэдэх сонирхолтой байдаг. Тодорхой мэдээлэл өгөхийн тулд ажигласан зүйлээ тэмдэглэж болно. Бусадтай хэрхэн тоглосон, хийсэн зүйлээ хараад хөөрч догдолсон гэх мэт. Гэвч хүүхдийн алдаа, харилцааны сөрөг илрэл дээр анхаарлаа хэт хандуулж болохгүй.
- **Хүлээж авах чадвартай байх.** Харилцаа бол мэдээллийг өгөх, хүлээн авах гэсэн хоёр талт үйл явц юм. Эцэг эхчүүдэд харилцан ярилцахад таатай нөхцөлийг бүрдүүлж, идэвхтэй сонсогч байхад анхаарна.
- **Мэдрэмжтэй байх.** Эцэг эхчүүдийн үгээр хэлж илэрхийлээгүй санааг ойлгохыг хичээх хэрэгтэй. Хэрэв эцэг эх ямар нэгэн байдлаар мэдрэмжээ илэрхийлбэл түүнийг нь өлгөн авч “Та их санаа зовсон шинжтэй байна.” гэх мэтээр яриаг нь цааш лавшруулан түүнийг тайтгаруулж болох юм.

- Асуудлыг хамтдаа шийдвэрлэх. Та хүүхдийн хөгжлийн талаар мэдлэгтэй ч эцэг эх хүүхдээ танаас дутуугүй мэддэг. Асуудал үүсэх үед нь өөрөө шийдвэр гаргаад, эцэг эхэд нь танилцуулахаас урьдаар тэдэнтэй харилцан ярилцаж, асуудлыг хамтдаа шийдэх нь чухал юм.

Эцэг эхтэй хамтран хийх ямар бүтээлч ажил байна вэ?

Хамтын төлөвлөгөө-хамтын ажиллагаа (Чингэлтэй дүүргийн 37-р цэцэрлэгийн багш Г.Янжмаагийн туршлагаас): Цэцэрлэгийн багш ангийнхаа эцэг эхтэй ажиллах ажлаа төлөвлөлтөөс эхэлдэг. Хичээлийн жилийн эхэнд эцэг эхтэй хамтран төлөвлөгөөгөө боловсруулж, харилцан ярилцаж, нэмэлт, хасалт хийж, хүн нэг бүрийн оролцоог дэмжин баталгаажуулдаг.

Ангийн эцэг эхчүүд багт хуваагдан ажилладаг, баг бүр ахлагчтай. Баг бүр жилд хийгдэх ажлаас нэг нэг ажил сонгож авдаг бөгөөд сард нэг л ажил зохион байгуулагдана. Багуудын ажил хүүхэд бүрийн хувийн онцлог, суралцах чадварыг харгалзан, хөгжил төлөвшилд нь ямар нэг байдлаар хувь нэмэр оруулах зорилгоор хийгддэг. Эцэг эхийн багууд юу хийснээ, хэрхэн хамтарч ажилласан болон амжилтаа танилцуулна. Мөн анхаарах зүйл юу байсан тухай хэлэлцэж, дараагийн жилийн төлөвлөлтийг ярилцдаг. Эцэг эхийн оролцоог нэмэгдүүлэхэд чиглэсэн зарим ажлаа танилцуулъя.

Миний цуглуулга

Хүүхэд бүр өөр өөр цуглуулгатай байна. Цуглуулгаараа аль нэг хүүхэд ээж юм уу аавтайгаа өглөөний тойргийн цагаар үзэсгэлэн гаргаж, найзууддаа танилцуулна. Хэрхэн хадгалсан, хэн хэзээ авч өгсөн, хамгийн анхны, хэдэн үе дамжсан, зориулалт, төрөл гэх мэтээр танилцуулж бусадтай ярилцана. Энэ нь тухайн гэр бүлийн хандлага, зан харилцааг илэрхийлсэн маш сонирхолтой ажил байдаг. Хүүхэд цуглуулгаа их дуртай, баяр хөөртэйгээр танилцуулж, хэрхэн яаж ашиглах талаар найзууддаа зааж өгнө. Мөн эцэг эхчүүд цаг зав гарган хүүхдэдээ өмсөх хувцсыг нь хүртэл бэлтгэж ирээд, найзуудад нь тэр цуглуулгыг ажиглах, үзэж сонирхох, тоглох боломж олгоно. Энэ өдөр тухайн хүүхдийн нэрэмжит өдөр болно. Энэ үйл ажиллагааг бүлгийн “Facebook” группт нээлттэй тавьж, талархал илэрхийлэн урамшуулж, бусад хүмүүсийг уриална. Мөн цуглуулгынхаа зургийг тайлбартайгаар тухайн хүүхдийн “Хувийн хавтас”-д хийж, баяжуулна.

Тоглоомын өдөр

Хүүхэд улиралд нэг удаа том овортой, сонин содон тоглоомоосоо нэгийг авч ирээд, бүх тоглоомыг зааланд төрөлжүүлж тавина. (хөгжим, машин, гал тогоо, динозавр гэх мэт) Цэцэрлэгийн бусад бүлгийн хүүхдүүд тэнд цаг цагаар орж чөлөөтэй тоглоно. Энэ нь манай ангийн төдийгүй бусад ангийн хүүхдүүдийн маш чухал, хүсэн хүлээсэн сайхан цаг байдаг. Цаг дуусахад хүүхдүүд бүгдийг цэгцлээд, дараагийн ангийн хүүхэд тоглоход бэлэн болгоно. Орой эцэг эхчүүддээ тоглоомыг нь хүлээлгэн өгнө. Хүүхдүүд тоглоомын өдрийг тэсэн ядан хүлээнэ. Үүнд эцэг эхчүүд маш дуртай оролцдог.

Ээжүүдийн өдөр

Ээжтэйгээ хамт бүжиглэх, хөдөлгөөнт тоглоом тоглох, тэврүүлэх, хайраа илэрхийлэх, өөрийн гараар хийсэн зүйлээр бэлэг барих зэргээр маш сайхан цагийг хамтдаа өнгөрүүлнэ. Үүнийг хүүхдүүд, ээжүүд тэсэн ядан хүлээдэг бөгөөд хувцас, зүүлт, ямар нэгэн зүйлээрээ хүүхэдтэйгээ хослож, бусад найз нарынхаа өмнө хөгжмийн аянд алхаж, дурсгалын зургаа татуулдаг бөгөөд бүхий л үйл ажиллагааны зургаа нэгтгэн, “Хувийн хавтас”- даа хийнэ. Жил бүр хэлбэрийг нь өөрчилж явуулна. “Аавуудын өдөр” мөн адил жил бүрийн 3 дугаар сард болдог.

Музей үзэх өдөр

Гэр бүлийнхэнтэйгээ ямар нэгэн музей үзэж ирээд, найзуудтайгаа сэтгэгдлээ хуваалцаж ярилцдаг өдөр. Энэ нь хүүхэд, эцэг эхийн маш дуртай ажлын нэг байдаг.

Дөрвөн жилийн турш эцэг эх багаар хамтарч ажилласнаар бие биетэйгээ илүү танил болж, хүүхдүүд цэцэрлэгээ дүүргээд сургуульд орсоны дараа ч гэсэн тэд хоорондоо холбоотой хамтран ажиллаж, бие биедээ тусалсаар байдаг.

2.3 ТУСГАЙ ХЭРЭГЦЭЭТ БОЛОВСРОЛ ШААРДЛАГАТАЙ ХҮҮХЭДТЭЙ АЖИЛЛАХ АРГА

2015 оны 5 дугаар сард БНСУ-ын Инчион хотноо болсон боловсролын асуудлаар дэлхий дахины форумас 2030 он хүртэл боловсролын талаар баримтлах шинэ үзэл баримтлалыг хэлэлцэн баталсан тунхаглалдаа “Тэгш хамарсан, тэгш боломжийг баталгаажуулсан чанартай боловсрол, бүх нийтийн насан туршийн суралцахуйг дэмжих” эрхэм зорилгыг дэвшүүлсэн билээ (ЮНЕСКО, 2015). Манай улсын хувьд энэхүү зорилгын хүрээнд хүүхдийн нас, хүйс, нийгмийн гарал, оюун ухаан, бие бялдрын ялгаатай байдлыг үл харгалзан цэцэрлэг, сургуульд тэгш хамрагдах эрхийг хүлээн зөвшөөрч, боловсролын тогтолцоогоо сайжруулах бодлогын хүрээнд боловсролын чанар, үр дүнг дээшлүүлж, хүртээмжийг нэмэгдүүлэх хэрэгцээ шаардлага тулгарч байна.

СӨБ-ын сургалтын хөтөлбөрийн хүрээнд тусгай хэрэгцээ шаардлагатай хүүхдийг боловсролд тэгш хамруулан сургах багшийн сэтгэл зүй, хандлагад өөрчлөлт гаргах, хүүхэд нэг бүрийг суралцах тэгш боломжоор хангасан сэтгэл зүйн болон сургалтын орчныг бүрдүүлэх эхлэлийг тавьж, улмаар үйлчилгээний хүртээмж, үр нөлөөг нэмэгдүүлэхэд тодорхой ахиц гарах боломжийг нэмэгдүүлэх зорилгыг тавилаа.

Сургуулийн өмнөх насны тусгай хэрэгцээ шаардлагатай хүүхдийн хөгжлийг дэмжихдээ бие даах, нийгэмшүүлэх, өөрийгөө илэрхийлэх чадвараас гадна сурах хүсэл эрмэлзэлтэй иргэн байхад нь чиглэсэн боловсролын үйлчилгээг эрхэмлэх хэрэгтэй. Хэдий чинээ эрт дэмжинэ, хөгжлийн хоцрогдол, бэрхшээл нь засан сайжрах боломжтой гэдгийг багш бүхэн мэднэ.

“Нийгмийн ямар орчин нөхцөлд байгаагаас тухайн хүүхдийн бэрхшээлтэй эсэх нь хамаардаг. Бусдын хандлага, зан үйлийн ялгаатай байдалд хамаг учир оршиж байгаа юм...” гэж Л.С.Выготскийн хэлсэн санааг бид бүхэн санаж, хүүхэд бүрийнхээ хөгжлийг дэмжин ажиллавал тэдэнд туслах боломж бүрдэж байна.

Тусгай хэрэгцээ шаардлагатай хүүхдийн хөгжлийг хэрхэн дэмжих вэ?

Хүүхэд бүр өөрийн гэсэн онцлог шинж чанар, сонирхол болон сурах хэрэгцээтэй байдаг. Тэгш хамруулах боловсрол нь хүүхэд төвтэй, хүүхдийн боловсролын хэрэгцээнд чиглэсэн нь СӨБ-ын сургалтын хөтөлбөрийн үзэл санаатай яв цав нийцэж байгаа юм.

Багш нар хүүхэд бүрийг ажиглан тэмдэглэсэн баримтдаа үндэслэн хүүхдийн хэрэгцээ шаардлагыг илрүүлж, хүүхдэд тохирсон энгийн хялбар ганцаарчилсан төлөвлөгөө боловсруулж хөгжлийг нь дэмжих зорилт тавин ажиллахдаа хүүхэд уг чадварыг эзэмшиж, бие даан хэрэглэх үед буюу зорилтоо биелүүлсэн хугацааг тэмдэглээд, дараагийн хэрэгцээг тодорхойлж, хөгжүүлэх байдлаар алхамчлан ажиллана.

Бүх насны бүлэг, анги танхимын орчинд, тухайлбал, цэцэрлэгийн хоёр настай хүүхдийн бүлгээс аваад их дээд сургуулийн анги танхимд ч нээлттэй, хүртээмжтэй байдлыг дэмжих хэрэгтэй. Учир нь хүртээмж, идэвхтэй оролцоо гэдэг нь тусгай хэрэгцээтэй бага насны хүүхдийг ердийн цэцэрлэгт зүгээр оруулж, тэнд байлгахад илүү өргөн ойлголт юм. Багш нар янз бүрийн тусгай хэрэгцээтэй хүүхдэд сургалтын орчныг хэрхэн тохируулж, тэднийг уян хатан, бүтээлч байдлаар хичээл, үйл ажиллагаанд бүрэн утгаар, үр өгөөжтэй оролцуулахад анхаарч ажилладаг. (Duncannon-Lahr, 2006)

Багш нарын хүүхэдтэй ажиллах аргаа хөгжүүлэхэд дэмжлэг болох зорилгоор дараах жишээг танилцуулж байна.

АНУ-ын цэцэрлэгийн багш “Б”-ийн тусгай хэрэгцээтэй хүүхэдтэй ажиллаж байгаа бүлгийн жишээг харцгаая. Хэдийгээр Монголын цэцэрлэгийн бүлгийн хүүхдийн тоо нь харьцангуй олон байдаг ч багш “Б”-ийн бүлгийн орчин, бага насны хүүхдэд зориулсан суралцахуй, сургахуйн орчин, агуулга, зохион байгуулалт нь хөгжлийг хэрхэн дэмжиж байгааг харуулсан нэгэн жишээ болж чадах юм. Багш “Б” цэцэрлэгийн багш, 2 жил ажиллаж байгаа. Одоогоор 3-4 насны хүүхдийн бүлгийг хариуцан ажилладаг. Түүний бүлэгт янз бүрийн хөгжлийн түвшинтэй 12 хүүхэд байдаг. 4 хүүхэд нь хэвийн хөгжилтэй, 8 хүүхэд нь хэл яриа, оюун ухаан, аутизм гэсэн хөгжлийн бэрхшээлтэй. “Б”-гийн анги эхнээсээ л бүх хүүхдийн хэрэгцээг хангасан байхаар төлөвлөгдсөн. Өрөө нь цэлгэр том, хэсэг бүр дээр хүүхдийн бие бялдрыг хөгжүүлэх хэрэгсэл бүхий зугаатай орчин бүрджээ. Жишээлбэл:

Сургалтын үеэр хүүхдүүд олноороо байх зориулалттай өрөөнд халтирдаггүй шалавч, хүүхэд хаана суухаа андахгүй мэдэхээр жижиг жижиг хивсэнцэр дэвсжээ. Мөн хуанли, цаг агаар, өдрийн үйл ажиллагаа болон хүүхдийн сонирхлыг татах бусад зүйлийг тавих зориулалттай тавиур байна. Суралцахуйн төвд ширээг тойруулан сандлуудыг тавьсан байхаас гадна хүүхдүүд янз бүрийн байдлаар сууж болох тэдний мэдрэхүйг хөгжүүлэх том том бөмбөгнүүд байна. Ширээний өндрийг хүүхдийн хэрэгцээнд нь тааруулан, сандал болон тэргэнцэрт тохируулж болох ба ширээ бүр өдөр тутмын үйл ажиллагаанд шаардлагатай хэрэглэгдэхүүнийг байрлуулах тавиуртай. Суралцахуйн төв бүрийн үйл ажиллагааны чиглэлийг үгээр болон зургаар хаягласан нь хүүхдүүд тухайн газар юу хийхээ төвөггүй таамаглах сануулга болж, чөлөөтэй бие даан ажиллах боломжийг хангаж чадсан.

Хүүхдүүд өглөө ангидаа ороод хувцас, гутлаа тайлж, өөрийн нэр, зураг бүхий саванд цүнхээ хийнэ. Хүүхэд бүр зургаа аван ангидаа орж хаалган дээр байрлах “Би ирлээ” самбарт тавина. Хөтөлбөрийн энэ долоо хоногийн агуулга нь юмсын ижил ба ялгаатай талыг олоход чиглэж байгаа. Энэ агуулгын хүрээ өргөн, учир нь олон талын өөр өөр ойлголтыг хамруулж болно. Өнөө өглөө 30-40 минутын хоёр үйл ажиллагаатай. Нэг суралцахуйн төвд хүүхдүүд юмсын ижил ба ялгаатай шинжийг олж мэдэхэд чиглэсэн байхад нөгөөд хүүхдүүд ямар нэгэн зүйлтэй ижил, төсөөтэй зүйлийг ангиасаа өөрсдөө эрж олох агуулга суралцахуйн буланд олон өөр агуулгатай хавсарч явагддаг (том ба жижиг, ялгаатай хэлбэр, өнгө гэх мэт). “Б” багш энэ долоо хоногийн хөтөлбөрийн агуулгаар суралцахуйн буланд хүүхдэд юмсын ижил ба ялгаатай шинжийг олж мэдэх чадварыг дэмжих олон төрлийн сонирхолтой үйл ажиллагааг төлөвлөжээ. Хүүхдүүд өөрсдийгөө бусадтай юугаараа ижил, бусдаас юугаар өөр, ялгаатай болохоо мэдэх үйл ажиллагаанд дуртай байдаг. Өөрсдийн биеийг зураг, үг, эд зүйлсээр чимэглэж, өөрсдийгөө ямар онцгой нэгэн болохыг харуулах зэрэг үйл ажиллагааг төлөвлөсөн байна. Хүүхдүүд эдгээр үйл ажиллагаандаа усан будаг, өнгийн харандаа, тодруулагч, даавуун өөдсөн бийр, хайч, цавуу, саа зэргийг ашиглана. “Б” багш үйл ажиллагаагаа төлөвлөх, түүнд хэрэглэх хэрэглэгдэхүүн, арга барилаа сонгохдоо хүүхдүүдийн хараа, сонсгол, хөдөлгөөний бэрхшээлийг харгалзан үзсэн байна. Өдрийн дэглэм, биеийн тамирын өрөөний зохион байгуулалт, үйл ажиллагаа нь хүүхдийн идэвхтэй оролцооны олон хувилбарыг дэмжсэн байна.

Дээрх жишээнд багш тусгай хэрэгцээтэй хүүхдийн онцлогт тохируулан орчноо хэрхэн бүрдүүлж болохыг харуулжээ. Багш тусгай хэрэгцээтэй хүүхдүүдийг сургуулийн өмнөх боловсролд хамруулахдаа дараах ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө боловсруулан ажиллах боломжтой юм.

ГАНЦААРЧИЛСАН СУРГАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө нь тусгай хэрэгцээ шаардлагатай хүүхдийн сурах үйл явцыг удирдах, дэмжих, үнэлэх арга юм. Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөг хийхдээ багш тухайн хүүхдийг ажиглан тэмдэглэж, түүндээ тулгуурлан үйл ажиллагааг зохион байгуулна. Энэ үйл ажиллагааны төлөвлөгөө нь зорилготой, чиглэсэн үйлтэй, түүнийг үнэлсэн үнэлгээтэй байх бөгөөд гарсан үр дүн, үнэлгээнд үндэслэн дараагийн үйл ажиллагааг төлөвлөх нь тухайн хүүхдийн хөгжлийн ахицыг харах боломжийг бүрдүүлнэ.

Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөг хэрхэн боловсруулах вэ?

1. Дөрвөн настай Хандаа саяхан цэцэрлэгт орсон. Тэрээр ихэвчлэн ангийн зах хэсэгт, буланд суух ба номоо нүүрэндээ тулган хардаг, мөн босч явахдаа ширээ мөргөж харагддаг. Хандаа хөдөлгөөн удаан учраас хичээл, үйл ажиллагаанд идэвхтэй оролцож чаддаггүй. Иймд хичээл, үйл ажиллагаанд оролцоходоо бусад хүүхдүүдээс хоцорч байна.

Хандаад ямар бэрхшээл учирч байна вэ?

Нэр: Б.Хандаа

Нас: 4

Бүлэг: Дунд

Огноо: 2018.09.10

Ажиглалтын үр дүн. Хандаа хөдөлгөөн, эрүүл мэндийн хичээлд ороходоо дургүйцдэг. Түүний нүдний хараа муу байж болох юм.

Зорилго: Хандааг хөдөлгөөн, эрүүл мэндийн хичээлд идэвхтэй оролцдог болгох

Үйл ажиллагаа

1. Урд талын эгнээнд багш өөртөө ойр байх боломжийг бүрдүүлэх
2. Багш хөдөлгөөн, эрүүл мэндийн хичээлд гүйх, харайхад нь туслах
3. Ангид хөгжимт дасгал, хөдөлгөөн хийхэд нь дэмжлэг үзүүлэх
4. Багш гэрийнхэнтэй нь уулзаж Хандааг нүдний эмчид үзүүлж харааг нь шалгуулахыг зөвлөх
5. Үеийн найзуудыг нь хичээл, үйл ажиллагаанд оролцоход Хандаад туслахыг зөвлөх

Үйл ажиллагааны үр дүн

- 9 сарын 15 – Хандааг эмчид үзүүлэхэд түүний нүдний хараа муу байсан тул шил зүүхийг эмч зөвлөсөн.
- 9 сарын 25- Ээж нь түүнд тохирох нүдний шил авч өгөв.
- 10 сарын 01- Нүдний шил зүүснээр тэр нүүрэндээ номоо нааж харахгүй болсон ба ширээ мөргөхөө больсон.
- 10 сарын 25- Хандаа хөдөлгөөн, эрүүл мэндийн хичээлд идэвхтэй оролцдог болсон, гэвч хөдөлгөөн, эрүүл мэндийн чадварын үнэлгээ доогуур хэвээр тул түүнд нэмэлт туслалцаа хэрэгтэй байна.

Цаашид багш 10 сарын 25-ны дүгнэлтэд үндэслэн хөдөлгөөн, эрүүл мэндийн ямар чадварын үнэлгээ доогуур гарсантай холбогдуулан төлөвлөгөөг гарган ажиллана.

2. Дэмбэрэл сонсголын бэрхшээлтэй учраас зарим нэгэн зүйлийг буруу сонсох, огт сонсохгүй байх нь хичээл, үйл ажиллагааны явцад ажиглагдлаа. Тэрээр муу сонсдог учраас үгийг буруу хэлж, зарим нэгэн үгийн утгыг ойлгохгүй байдаг учраас багштай болон бусадтай ярилцах нь ховор.

Нэр: Т. Дэмбэрэл

Нас: 5

Бүлэг: Бэлтгэл

Хугацаа: 2016-10-11

Суралцахад тохиолдож буй бэрхшээл: Сонсголын бэрхшээлтэй учраас хэл ярианы хөгжил муу. Бусдад санаа бодлоо илэрхийлж чаддаггүй.

Зорилго	Үйл ажиллагаа	Үнэлгээ дүгнэлт
Бусадтай харилцдаг болоход нь туслах.	<ul style="list-style-type: none"> - Багш өөртэйгөө аль болох ойрхон байлгах - Бүх хичээл, үйл ажиллагаанд багш ганцаарчлан ажиллах 	<ul style="list-style-type: none"> - Багш ганцаарчлан ажилласнаар хүүхдэд ойлгомжгүй байгаа үг, өгүүлбэрийг ойлгуулж, ярилцдаг болсон. - Ангийн хүүхдүүд, найзууд нь хичээл, үйл ажиллагааны явцад үгийг тайлбарлаж тусалдаг болсон.
<p>Дэмбэрэл энгийн үг хэллэгийг сайн ойлгож, хичээл, үйл ажиллагааны явцад юу хийхээ мэддэг болсон ч цаашид өөрийгөө илэрхийлэх, асуулт асуух, асуултанд хариулах чадварыг сайжруулах шаардлагатай байна.</p>		

Дээрх жишээнээс үзвэл, багш хүүхдийнхээ хөгжлийг дэмжих дараагийн зорилго харагдаж байна. Багш ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөг дээрх байдлаар төлөвлөж болох бөгөөд тухайн хүүхдийн онцлог хэрэгцээнд тохируулан зорилго, хийх үйл ажиллагааг тодорхой оруулна. Гэхдээ багшийн хийж буй үйл нь хүүхдийн эзэмших чадварыг дэмжсэн, хичээл, үйл ажиллагаатай уялдсан байхад анхаарах хэрэгтэй.


ГУРАВ. ХҮҮХДИЙН ХӨГЖЛИЙН ҮНЭЛГЭЭ

Бага насны хүүхдийн боловсролын үндэс нь багш хүүхдийн хөгжлийг хэрхэн дэмжин ажиллаж байгаатай салшгүй холбоотой юм. Сургуулийн өмнөх насны (2-5 нас) хүүхдийн хөгжлийн үнэлгээний зорилго нь багш хүүхдийн юу мэдэж, чадаж, сонирхож байгааг болон тэдний хөгжлийн ахиц, өөрчлөлтийн талаар мэдээлэл цуглуулж өөрийн хичээл, хөгжүүлэх үйл ажиллагааг төлөвлөхөд оршдог.

Сургуулийн өмнөх насны хүүхдийн үнэлгээ нь явцын болон үр дүнгийн гэсэн төрөлтэй байх бөгөөд энэ нь багшийн анги дахь хичээл, үйл ажиллагааг төлөвлөх, хүүхдийн хөгжилд дэмжлэг болно. Явцын үнэлгээ нь ажиглалтын тэмдэглэл болон хувийн хавтасыг бүрдүүлэх үйл явцыг ойлгоно. Үр дүнгийн үнэлгээ нь явцын үнэлгээнд тулгуурлан хүүхдийн хөгжлийн байдлыг тогтоон хичээлийн жилийн төгсгөлд ямар үр дүнд хүрснийг тодорхойлно.

Хүүхдийн хөгжлийн үнэлгээ нь дараах циклийн дагуу тасралтгүй явагдах бөгөөд хүүхдийн хөгжлийг дэмжих боломжийг бүрдүүлнэ.

Зураг 3. Хүүхдийн хөгжлийн үнэлгээ



Багш нар үнэлгээний арга, хэрэгслийг ашиглан хүүхдийн хөгжлийн бодит байдлыг тогтоон түүний үндсэн дээр хүүхдэд хичээл, үйл ажиллагааны явцад ямар дэмжлэг үзүүлэх аргагүйгээ төлөвлөн хэрэгжүүлэх замаар хүүхдийн бие бялдар, танин мэдэхүй, нийгэмшихүйн хөгжилд гарч буй өөрчлөлт, ахицыг үнэлнэ.

3.1. АЖИГЛАЛТ

Ажиглана гэдэг нь хүүхдийг, тухайлбал түүний зан харилцаа, бусадтай зохицож буй байдал, оролдлого, тулгарсан асуудлаа давж гарч буй байдал, орчноо нээж таньж мэдэж, ойлгож буй байдлыг илүү эрчимтэй анхаарна гэсэн үг. [Kazemi-Weisari, 2004]

Ажиглалт нь:

- Бусдад мэдээлэл өгөх баталгаа
- Эцэг эхэд мэдээлэл өгөх баримт
- Сургуульд ороход нь мэдээлэл
- Цэцэрлэгийн багшийн чадварыг бусдад таниулна.

Ажиглалтыг хийхдээ багш шаардлагатай нөхцөлийг бүрдүүлэн, тухайлбал, яаж цаг гаргах, эцэг эхтэй хэрхэн холбогдох, хэрхэн зохион байгуулах, ямар ур чадвартай байх зэргийг харгалзан үйл ажиллагааг зохион байгуулах хэрэгтэй. Эцэг эх хүүхдээ ийм байх ёстой мэтээр ойлгох нь бий. Үүнийг багш нар чиглүүлэн тэдэнд зөв мэдээлэл өгөх нь чухал. Ингэхийн тулд юуг ажиглах вэ, мэдээд яах вэ, хэнд хандах вэ, хэрхэн хамтрах вэ гэдгийг олж тогтоон түүнд чиглэсэн шийдвэр гаргахад ажиглалтын тэмдэглэл чухал үүрэгтэй.

Тэмдэглэл гэдэг нь хүүхдийн үйл ажиллагаа, үйлдэл, зан төлөв, сэтгэл хөдлөлийн илэрлийг ажигласнаа бодитой бичих үйл явц. Ажиглалтын тэмдэглэл хийхдээ багш ажиглаж буй үзэгдлийг бодит байдлаар нь (өөрийн байр суурь, үзэл бодол, сэтгэлийн хөдөлгөөнд авталгүй) хүүхэд юу хийж, яаж тоглож, биеэ хэрхэн авч явж, ямар зан ааш гаргаж байгааг ажиглан тэмдэглэж бичнэ. Багш ажиглалтыг өдөр тутам хийх бөгөөд зарим голлох үйл ажиллагаанд юуг ажиглаж болох санааг дор сийрүүлье.

Багш хэзээ, юуг ажиглаж болох вэ?

Багш ажиглалтыг:

- Өдөр тутмын үйл ажиллагаанд оролцож байхад нь (Хувцсаа солих, хоол идэх, цайгаа уух, жагсах, цэцэрлэгтээ ирэх, явах үед хүүхэд Юу хийх ёстойгоо ойлгож байна уу?, Бие даах оролдлого байна уу?, Өөрөө бие даан хувцсаа өмсөж, хооллож чадаж байна уу?, Багшийн командыг ойлгоод жагсаалд зогсож байна уу?, Хүүхэд эцэг эхээсээ холдож цэцэрлэгтээ үлдэж чаддаг уу?, Хүүхэд тухайн үйлийг хийхдээ тайван, хичээнгүй, уцаартай, дургүйцсэн, өөртөө итгэлтэй байсан уу? гэх мэт)
- Хичээл, үйл ажиллагааны явцад нь (хэл яриа, хөдөлгөөн, математикийн төсөөлөл, хөгжим гэх мэт үйл ажиллагааны эхэнд ямар байсан, төгсгөлд хүүхдийн анхны байсан байдал өөрчлөгдсөн үү?, Эхлээд сайн мэдэхгүй мэт байгаад аажмаар сайн хийсэн үү?, Урамшуулаад байсан чинь улам сайн болсон уу?, Хэр хурдан эсвэл удаан тусгаж авч байна вэ?, Идэвхитэй байна уу?, Анхаарал нь төвлөрч чадаж байна уу?, Тогтож анхаарч чадахгүй байна уу?)
- Урлаг, уран сайхны үйл ажиллагаанд оролцож байхад нь (судалж байгаа хүүхдээ ширээний театр, хуруу хүүхэлдэй тоглуулж байх үед нь ажиглахад тэрээр Хэр зэрэг анхаарч байна вэ?, Сэтгэл хөдлөл нь ямар байсан?, Үлгэр, жүжиг тоглуулахад ямар дүр авч байна вэ?, Сэтгэл хөдлөл нь хэрхэн илэрч байсан бэ?, Өөрийн санаа бодлыг яаж бусдад илэрхийлж байсан бэ?, Хүүхэд шинэ санаа гаргахдаа багшийн туслалцааг авч байсан уу? гэх мэт.
- Шинэ зүйл сурч байхад нь (Шинэ зүйлийг хурдан эсвэл удаан тусгаж байна уу?, Юмыг хурдан эсвэл удаан тогтоож байна уу?, Шинэ зүйлийг сурах сонирхол, сониуч зантай юу?, Юмыг сонирхож асууж шалгадаг уу? гэх мэт)

- Зугаалж явах үед нь (Орчны юмс үзэгдлийг сонирхож байна уу?, Харсан зүйлээ багшид буюу бусадтайгаа хуваалцдаг уу?, Асуулт тавьдаг, бодол санаагаа илэрхийлж чаддаг уу?, Зугаалга нь таалагдсан эсвэл сэтгэл хөдлөөгүй гэх мэт)
- Тоглож байхад нь (сэдэвт, төсөлт тоглоом, шагай наадам гэх мэт тоглох үед Ганцаараа тоглохыг эрхэмлэж байна уу?, Хамтран тоглож байна уу?, Бусадтай хамтран тоглох үед биеэ хэрхэн авч явж байна вэ?, Тоглоомоо хуваалцдаг уу?, Тоглох ээлжийг хүлээдэг үү?, Өөрийн бодол санаагаа илэрхийлж чаддаг уу?, Тоглосон тоглоомоо хураадаг уу, үгүй юу? гэх мэт)
- Бусад хүүхэдтэй харилцаж байх үед нь (судалж байгаа хүүхдээ нэг ба хэд хэдэн хүүхэдтэй харилцаж байх үед Бие биетэйгээ хэрхэн харилцсан, нэг нь манлайлж, нөгөө нь дагалдсан уу?, Бусад хүүхэд таны ажиглаж байгаа хүүхэдтэй хэрхэн харилцаж байна вэ?, Бусадтай нээлттэй харилцаж байна уу, Хүүхдийн сэтгэл хөдлөл хэр байсан бэ? гэх мэт)
- Насанд хүрэгчидтэй харилцах үед нь (судалж буй хүүхэд тань насанд хүрэгчидтэй яаж харилцаж байна вэ? Тэднийг сонсож байна уу? Тусламж, дэмжлэг заавар авдаг уу? Өөрт нь хандаж ярихаас бусад үед томчуудад санаачилгаараа ханддаг уу? Ээж, аав, багшид хандах хандлагад нь ямар ялгаа байна вэ?, Хүүхэд багштайгаа ерөнхийдөө ямар байдлаар харилцдаг вэ?, Багш хүүхдэд ямар нэг зүйл санал болгох, туслахад яаж ханддаг вэ? гэх мэт) хийж болно.

Багш ажиглалтын аргыг хэрэглэхдээ юуг анхаарах вэ?

- Ажиглалтын аргыг хэрэглэхэд тавигдах нэг чухал шаардлага бол ажигласан зүйлээ цаасан дээр буулгах (тэмдэглэл хөтлөх) явдал юм. Бодит амьдралаас харахад, ажиглалтын явцад тэмдэглэл хөтлөхөөс тань өмнө үйл явц өрнөж дуусдаг учраас бүтэн өгүүлбэрээр нь тэмдэглэл хөтлөх боломжгүй байдаг. Хурдан, товч тэмдэглэлүүд нь асуудлын хариулт мөн. Гэвч тэдгээр нь ажиглалт явагдаж дуусах үед даруй тэмдэглэж үлдсэн байх ёстой. Эс тэгвээс та өөрийн тэмдэглэлийн утга санаа болон түүнтэй холбоотой баримтыг мартаж болзошгүй.
- Хүүхэдтэй ажиллаад завгүй байх үед үйл явдлыг дөнгөж дууссаны дараа, мартахаасаа өмнө тэмдэглэж болно. Зарим тохиолдолд үйл явдлын өмнөх болон дараагийн агшныг тэмдэглэх хэрэгтэй байдаг [Жанет Гонзалис–Мина, 2018]
- Багш үзэгдлийг (хүүхдийн гаргаж байгаа зан авир, зурж дүрсэлж байгаа байдал, ярих чадвар гэх мэт) харж ажиглахын зэрэгцээ түүний тухай бодож эргэцүүлэхийг шаарддаг. Тухайлбал: Яагаад хүүхэд зөрүүдлэх болов, энэ нь яагаад олон удаа давтагдаж байна вэ? Ямар учир шалтгаанаас үүдэв? гэж эргэцүүлэх хэрэгтэй. Тухайн хүүхдийн зан ааш танд төвөг удаж байвал Энэ зан чанар юуг илэрхийлж байна вэ? гэж өөрөөсөө асууж болох юм.
- Ажиглах явцдаа гэрэл зураг авч, видео, аудио бичлэг хийж болно. Харин багш түүнийгээ хэлэлцүүлэг, илтгэл тавихад ашиглах бол эцэг эхээс нь зөвшөөрөл авсан байх шаардлагатай. Бичлэгийг ашиглахад учир бий. Аль нэг хүүхэд түрэмгүй, эвгүй зан авир гаргаж байгааг харуулсан бичлэгийг олон эцэг эх, хүмүүст үзүүлэх нь тохиромжгүй, харин хүүхдүүд хамтаараа тоглож байхад тухайн хүүхэд тоглоомоо эвдлээд бусдыг шоглоод байгааг ээж аавд нь харуулахын тулд ашиглаж болно.
- Ажиглалтын тэмдэглэлийг бичихдээ хэнийг, хэзээ, хаана, ямар үед, юуг ажигласныг тодорхой бичнэ. Огноо, байршил, орчин нөхцөл, байлцсан хүмүүс гэх мэт. Ялангуяа ажигласан он, сар, өдрийг тэмдэглэх нь хүүхдийн өсөлт, хөгжилд гарч буй өөрчлөлт, ахицыг үнэлэхэд чухал баримт болдог.

Ажиглах үйл ажиллагаа нь хичээлийн жилийн туршид олон удаа давтагддаг. Ажиглалтыг хийхдээ багш өөрийн эзэмшсэн арга, аргачлалаар мэдээллийг цуглуулж баримтжуулах боломжтой бөгөөд ажиглалтын аргын дараах хувилбараас санаа авч болно.

Хувилбар 1. Ажиглалтын явц, үзэгдлийг тэмдэглэх, дүгнэх

№	Огноо	Ажигласан зүйлийн талаарх тэмдэглэл	Дүгнэлт
1	05/10	Нацагдорж дүрслэх урлагийн төвөөс цаасны цавуу тоолж аваад, “- багшаа манай ширээнд 6 хүүхэд сууж байгаа, энд 5 ширхэг цавуу байна. 1 цавуу дутаад байна” гэж хэлэв.	Өөрийн санаа бодлоо чөлөөтэй илэрхийлж чаддаг, хийх үйлээ зөв сонгож оролцдог, хөдөлгөөнтэй, аливаа үйлд идэвхитэй байж бусад хүүхдүүдийг сайн идэвхижүүлдэг.
		Нацагдорж хоолны дараа аяга хураагаад алчуураар ширээ арчингаа “- би бүгдийг нь арчина шүү багшаа” гэж хэлээд бүх ширээг ганцаараа арчиж дуусгаад сандлаа авч цааш явлаа	5, 6-ийн тоог мэдэж яриандаа хэрэглэж байна. Найзтайгаа эвтэй, зохицон тоглож чаддаг.
2	05/14	Нацагдорж биеийн тамирын хувцсаа өмсчихөөд анги тойрон гүйж байснаа “-Хүүхдүүд ээ, та нар яасан удаан өмсдөг юм бэ? “гэж хэллээ.	Хийж буй ажлаа дуустал нь өөрөө хийдэг сайн талтай байна.
		Бат-Оргил, Нацагдорж хоёр ангид байгаа бүх сандлыг тойруулан тавьж байгаад голд нь орж суугаад шагай асгаж, морь уралдуулж тоглов.	Нацагдоржийн бусдыг идэвхжүүлдэг сайн талыг дэмжин бусад хүүхдэд дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааг төлөвлөх хэрэгтэй байна гэж үзлээ.

Хувилбар 2. Ажиглалтын явц - зан үйлийн давтамжийг илрүүлэх

Тухайн үйл ажиллагааны нэр	Сургалтын үйл ажиллагааны явцад (Тодорхой хугацаанд сургалтын үйл ажиллагаанд хэр идэвхтэй байсан, хэдэн удаа асуултад хариулсан, хэр олон удаа сургалтын дундуур босч явсан)		
Огноо	Ажиглалтын хугацаа	Давтамжийн тэмдэглэгээ	Нийт
2019.05.10	10:00-10:30	+ + + +	4
.....
.....
Дүгнэлт	30 минутад 6 удаа = 7 мин 1 удаа идэвхтэй үйл ажиллагаанд оролцож байна гэх мэт.		

Ажиглалтын мэдээлэл цуглуулах аргачлалыг боловсруулахдаа тухайн ажиглахаар зорьж буй зүйлийнхээ талаар цуглуулах хамгийн чухал мэдээлэл нь тухайн зүйлийн давтамж (хэр олон удаа), үргэлжлэх хугацаа (хэр удаан), эрч хүч зэргийг анхаарах нь зүйтэй юм. Тухайлбал, тухайн ажиглагдаж буй зүйл тогтмол давтагддаг бол цаг хугацааны дамтамж илүү чухал байж болох юм. Эсвэл багш хүүхдийн тодорхой нэг зан үйлийн илрэлийг зүгээр тоолох, дүн тоог гаргах аргыг хэрэглэж болно.

Гэхдээ дан ганц ажиглалтын тэмдэглэлээр хүүхдийн хөгжлийн онцлогийг бүхэлд нь тодорхойлох боломжгүй учир бусад арга хэрэгсэл (*хувийн хавтас, үр дүнгийн үнэлгээний хуудас*)-тэй хослуулан хэрэглэхийг зөвлөж байна.

3.2. ХУВИЙН ХАВТАС

Үнэлгээний нэг хэрэгсэл нь хувийн хавтас юм. Хүүхдийн хөгжлийн явцын үнэлгээг илүү өргөжүүлэх, ажиглалтын үр дүнг баримтжуулах зорилгоор багш нар бүлгийн хүүхэд бүрт хувийн хавтас бүрдүүлж ажилладаг. Зорилго нь хүүхэд сургалт, үйл ажиллагааны үр дүнд ямар амжилтад хүрсэн, юу чаддаг болсон, сурч мэдсэн зүйлээрээ бахархах, тэдгээрийн тухай мэдээллүүдийг бусдад ярих, тайлбарлах, өөрийгөө үнэлэхэд оршино.

Хувийн хавтсыг юунд ашиглах вэ?

Хүүхдийн хөгжлийн ахицыг бодитой тодорхойлох

Хүүхэд бүрийн амжилтын үр дүн, суралцахуйд гарч буй ахиц, суралцахдаа гаргаж буй идэвх, санаачилгыг харуулах зорилготой тодорхой үйлүүдийн үр дүнгийн цуглуулга байна.

Хүүхдийн бүх талын хөгжлийг олон янзын эх сурвалжид тулгуурлан дүгнэх

Хүүхдийн хувийн хавтсанд байгаа баримтаас тухайн хүүхдийн талаар ямар үйлд оролцож байсан, түүний үзсэн музей, аялалаар явсан тухай, өдөрлөг, өглөөлөгт ямар дүр бүтээж оролцсон, найздаа хэрхэн тусалсан, зурж, бүтээсэн бүтээл гэх мэт тухайн хүүхдийн хөгжлийн ахиц, өөрчлөлтийн нотолгоо болж, хүүхдийн талаар илүү их мэдээллийг шууд авч болохоор бүрдүүлсэн байна.

Хүүхэд өөрийгөө дүгнэх

Хүүхэд өөрөө шинээр сурсан, мэдсэн зүйлээрээ бахархах, тэдгээрийн тухай мэдээллүүдийг бусдад ярих, тайлбарлах, өөрөөрөө бахархаж үнэлэх сэдлийг төрүүлэхэд оршино.

ХУВИЙН ХАВТАС БҮРДҮҮЛЭЛТИЙН ЖИШЭЭ

Хувийн хавтасны бүрдэл хэсэг нь тухайн цэцэрлэгийн үзэл баримтлал, сургалтын хөтөлбөрийн онцлог, багшийн үйл ажиллагааны онцлогоос хамаарч өөр өөр байж болно.

Жишээ 1: Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн 104 дүгээр цэцэрлэг заах аргын нэгдлээрээ хэлэлцэж өөрийн цэцэрлэгийн хүүхдийн хувийн хавтсын бүрдлийг томъёолсон. Үүнд: *Миний бүтээлүүд, Миний бичсэн зүйлс, Миний зохиосон ном, Миний зургийн цомог, Миний хувийн цуглуулга, Миний сурсан дуу, шүлэг, Миний амжилт, Соронзон хальс, бичлэг* гэх мэт.

Жишээ 2. Нийслэлийн Баянзүрх дүүргийн 32 дугаар цэцэрлэгийн тухайд, *Энэ бол би, Энэ бол манай гэр бүл, Миний онцлог өдөр, үйл явдлууд, Би үүнийг чадна, Би үүнийг хийсэн, Миний сонирхдог зүйлс, Багшийн тэмдэглэл* гэх мэтээр хувийн хавтсын бүрдэл хэсгүүдийг томъёолон хэрэгжүүлж байна.

Жишээ 3.

Хүүхдийн хувийн хавтсанд хийхээр сонгож авсан зүйлс нь хүүхдийн хөгжлийн явцыг тодорхой харуулсан байна.

Жишээ нь:

- *Хүүхдийн бүтээл*

Багш тухайн хүүхдийн бүтээлүүдийг төрлөөр нь ялгаж, материалууд дээр хүүхдийн нас, сар(он, сар, өдөр) тайлбарыг бичиж, цаг хугацааны дарааллаар нь байрлуулсан баяжуулна.

Мөн хувийн хавтсанд хийж буй бүтээлүүд нь тухайн хүүхдийн ахисан түвшнээр баяжигдаж байна.

- *Хүүхдийн хөгжлийн онцлогийг харуулсан гэрэл зураг*

Тухайн хүүхдийн хөгжлийн нотолгоо болох мэдээлийг гэрэл зургаас харж болно. Мөн тухайн зурагт хүүхдийн нас, сар (он, сар, өдөр), тайлбарыг бичиж, цаг хугацааны дарааллаар нь байрлуулан баяжуулна.

Б.А 4 нас 6 сартай “Хүнсний ногоо” сэдэвт ажлын хүрээнд төмс арилгах ажилд их сайн, хичээнгүй оролцож, хүүхдүүд төмсөө арилгаж дууссаны дараагаар ширээгээ нямбайлан цэвэрлэж, хэрэглэж байсан зүйлээ хурааж тавьсан.

- *Хүүхдийн сонирхдог зүйлс, хувийн цуглуулага*

Хүүхдийн сонирхдог зүйлийг илрүүлэхдээ гэртээ цуглуулдаг тоглоом, үзэх дуртай кино зэргийг эцэг эхээс мэдээлэл авч, сонирхдог зүйлийг нь дагуулан ажиглалт хийж тэмдэглэл хөтөлж болно. **Жишээ нь:**

“БГД-ийн 87-р цэцэрлэгийн Н.Ц хүүхэд гэртээ “Мөнгөн дэвсгэрт” цуглуулдаг.

Түүнийг ангидаа тоглож байх үед багш ажиглалт хийхэд дэлгүүр сэдэвт тоглоом дээр худалдагч болж тоглоод цээжээрээ 20-ын дотор тоог нэмж, хасаж бодож чадаж байсан. Мөн мөнгөн дэвсгэртийг төвөггүй ялган таньж, хүүхдүүдэд хариултыг цээжээр бодон өгч байна” гэх мэт багш тухайн хүүхдийн сонирхолыг дагуулан судалж үзвэл илүү их мэдээлэл олж авна.

- *Хувийн хавтасны баримт мэдээлэл нь хүүхдийн хөгжлийн ахицыг үнэлэх хуудсанд тэмдэглэж, үнэлгээ хийх үндэслэл болж өгнө.*

Хүүхдийн хувийн хавтсанд байгаа баримтаас тухайн хүүхдийн оролцож байсан үйл, зурж бүтээсэн бүтээл, үзсэн музей, аялалаар явсан тухай, өдөрлөг, өглөөлөгт ямар дүр бүтээж оролцсон, найздаа хэрхэн тусалсан гэх мэт мэдлэг, оролцоо, хандлагын мэдээллийг шууд авч болох юм. Багш хүүхэд бүрд хувийн хавтас бүрдүүлэн ажилласнаар тэдэнд гарч буй ахиц, өөрчлөлт, хөгжлийг олж мэдэх, **багш – хүүхдийг, эцэг эх - хүүхдээ, хүүхэд – өөрийгөө** танин мэдэж, хийсэн зүйлээрээ бахархаж үнэлэх сэдлийг төрүүлэх, хүүхдийн хэрэгцээ шаардлагыг зөв тодорхойлж, хувийн онцлогт нь тохируулан хичээл, үйл ажиллагааны төлөвлөгөөг гаргах, багш өөрийнхөө ажлын ололт амжилт, алдаа дутагдлыг олж харах, цаашид хийх ажлынхаа чиглэлийг тодорхойлох, хүүхдийн талаарх мэдээлэл шууд харж болох боломжийг олгодгоороо ач холбогдолтой.

Хувийн хавтас бүрдүүлэхэд юуг анхаарах вэ?

- Багш нар хүүхдийн хувийн хавтасны бүрдэл хэсгүүдийн тэнцвэртэй байдлыг харгалзан үзэж баяжуулах нь чухал. Яагаад гэвэл дээрх зураг дээр харуулсан үзүүлэлт харилцан адилгүй байгааг анзаарч ажиллах нь хэрэгтэй.
- Суралцаж, хөгжиж байгаагаа баримтжуулахад хүүхэд идэвхтэй оролцогч байна. Өөрөөр хэлбэл хүүхэд өөрөө хувийн хавтсаа хэрэглэдэг, түүнээс өөрийнхөө суралцаж хөгжиж байгааг мэдэрдэг, эцэг эх оролцож дэмждэг, хүүхдийн хөгжлийн талаарх бодит мэдээллийг авдаг байх нь чухал юм.
- Хувийн хавтасны материалуудад хүүхдийн нас, сар (он, сар, өдөр), тайлбарыг заавал бичиж, цаг хугацааны дарааллаар нь байрлуулна.
- Хувийн хавтасны мэдээллүүд нь хүүхдийн хөгжлийн ахицыг харуулах бөгөөд **ажиглалтын** тэмдэглэлтэй харьцуулан ашиглана.

3.3. ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС

Үр дүнгийн үнэлгээний хуудас нь хөгжлийн түвшин бүрээр байх бөгөөд багш зөвхөн өөрийн бүлгийн хүүхдэд тохирох түвшний хуудсыг ашиглана. Тэмдэглэгээ хийхдээ суралцахуйн чиглэл бүрийн эзэмших чадварыг хэрхэн эзэмшиж байгааг “чадаж байна”, “хараахан чадахгүй байна”, “чадахгүй байна” гэсэн гурван шалгуурын дагуу ажиглалтын тэмдэглэл болон хувийн хавтас дахь баримт, материалд тулгуурлан тэмдэглэл хийнэ. Тус үнэлгээгээр “хараахан чадахгүй байна”, “чадахгүй байна” гэсэн тэмдэглэлд байгаа хүүхдийг “чадаж байна” гэсэн шалгуурт чиглүүлэн хичээл, үйл ажиллагааг төлөвлөн ажиллана.

Багш, үр дүнгийн үнэлгээний хуудсанд тулгуурлан төлөвлөсөн хичээл, үйл ажиллагаа нь хүүхдийн хөгжлийг дэмжиж тэдний нийгэмшихүй, бие бялдар, танин мэдэхүйн хөгжилд бодитой хувь нэмэр оруулах хэрэгсэл байна. Үр дүнгийн үнэлгээний хуудасны тусламжтайгаар багш тухайн хүүхдийн хөгжлийн ахиц, өөрчлөлтийг харахаас гадна бүлгийн бүх хүүхдийн хөгжлийн ахицын дүр зургийг харж болно. Энэхүү үр дүнгийн үнэлгээний хуудас нь багшийн хичээл, үйл ажиллагаагаа төлөвлөх, хүүхдийн хөгжлийг хөтлөх баримт бөгөөд багшийн ажлын чиглэл болно.

Багш ажиглалт болон хувийн хавтаст үндэслэн үнэлгээний хуудаст тэмдэглэл хийх ба тухайн тэмдэглэлийг хүүхэд нэг бүрийн болон бүлгийн бүх хүүхдийн үнэлгээг нэгтгэн харж дүгнэлт хийнэ. Үүнд үндэслэн тухайн хүүхдийн хөгжлийн аль талыг дэмжих, хэрхэн ажиллах төлөвлөгөөг боловсруулах юм. Багш хүүхэд бүртэй ажиллахаас гадна хүүхэд бүрийн онцлогт тохируулан ажиллахад анхаарах хэрэгтэй.

Үнэлгээний хуудсанд суралцахуйн чиглэлээр нэг асуултад хэд хэдэн чадварыг үнэлэх хэрэг гарна. Тухайлбал, хөдөлгөөн эрүүл мэндийн чиглэлээр бөмбөгийг дамжуулах, дээш шидэх, барьж авах, эсвэл саадыг давж мөлхөх, өндөрлөг зүйл дээр авирч гарах, давж буух гэх мэт. Хэрэв хүүхэд тань эдгээр чадварыг бүгдийг хийж байгаа тохиолдолд “чадаж байна”, заримыг хийж байгаа тохиолдолд хараахан чадахгүй байна, бүгдийг хийж чадахгүй бол “чадахгүй байна” гэж үнэлнэ. Багш үр дүнгийн үнэлгээний хуудсанд тухайн чадварын хэчнээн хувийг эзэмшсэн байдалд үндэслэн дүгнэлт хийнэ.

Ном зүй:

1. Крайг, Г, Психология развития (Мастер психология) 7-е международное издание, Питер, Москва, 2000, стр.15
2. Gonzalez-Mena (Жанет Гонзалес-Мина), *Соёлын баялаг, ялгаатай орчинд багшлах нь, хуудас 25*
3. Prof.Dr.WassiliosE.Fthenakis, *KindlicheEntwicklungko-konstruktiv stärken, Stadt*
4. Leipzig, am 13.Maerz, 2015, Fthenakis_Kindliche_Entwicklung_klein.pdf
5. Алтансүвд, Л, Бага насны хүүхдийн математикийн энгийн төсөөллийг хөгжүүлэх арга зүй, Тэнгэр бага тур хэвлэлийн газар, Улаанбаатар, 2012 он, хуудас 100-104.
6. Тусгай хэрэгцээт боловсролын үндэс, 2018 он, хуудас 115
7. Лхагвасүрэн, Д., “Боловсрол судлалын судалгааны арга”, 2010 он
8. Kazemi-Veisari, *Kindergarten heute*, 2004, Herder Verlag

Зөвлөмж эмхэтгэн боловсруулсан:

Н.Норжхорлоо (Ph.D)	Багшийн мэргэжил дээшлүүлэх институтын зөвлөх
Д.Сарантуяа	Боловсролын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан
Г.Монголхатан	Боловсролын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан
Ж. Батдэлгэр (Проф)	МУБИС, СӨБС-ийн Сургалт, судалгааны төвийн эрхлэгч
Б.Даваасамбуу	БЗД-ийн 32-р цэцэрлэгийн арга зүйч
Л.Ууганбаяр	БЗД-ийн 268-р цэцэрлэгийн эрхлэгч
Б.Баяртуяа	БГД-ийн 30-р цэцэрлэгийн эрхлэгч
О.Одончимэг	СБД-ийн 225 дугаар цэцэрлэгийн эрхлэгч
Ж.Мөнхнасан	БГД-ийн “Бяцхан эрдэмтэн” цэцэрлэгийн эрхлэгч